ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2021 №4 (78)
19 дэх жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237
ISBN 978-99929-62-31-3

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D)

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ	*С.Гантулга* *Ж.Мөнхболд*	5
Гэмт хэргийн хяналтын “Compstat” цогц системийн үүсэл, хөгжил	*Ж.Эрдэнэболд*	34
Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам	*Б.Батбаяр*	47

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гадаадын зарим улсын Эрүүгийн хуульд хуульчилсан байдал, харьцуулсан судалгаа	*Г.Гантөмөр*	52

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Эрүүгийн процессын мөрдөн байцаалт: Харьцуулсан судлал, агуулга, мөн чанар	*Н.Манлайбаатар*	60
Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал	*Т.Болор-Эрдэнэ*	68

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Цагдаагийн тоо бүртгэлд хүний дүр төрх судлалыг ашиглаж ирсэн нь	*Г.Бямбадорж*	76
Зам тээврийн ослын гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам	*Б.Зоригтбаатар*	81

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийн шинэчлэлт, өөрчлөлтийн талаарх харьцуулсан судалгаа	*Т.Сосорбарам*	88

ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

The Relationship Between Eu Law And International Law-Autonomy Versus Völkerrechtsfreundlichkeit	*Namsrai Battulga*	102

СУДЛААЧИЙН БАЙР СУУРЬ

Орон нутгийн сонгуулийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт судалгаа	*А.Мөнхцэцэг* *Ц.Түвшинбаяр*	111
Гэр бүлийн насанд хүрээгүй хүний эд хөрөнгийн эрх: Онол, практик	*Д.Батчимэг*	118
Цахим орчин дахь залилах гэмт хэргийн нөхцөл байдал, шийдвэрлэх арга зам	*Б.Алтанцэцэг*	124
Дижитал шилжилт гэмт хэргийн гаралтад нөлөөлөх нь	*Б.Наранхүү*	130

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДААС ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

С.Гантулга
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа
Ж.Мөнхболд
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа

2010-2020 онд хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн, хохирсон шүүхийн шийтгэх 37 тогтоолыг түүвэрлэн авч дүгнэлт хийсэн. Шүүхийн шийтгэх тогтоолуудыг судлан үзэхэд 42 хэрэгт 42 хилийн цэргийн алба хаагч шүүгдэж, 26 хилийн цэргийн алба хаагч гэмт хэргийн улмаас хохирсон байна.

Судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэн боловсруулсан болно.

1) Үйлдсэн гэмт хэрэг

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн, хохирсон 37 хэргийн шүүхийн шийтгэх тогтоолыг авч үзвэл, 2002 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн 10 төрлийн 26 гэмт хэрэг, 2015 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн 12 төрлийн 16 гэмт хэрэг, нийт 42 гэмт хэрэг байна. Эдгээр нь:

- Цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг 7 буюу 16.6 хувь,
- Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих гэмт хэрэг 6 буюу 14.2 хувь,
- Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг 5 буюу 11.9 хувь,
- Хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 4 буюу 9.5 хувь, Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих гэмт хэрэг 3 буюу 7.1 хувь,
- Хүнийг алах болон хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл санаатай учруулах, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших, захирагчийг заналхийлэх, эсэргүүцэх, хүч хэрэглэх, харуулын албаны журам зөрчих, хууль сахиулагчийг эсэргүүцэх, автотээврийн хэрэгслийг авч зугтаах, хүчиндэх, залилах, хөрөнгө завших, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих, автотээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах гэмт хэрэг 1 буюу тус бүр 2.38 хувийг эзэлж байна. (График №1)

Эндээс үзэхэд, хил хамгаалах байгуулллагын алба хаагчид зөвхөн цэргийн албаны эсрэг гэмт хэргээс гадна хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зэрэг олон төрлийн гэмт хэргийг үйлдсэн байгаа нь анхаарал татаж байна.

График №1 Үйлдсэн гэмт хэргийн төрөл, тоогоор



Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн гэм буруугийн хэлбэрээр нь авч үзвэл:

- 38 гэмт хэрэг хэрэг буюу 90.4 хувь нь санаатай,
- гэмт хэрэг буюу 7.1 хувь нь болгоомжгүй,
- 1 гэмт хэрэг буюу 2.3 хувь нь гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгдсэн байна. (График №2) Тухайлбал, Өмнөговь аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн харуулын дарга Харуулын албаны журам зөрчсөний улмаас байлдагч угаартаж нас барсан[1] хэргийг гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдсэн байж болохоор байна.

Ийнхүү цэргийн алба хаагч өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсч үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэж гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэж байгаа нь анхаарал татаж байна.

Харин болгоомжгүй гэмт хэрэг нь Байлдааны галт зэвсэг, галт хэрэгсэлтэй харьцах журам зөрчсөний улмаас цэргийн алба хаагчийн амь нас хохирсон, эрүүл мэндэд гэмтэл учирсан гэмт хэрэг байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн заставын байранд байлдагч Г байлдагч Ө-г дохионы буугаар буудаж, эрүүл мэндэд хүнд гэмтэл болгоомжгүйгээр учруулсан[2], Завхан аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн байлдагч А нь хилийн манааны ахлагчийн шийдвэргүйгээр дур мэдэн АКМ буундаа магазинтай байлдааны сум угсарч, буудлага үйлдсэнээр хамт харуулын үүрэг гүйцэтгэж байсан байлдагч Г-г буудаж, эрүүл мэндэд хүнд гэмтэл болгоомжгүйгээр учруулсан[3], Өмнөговь аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн харуулын дарга байлдааны галт зэвсгээ цэвэрлэж байгаад байлдагчийг буудаж, эрүүл мэндэд хүнд гэмтэл болгоомжгүйгээр учруулсан[4] байна.

Иймд байлдааны галт зэвсэг, галт хэрэгсэлтэй харьцах журмыг чанд мөрдөж ажиллах, журмын хэрэгжилтэд хяналт тавих, алба хаагчдын сахилга, хариуцлага, галт зэвсэг, хэрэгсэлтэй харьцах ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

График №2 Үйлдсэн гэмт хэргийн гэм буруугийн хэлбэр, тоогоор

Гэмт хэргийн ангилалын хувьд авч үзвэл:

- 22 гэмт хэрэг буюу **52.3 хувь нь хүндэвтэр** гэмт хэрэг,
- 14 гэмт хэрэг буюу **33.3 хувь нь хөнгөн** гэмт хэрэг,
- гэмт хэрэг буюу **7.1 хувь нь тус бүр хүнд, онц хүнд** гэмт хэрэгт хамаарч байна. (График №3)

[1] Өмнөговь аймаг дахь Сум дундын шүүхийн 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 59 дүгээр шийтгэх тогтоол

[2] Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүхийн 2011 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 19 дүгээр шийтгэх тогтоол

[3] Завхан аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхийн 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 4 дүгээр шийтгэх тогтоол

[4] Өмнөговь аймаг дахь Сум дундын шүүхийн 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 5 дугаар шийтгэх тогтоол

График №3. Үйлдсэн гэмт хэргийн ангилал, тоогоор



Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн 42 гэмт хэргийн 39 буюу 92.8 хувийг ганцаараа, 3 гэмт хэрэг буюу 7.2 хувийг бүлэглэж үйлдсэн байгаа (График №4) нь хил хамгаалах байгууллагын алба хаагчид санаатай нэгдэж, бусадтай бүлэглэн гэмт хэрэг үйлдэх сэдэлгүй байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд цэргийн алба хаагч нь энгийн иргэдтэй бүлэглэж, бусдын малыг завшсан[5], хугацаат цэргийн алба хаагчид бүлэглэн цэргийн албанаас оргон зайлж, бусдын автотээврийн хэрэгслийг авч зугтаасан[6], захирагчид хүч хэрэглэх[7] гэмт хэргийг тус тус бүлэглэж үйлдсэн байна.

График №4 Гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр, тоогоор

Гэмт хэрэг үйлдэх үе шатаар авч үзэхэд, 41 гэмт хэрэг буюу 97.6 хувь нь төгссөн, 1 гэмт хэрэг буюу 2.4 хувь нь төгсөөгүй гэмт хэрэг /завдалт/ байна. (График №5) Дорноговь аймгийн Хилийн цэргийн дугаар ангид хамт алба хаадаг эмэгтэйг хувийн сэдэлтээр алахыг завдсан[8] гэмт хэргээс бусад гэмт хэрэг төгссөн байна.

Энэ нь цэргийн албаны эсрэг зарим гэмт хэргийг хэлбэрийн шинжтэйгээр буюу үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүйгээр хуульчилсантай холбоотой байх боломжтой.

График №5 Гэмт хэрэг төгссөн байдал, тоогоор



[5] Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар шийтгэх тогтоол

[6] Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 53 дугаар шийтгэх тогтоол

[7] Өмнөговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн шүүхийн 2011 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 63 дугаар шийтгэх тогтоол

[8] Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 62 дугаар шийтгэх тогтоол

2) Шүүгдэгчийн хувийн байдал

Шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох нь тухайн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход ач холбогдолтой. Иймээс судалгааны хүрээнд түүвэрлэн авсан 37 шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгүүлсэн ялтны хүн ам зүйн шинжийг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн хүний нийтлэг шинжийг харьцуулан судаллаа.

Шүүгдэгчийн насны байдлыг авч үзвэл:

- 18 насны 3 буюу 7.1 хувь,
- 19-20 насны 6 буюу 14.2 хувь,
- 21-22 насны 7 буюу 16.6 хувь,
- 23-24 насны 9 буюу 21.4 хувь,
- 25-26 насны 4 буюу 9.5 хувь,
- 27-28 насны 3 буюу 7.1 хувь,
- 29-30 насны 4 буюу 9.5 хувь,
- 31 ба түүнээс дээш 6 буюу 14.2 хувийг тус тус эзэлж байна. (График №6)

График №6 Шүүгдэгчийн нас[9], тоогоор



Үүнээс үзэхэд, ихэвчлэн 18-24 насны цэргийн алба хаагчид гэмт хэрэг үйлдэж байгаа нь харагдаж байна. Гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчдын хамгийн залуу нь 18 настай бол хамгийн ахмад нь 41 настай алба хаагч байна.

Хүн нас ахих тусам биеэ барих, аливаа асуудлын эрх зүйн үр дагаварыг урьдчилан тооцоолж, түүнээс зайлсхийх чадвар нэмэгддэг. Тиймээс 18-24 насны цэргийн алба хаагчид гэмт хэрэг харьцангуй их үйлдсэн байгаа нь энэ насныхан зан төлөвийн хувьд бүрэн төлөвшөөгүй, биеэ барих чадваргүй байдагтай холбоотой байна.

Шүүгдэгчдийн хүйсийн харьцааг авч үзвэл, гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 40 буюу 95.2 хувь эрэгтэй, 2 буюу 4.8 хувь нь эмэгтэй байна. (График №7) Гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчдын цөөн хувийг эмэгтэй алба хаагч эзэлж байгаа боловч гэмт хэрэг үйлдсэн 2 эмэгтэй алба хаагч хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, бусдын эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулсан нь анхаарал татаж байна. Тухайлбал, хилийн цэргийн дугаар ангид холбоочин ажилтай эмэгтэй нь өмнө нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон атлаа дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн[10], дугаар ангийн хүн эмнэлгийн албаны дарга ажилтай эмэгтэй нь гэр бүлийн хардалтын улмаас бусдыг хүүхдийнх нь өмнө догшин авирлан зодож, өмнөө сөгдүүлж, уучлал гуйлгасан[11] байна.

[9] Цэргийн алба хаагчидтай хамтран гэмт хэрэг үйлдсэн энгийн иргэдийг хасч тооцов.
[10] Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 206 дугаар шийтгэх тогтоол
[11] Дорноговь аймгийн Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 49 дүгээр шийтгэх тогтоол

График №7 Шүүгдэгчийн хүйс, тоогоор

Шүүгдэгчдийн боловсролын байдлыг авч үзвэл:

- Дээд боловсролтой 11 буюу 26.2 %,
- Бүрэн дунд боловсролтой 24 буюу 57.1 %,
- Бүрэн бус дунд боловсролтой 3 буюу 7.1 %,
- Бага боловсролтой 2 буюу 4.7 %,
- Боловсролгүй 2 буюу 4.7 хувийг тус тус эзэлж байна. (График №8)

График №8 Шүүгдэгчийн боловсролын түвшин, тоогоор



Үүнээс үзвэл, бүрэн дунд, дээд боловсролтой хүн хамгийн их гэмт хэрэг үйлдсэн байгаа бол, бүрэн бус дунд болон бага боловсролтой эвэл боловсролгүй хүмүүс гэмт хэрэг үйлдэх нь харьцангуй бага байна. (График №9)

Иймээс цэргийн алба хаагчид гэмт хэрэг үйлдэх нь боловсролын түвшинтэй шууд холбоотой гэж дүгнэж болохооргүй байна.

Шүүгдэгчийн мэргэжлийн байдлыг авч үзвэл:

- буюу 7.1 хувь нь автомеханик,
- буюу 4.7 хувь нь хилийн алба, жолооч, хүний их эмч, гагнуурчин, эрх зүйч, сантехникч, 1 буюу
- 2.3 хувь нь хөгжимчин, хөгжмийн удирдаач, ар талын эдийн засагч, цахилгаанчин, холбоочин, нохой сургагч, нягтлан бодогч, бизнесийн менежмент мэргэжилтэй,
- 20 буюу 47.6 хувь нь мэргэжилгүй байна.

Дүгнэн үзвэл, тодорхой мэргэжил эзэмшээгүй алба хаагч гэмт хэрэг ихэвчлэн үйлдэж байна гэж дүгнэж болохоор байна.

График №9. Шүүгдэгчийн мэргэжил, тоогоор



Шүүгдэгчдийн цэргийн албаны төрлийг авч үзвэл:

- 8 буюу 19 хувь нь офицер,
- 13 буюу 31 хувь нь ахлагч,
- 5 буюу 12 хувь нь гэрээт хилчин,
- 16 буюу 38 хувь нь хугацаат цэрэг байна. (График №10)

Дээрх дүн мэдээ нь ахлагч, хугацаат цэргүүд гэмт хэрэг ихэвчлэн үйлдэж байгааг дахин баталж байгаа учир гэмт хэргээр урьдчилан сэргийлэх ажлыг хугацаат цэрэг, ахлагчид рүү чиглүүлэн, тэднийг харилцаа, хандлага, ёс зүй, сэтгэл зүйн сургалтад хамруулах нь шаардлагатай байна.

Цаашид улсын хил хамгаалалтад гэрээт цэргийн алба хаагчдын түлхүү ашиглах нь энэ салбарт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой.

График №10 Шүүгдэгчийн цэргийн албаны төрөл, тоогоор



Шүүгдэгчдийн 16 буюу 38 хувийг хилчин байлдагч, 8 буюу 19 хувийг харуулын дарга эзэлж, үлдсэн хувийг бусад албан тушаалтан эзэлсэн байна. Үүнээс үзэхэд, харуулын дарга, хилчин байлдагчид гэмт хэрэг үйлдэх нь их байна. (График №11)

Хил хамгаалах байгууллагад эмч, нохой сургагч, сургалт, биеийн тамирын ажилтан, хөгжмийн салааны удирдаач, боксын тамирчин зэрэг ажилтныг сонгон шалгаруулж авахдаа тухайн хүний боловсрол, ёс суртахуун, төлөвшил, хандлага, өмнө нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж байсан эсэхийг сайтар нягталж авах шаардлагатай. Тухайлбал, Хилийн цэргийн дугаар ангийн Хүн эмнэлгийн албаны дарга тус ангийн офицер болон ахлах байлдагчийг хутгалж, эрүүл мэндэд хохирол учруулсан[12], бусдыг гэр бүлийн хардалтын улмаас зодож, эрүүл мэндэд хөнгөн

[12] Дорноговь аймгийн Сум дундын 8 дугаар шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар шийтгэх тогтоол

гэмтэл санаатай учруулсан[13], Хилийн цэргийн дугаар ангид нохой сургагч ажилтай алба хаагч 13 настай төрсөн дүүгээ хүчиндэж, энэхүү үйлдэлдээ огт харамсаахгүйн зэрэгцээ хариуцлагаас мултрахын тулд дүүгээ алчих юмсан гэж байсан[14], боксчин согтуугаар автомашин жолоодсон, бусдаас архины мөнгө нэхэж, улмаар зодож, эрүүл мэндэд гэмтэл санаатай учруулсан[15], хөгжмийн салааны удирдаач 3 удаагийн үйлдлээр иргэдээс 18 сая төгрөгийг залилж, мөнгөөр нь амралтад амарч, зугаа, цэнгэлд зарцуулсан гэх[16] ноцтой гэмт хэргийг үйлдсэн байна.

График №11 Шүүгдэгчийн албан тушаал, тоогоор



Шүүгдэгчийн цолыг авч үзвэл:

16 буюу 38 хувь нь ахлагч, 14 буюу 33.3 хувь нь байлдагч, буюу 7.1 хувь нь дэслэгч, буюу 4.7 хувь нь ахмад, ахлах дэслэгч, ахлах байлдагч, 1 буюу 2.3 хувь нь хошууч, дэд ахлагч, дэд түрүүч байна. (График №12)

Цолны байдлаар нь авч үзэхэд ахлагч бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчид гэмт хэрэг ихэвчлэн үйлдэж байна.

График №12 Шүүгдэгчийн цэргийн цол, тоогоор

[13] Дорноговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 49 дүгээр шийтгэх тогтоол

[14] Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 1045 дугаар шийтгэх тогтоол

[15] Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 892 дугаар шийтгэх тогтоол

[16] Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 392 дугаар шийтгэх тогтоол

Шүүгдэгчдийн хил дээр ажилласан хугацаагаар нь авч үзвэл:

- 17 буюу 40.4 хувь нь 1 хүртэл жил,
- 11 буюу 26 хувь нь 1-3 жил,
- 10 буюу 23.8 хувь нь 3-5 жил,
- 4 буюу 9.5 хувь нь 5-10 жил цэргийн алба хаасан байна. (График №13)

Эндээс үзэхэд, алба хаагчид олон жилийн хугацаагаар алба хаах тутам гэмт хэрэг үйлдэх нь магадлал нь багасаж байна.

График №13 Шүүгдэгчийн цэргийн алба хаасан хугацаа, тоогоор



Шүүгдэгч удам залгасан хилчин эсэхийг тодорхойлох нь шүүгдэгчдийн хувийн байдлыг тодорхойлоход ач холбогдолтой. Судалсан шүүхийн шийтгэх тогтоолуудаас үзэхэд, удам залгасан хилчин байхгүй, /13 буюу 31 хувь нь үгүй, 29 буюу 69 хувь нь тодорхойгүй/ байна.

График №14 Удам залгасан хилчин эсэх, тоогоор



Шүүгдэгчдийн гэр бүлийн байдлыг авч үзэхэд:

- 14 буюу 33.3 хувь нь гэрлэсэн,
- 25 буюу 59.5 хувь гэрлээгүй,
- буюу 7.1 хувь нь найз охинтой,
- 17 буюу 40.4 хувь нь хүүхэдтэй,
- 25 буюу 59.5 хувь нь хүүхэдгүй байна. (График №15,16)

График №15 Шүүгдэгчийн гэр бүлийн байдал, тоогоор

График №16 Шүүгдэгч хүүхэдтэй эсэх, тоогоор



Энэ судалгаанаас үзэхэд, гэрлээгүй хүмүүс гэмт хэрэг илүү үйлдсэн байна. Гэрлэсэн, гэр бүлтэй алба хаагчид нь нийгэм, гэр бүлийн гишүүдийн өмнө хүлээх үүрэг илүү байдаг тул гэмт хэрэг үйлдэх магадлал бага байна.

Иймд алслагдсан анги, заставд томилогдсон залуу алба хаагчдыг гэр бүлээ авч авах нөхцлөөр хангах, нийгэм, эдийн засгийн баталгааг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Хил хамгаалах байгууллагад ажиллаж байгаа алба хаагчид, хугацаат цэргийн алба хаагчид цэрэгт татагдахын өмнө гэмт хэрэг үйлдэж, шүүхээс ял шийтгэгдсэн тохиолдол цөөнгүй байгаа төдийгүй тухайн иргэд цэрэгт татагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх явдал байгааг анхаарах шаардлагатай. Тухайлбал, Шүүхээр шийтгүүлсэн шүүгдэгчийн 7 буюу 16.6 хувь нь өмнө нь ял эдэлж байсан (График №17) байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Хилийн цэргийн дугаар ангид хамт алба хаадаг эмэгтэйг хувийн сэдэлтээр алахыг завдсан гэмт хэргийг өмнө нь хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг үйлдэж, шүүхээс торгох ял шийтгэгдсэн алба хаагч үйлдсэн[17], хилийн цэргийн дугаар ангид холбоочин ажилтай эмэгтэй нь өмнө нь хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн боловч дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлджээ.[18]

Иймд хил хамгаалах албанд санаатай гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан иргэдийг авахгүй байх нь зүйтэй.

График №17 Урьд нь шүүгдэгч ял шийтгэгдсэн байдал, тоогоор



Өмнө нь ял шийтгэгдсэн шүүгдэгчдийн ялыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл:

- 2 буюу 4.7 хувийг биечлэн эдлүүлсэн, хорих ялыг тэнссэн,
- 1 буюу 2.3 хувийг хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан,
- 1 буюу 2.3 хувийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан,
- 1 буюу 2.3 хувийг өршөөгдсөн байна. (График №18)

График №18 Үүнээс: Оногдуулсан ялыг хэрэгжүүлсэн байдал, тоогоор

[17] Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 62 дугаар шийтгэх тогтоол
[18] Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 206 дугаар шийтгэх тогтоол



Урьд нь үйлдсэн гэмт хэргийг төрлийн хувьд авч үзэхэд:

- 2 буюу 7.1 хувь нь хулгайлах,
- 3 буюу 4.7 хувь нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг,
- 1 буюу 2.3 хувь нь алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших,
- 1 буюу 2.3 хувь нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг тус тус байна. (График №19)

Иймд өмнө нь гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай болох нь шүүхээр тогтоогдсон иргэдийг цэргийн алба, дэр дундаа Монгол Улсын хилийн халдашгүй байдлыг хамгаалах чиг үүргийг гүйцэтгүүлэхээс татгалзах шаардлагатай байна.

График №19 Үүнээс: Үйлдсэн гэмт хэргийн төрөл, тоогоор



Шүүгдэгчдийн 7 буюу 16.6 хувь нь урьд нь ял шийтгэгдэж байсан нь өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн, шүүгдэгчдийн 4 буюу 9.5 хувь нь тухайн байгууллагын хөдөлмөрийн аварга, марш-тусгай бэлтгэлийн тэмцээнд амжилттай оролцдог тэргүүний алба хаагч байсан нь анхаарал татаж байна.

Шүүгдэгч цэргийн алба хааж байхдаа болон цэрэгт татагдаж ирсний дараа сахилгын зөрчил гаргасан байдлыг авч үзвэл, 2 буюу хувь нь сахилгын зөрчил үйлдсэн, 40 буюу хувь нь сахилгын зөрчил гаргаагүй байна. (График №20)

График №20 Шүүгдэгч алба хааж байхдаа болон цэрэгт татагдаж ирсний дараа сахилгын зөрчил гаргасан байдал, тоогоор



Шүүгдэгчдийн ажиллаж байсан, цэргийн албанд татагдсан газраар авч үзвэл, Улаанбаатар хот 7 буюу 16.6 хувь, орон нутаг 35 буюу 83.4 хувийг тус тус эзэлж байна. (График №21)

Дээрх судалгаанаас харахад, орон нутагт төрсөн, тэнд өссөн хүмүүс шүүгдэгчдийн 83.4 хувийг эзэлж байна. Монголчууд нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор хөдөө, орон нутгийн хүмүүсийг уужуу сэтгэлтэй, холч ухаантай, ёс зүй, зан заншлын хэм хэмжээг эрхэмлэх чанар хотын хүмүүстэй харьцуулахад өндөр байдаг гэсэн таамаглал цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн хувьд үгүйсгэгдэж байна. Энэ нь боловсролын түвшин, түүний чанараас хамааралтай байх магадлалтай.

- Бүс нутгаар авч үзвэл:
- Говийн бүс 16 буюу 38 хувь,
- Баруун бүс 13 буюу 31 хувь,
- Төвийн бүс 7 буюу 16.6 хувь,
- Зүүн бус 6 буюу 14.2 хувь,
- Хойд бүс 3 буюу 7.1 хувийг тус тус эзэлж байна.

Энэ үзүүлэлтээс үзэхэд, говийн болон баруун бүсэд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна. (График №22)

График №21 Шүүгдэгчийн ажиллаж байсан, цэрэгт татагдсан газар, хувиар

График №22 Шүүгдэгчийн ажиллаж байсан, цэрэгт татагдсан газар /бүсээр/, хувиар



Шүүгдэгчийн хувийн зан чанарын онцлогийг авч үзвэл, түргэн ууртай, түрэмгий, тогтворгүй зантай хүн хүч хэрэглэсэн гэмт хэрэг ихээр үйлдэж байна. Тухайлбал, түргэн ууртай, түрэмгий ууртай, өмнө нь хулгайлах болон завших гэмт хэрэг үйлдэж, шүүхээс баривчлах ял шийтгэгдэж байсан хугацаат цэргийн алба хаагч хамт алба хааж байсан цэргийн алба хаагчтай өдрийн хоолны үеэр маргалдаж, улмаар өс хонзонгийн сэдэлтээр орой ОО руу орж байхад нь араас нь турба-аар

цохиж, эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан[19], хугацаат цэргийн алба хаагч хамт алба хааж байсан алба хаагчийг илтгэл, рапорт өгсөнгүй гэж алгадаж, нүүрс зөөлгөсөнд шаралхаж, хог түүж байхдаа олоод тэвшний дор нуусан байсан хутгаар араас нь хутгалж, эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан[20] байна. Шүүхээс дээрх үйлдэлд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээр зүйлчилж, ял оногдуулсан байх боловч хүнийг алах гэмт хэрэгт завдах гэмт хэргээр зүйлчлэх нь илүү оновчтой байсан нь хэргийн нөхцөл байдлаас харагдаж байна.

Харин цэргийн албанаас оргон зайлах гэмт хэргийг бүрэг ноомой, бусадтай харьцдаггүй, дотогшоо, үг дуу цөөтэй, хартай, гэрээ болон найз охиноо санадаг, шантрамтгай зантай хүмүүс ихээр үйлдэж байна. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагч гэрээ санасан, цэрэгт захны даавуу оёх, жагсах, юм хийх нь төвөгтэй байсан учраас гэрээ харимаар санагдаад цэргийн албанаас оргосон[21], найз охиноо, гэрээ санаад гэртээ харимаар санагдаад 2 удаа цэргээс оргож, 1 удаа цэргийн ангийн сахилгын байрнаас хаалгыг эвдэж оргосон[22], гэрээ санаад байхаар нь оргосон[23] байна.

Эдгээр анги байрлалаас оргосон цэргийн алба хаагчдыг дарга, захирагч, хамт алба хааж буй цэргүүдээс дарамтлах, дэглэх явдал гаргаагүй бөгөөд цэргийн ангийн холбогдох албан тушаалтан уулзаж, тайвшруулсан, цэргийн албанаас оргох гэмт хэрэг, түүний үр дагаварын талаар ойлгуулж ярилцсан боловч дахин оргосон байдал ажиглагдаж байна.

График №23 Шүүгдэгчийн хувийн зан чанарын онцлог, тоогоор



Шүүгдэгч дондолт, аливаа зүйлээс хамааралтай эсэхийг тодорхойлох нь гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тодорхойлоход ач холбогдолтой бөгөөд шүүхийн шийтгэх тогтоолуудаас үзэхэд, энэ талаарх мэдээлэл хомс байсан.

[19] Увс аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 67 дугаар шийтгэх тогтоол
[20] Өмнөговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2011 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 41 дүгээр шийтгэх тогтоол
[21] Увс аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 82 дугаар шийтгэх тогтоол
[22] Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 86 дугаар шийтгэх тогтоол
[23] Говь-Алтай аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 33 дугаар шийтгэх тогтоол

Цаашид цэргийн албаны эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа шүүгдэгчийн донтолт, хамааралтай эсэхийг тогтоох нь зүйтэй байна.

График №24 Шүүгдэгч донтолт, хамааралтай эсэх, тоогоор



3) Хохирогчийн хувийн байдал

Хохирсон цэргийн алба хаагчийн хувийн байдлыг судалж, дүн шинжилгээ хийх нь гэмт хэрэг үйлдэгдсэн обьектив шалтгаан, нөхцөл, субьектив хүчин зүйлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой тул хохирогч цэргийн алба хаагчийн нас, хүйс, боловсрол, мэргэжил, алба хаасан хугацаа, албан тушаал, цэргийн цол, албан тушаалын зэрэглэл, гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ямар хамааралтай болох, гэр бүлийн байдал, хохирогч өмнө нь шүүгдэгчийн хууль бус, дүрмийн бус үйлдлийн талаар удирдлагад мэдэгдсэн эсэх, авсан арга хэмжээ зэрэг үзүүлэлтээр хувийн байдлыг тодорхойлсон.

Гэмт хэргийн улмаас 26 цэргийн алба хаагч, 14 энгийн иргэн хохирсон байна. (График №25) Гэмт хэргийн улмаас хохирсон 14 иргэний 2 буюу 14.2 хувь нь гадаадын иргэн, 2 буюу 14.2 хувь нь цагдаагийн алба хаагч, 10 буюу 71.6 хувийг энгийн иргэд эзэлж байна. Гадаадын иргэд цэргийн алба хаагчийн үйлдсэн залилах гэмт хэрэгт, цагдаагийн алба хаагчид цэргийн алба хаагчийн үйлдсэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас хилийн цэргийн анги байгууллагад эд хөрөнгийн хохирол учирч байна. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагч байгаа газраа дур мэдэн орхиж явсан, оргон зайлсан тохиолдолд эрлийн баг гаргаж, удаан хугацаанд эрэн хайж, шатахуун, хүнсний ихээхэн зардал гаргадаг. Шүүх хуралдаанд ангийн захирагчийн тушаалаар томилогдсон алба хаагч иргэний нэхэмжлэгчээр оролцож, эрэн хайхад гарсан зардлыг нэхэмжилдэг боловч зарим тохиолдолд шүүхээс нэхэмжлэлийг иргэний журмаар гаргах эрхтэйг дурдаж, нэхэмжлэлийг хангахгүй байна.

График №25 Гэмт хэргийн улмаас хохирсон цэргийн алба хаагч, энгийн иргэн, тоогоор



Гэмт хэргийн улмаас хохирсон цэргийн алба хаагчдыг насны хувьд авч үзвэл,

- 18 настай 6 буюу 23 хувийг,
- 19-20 насны хохирогч 13 буюу 50 хувь,
- 21-22 насны хохирогч 5 буюу 19.2 хувь,
- 27-28 насны хохирогч 1 буюу 3.8 хувь,

- 31-ээс дээш насны хохирогч 1 буюу 3.8 хувийг тус тус эзэлж байна. (График №26)

График №26 Хохирогчийн нас, тоогоор



Судалгааны дүнгээс үзвэл, 22 хүртэлх насны хохирогч 24 бюу 92 хувь, 23-аас насны хохирогч 2 бюу 8 хувийг тус тус эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Үүнээс үзвэл 18-22 насны алба хаагчид гэмт хэрэгт өртөж, хохирогч болох эрсдэлтэй бүлэгт хамаарч байна.

Хохирогчдыг хүйсийн хувьд авч үзвэл, 23 буюу 88.4 хувь эрэгтэй, 3 буюу 11.6 хувь эмэгтэй хохирогч байна.

Хохирогчдыг боловсролын хувьд авч үзвэл, 7 буюу 27 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 16 буюу 61.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 3 буюу 11.5 хувь нь дээд боловсролтой алба хаагч байна. Харин боловсролгүй болон бага боловсролтой хохирогч байхгүй байгаа нь сонирхолтой байна. (График №27)

График №27 Хохирогчийн боловсролын түвшин, тоогоор



Үүнээс сүүлийн жилүүдэд цэргийн албанд татагдаж байгаа иргэдийн боловсролын түвшин нэмэгдсэн байна гэж дүгнэж болохоор байна.

Харин хохирогчдын 19 буюу 73 хувь нь мэргэжилгүй, 4 буюу 15.3 хувь нь хилийн алба, 3 буюу 11.7 хувь нь жолооч мэргэжилтай байна. (График №28)

График №28 Хохирогчийн мэргэжил, тоогоор

Хохирогчдын 3 буюу 11.5 хувь нь офицер, 1 буюу 3.8 хувь нь ахлагч, 2 буюу 7.6 хувь нь гэрээт хилчин, 20 буюу 77 хувь нь хугацаат цэргийн алба хаагч тус тус

байна. (График №29) Эндээс үзэхэд, хугацаат цэргийн алба хаагчид цэргийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн хохирогч ихээр болж байна.

График №29 Цэргийн албаны төрөл, тоогоор



Гэмт этгээдийн гэмт халдлагад 1 заставын орлогч, 1 харуулын дарга, 2 салаан захирагч, 21 хилчин байлдагч тус тус хохирсон байна. Нийт хохирогчдын 21 буюу 80.7 хувийг хилчин байлдагч эзэлж байгаа бөгөөд гэмт халдлагад анги, застав, харуулын дарга, бусад алба хаагчид өртөөгүй, бага өртсөн байгаа нь анхаарал татаж байна. Судалсан шүүхийн шийтгэх тогтоолуудаас үзэхэд, шүүгдэгчийн дийлэнх хувийг харуулын дарга нар эзэлж байсан бол эсрэгээрээ нэг харуулын дарга хохирсон байна.

График №30 Хохирогчийн албан тушаал, тоогоор



Хохирогчдын 1 буюу 3.8 хувь нь ахмад, 2 буюу 7.6 хувь нь дэслэгч, 1 буюу 3.8 хувь нь ахлагч, 1 буюу 3.8 хувь нь ахлах байлдагч, 21 буюу 80.7 хувь нь байлдагч цолтой алба хаагчид байна. (График №31) Эндээс үзэхэд, офицерууд гэмт хэргийн халдлагад өртөх магадлал харьцангуй бага байгаа нь харагдаж байна.

График №31 Хохирогчийн цэргийн цол, тоогоор



Хохирогчдын 22 буюу 84.6 хувь нь нэг хүртэл жил, 3 буюу 11.5 хувь нь 1-3 жил, 1 хувь 3.8 хувь нь 3-5 жил цэргийн алба хаасан байна. (График №32) Эндээс үзэхэд, 5-аас дээш жил цэргийн алба хаасан алба хаагч гэмт халдлагад өртөөгүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь тухайн алба хаагч туршлагажиж, төлөвшсөн,

аливаа асуудлыг эв дүйгээр зохицуулж, аюулаас зайлсхийх чадвар эзэмшсэнтэй холбоотой байх магадлалтай.

График №32 Хохирогчийн цэргийн алба хаасан хугацаа, тоогоор



Хохирогч шүүгдэгчтэй ямар хамааралтай болохыг авч үзэхэд, 14 буюу 53.8 хувь нь захирагдагч, 8 буюу 30.7 хувь нь хамт алба хааж байсан хугацаат цэргийн алба хаагч, 3 буюу 11.5 хувь нь хамт ажиллаж байгаа цэргийн алба хаагч, 1 буюу 3.8 хувь нь захирагч байна. (График №33)

График №33 Хохирогч гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ямар хамааралтай болох



Дээрх судалгаанаас үзэхэд, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг үйлдэх байдал их байна. Иймд хилийн цэргийн анги байгууллагад дүрмийн бус харьцаа, хүч хэрэглэх явдлаас сэргийлэх байнга зохион байгуулах шаардлагатай.

Хохирогчдын гэр бүлийн байдлыг авч үзвэл, 23 буюу 88.4 хувь нь гэрлээгүй, 3 буюу 11.6 хувь нь гэрлэсэн байна. (График №34) Энэ нь хохирогчдын дийлэнх хувийг 23 хүртэлх насны залуус эзэлж байгаатай холбоотой гэж үзэж байна.

График №34 Хохирогчийн гэр бүлийн байдал, тоогоор

Хохирогч өмнө нь шүүгдэгчийн хууль бус, дүрмийн бус үйлдлийн талаар удирдлагад мэдэгдсэн эсэх, авсан арга хэмжээний талаар судлахыг зорьсон боловч шүүхийн шийтгэх тогтоолд энэ талаарх мэдээлэл байхгүй байв. (График №35)

График №35 Хохирогч өмнө нь шүүгдэгчийн хууль бус, дүрмийн бус үйлдлийн талаар удирдлагад мэдэгдсэн эсэх, авсан арга хэмжээ, тоогоор

4) Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйл

Гэмт хэргийн обьектив шалтгаан, нөхцөл, субьектив хүчин зүйлсийг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр, түүний байршил, гэмт хэрэг үйлдэгдсэн газар, гэмт хэргийн сэдэлт, зорилго зэрэг түвшинд ангилж дүн шинжилгээ хийлээ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар нутгийг Улаанбаатар хот, бүс тус бүрээр нь нэгтгэн харуулав. (График №36)

График №36 Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр, байршил, тоогоор



Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд:

- Улаанбаатар хотод 8 буюу 19 хувь,
- Баруун бүсэд 12 буюу 28.5 хувь,
- Зүүн бүсэд 6 буюу 14.2 хувь,
- Хойд бүсэд 3 буюу 7.1 хувь,
- Төвийн бүсэд 3 буюу 7.1 хувийг тус тус эзэлж байна.

Үүнээс үзвэл баруун, говийн бүсэд төрлийн гэмт хэргийн гаралт харьцангуй өндөр үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг авч үзвэл:

- харуулын байранд 9 буюу 21.4 хувь,
- цэргийн ангид 8 буюу 19 хувь,
- заставт 7 буюу 16.6 хувь,
- улсын хилд 3 буюу 7.1 хувь,
- цэргийн ангийн мод бэлтгэлийн газарт 1 буюу 2.3 хувь,
- бусад газарт 14 буюу 33.3 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

Дээрх судалгаанаас үзэхэд, цэргийн анги, застав, харуулын байранд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж, байгаа нь цэргийн алба хаагч аюулгүй орчинд цэргийн алба хаах нөхцөл бүрдээгүй гэж дүгнэж болохоор байна.

Иймд гэмт хэрэг зонхилон үйлдэгдэж буй цэргийн анги, застав, харуулын байрыг бүрэн камержуулах, байнгын хяналт тавьж ажиллах, харуулын албаны дүрмийг чанд сахиулж ажиллах нь зүйтэй байна.

График №37 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, тоогоор



Гэмт хэрэг үйлдсэн цагийг үечлэн авч үзвэл:

- 00-03 цаг хүртэл 16 буюу 38 хувь,
- 04-08 цаг хүртэл 4 буюу 9.5 хувь,
- 09-12 цаг хүртэл 5 буюу 11.9 хувь,
- 13-16 цаг хүртэл 4 буюу 9.5 хувь,
- 17-20 цаг хүртэл 9 буюу 21.4 хувь,
- 21-24 цаг хүртэл 4 буюу 9.5 хувийг тус тус эзэлж байна. (График №38)

Эндээс үзэхэд шөнийн цагаар буюу 00-03 цагийн хооронд гэмт хэрэг зонхилон үйлдэгдэж байгаа бөгөөд шөнийн цагаар харуулын үүрэг гүйцэтгэхдээ унтсан, харуулд гарахгүй гэж маргасны улмаас дүрмийн бус харьцсан тохиолдол цөөнгүй байна.

График №38 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, тоогоор



Гэмт хэрэг үйлдэгдсэн улирлын хувьд авч үзвэл:

- өвлийн улиралд 15 буюу 35.7 хувь,
- хаврын улиралд 7 буюу 16.6 хувь,
- намрын улиралд 11 буюу 26.1 хувь,
- зуны улиралд 9 буюу 21.4 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд өвлийн улиралд гэмт хэрэг хамгийн их үйлдэгдэж байна. (График №39)

График №39 Гэмт хэрэг үйлдэгдсэн улирал, тоогоор



Өвөл, намрын улиралд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа нь хяналт суларсан, цэргийн алба хаагчид ядарч, даарч бухимдсантай холбоотой байх магадлалтай байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг нарийвчлан тогтоох зорилгоор гэмт хэрэг үйлдэгдсэн гаригийг авч үзвэл, Даваа гаригт 5 буюу 11.9 хувь, Мягмар гаригт 3 буюу 7.1 хувь, Лхагва гаригт 5 буюу 11.9 хувь, Пүрэв гаригт 3 буюу 7.1 хувь, Баасан гаригт 6 буюу 14.2 хувь, Бямба гаригт 14 буюу 33.3 хувь, Ням гаригт 6 буюу 14.2 хувийг эзэлж байна. (График №40)

Гэмт хэрэг мягмар, пүрэв гаригт хамгийн бага үйлдэгдэж, 7 хоногийн сүүл үе буюу баасан, бямба, ням гаригт нэмэгдэх хандлагатай байжээ.

График №40 Гэмт хэрэг үйлдэгдсэн гариг, тоогоор



Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор гэмт хэргийн үйлдлийн аргыг судалж үзэхэд:

- хүч хэрэглэсэн гэмт хэрэг 22 буюу 75.8 хувь,
- хууран мэхэлсэн 2 буюу 6.8 хувь,
- биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулсан 1 буюу 3.4 хувь,
- мориор хөөсөн 1 буюу 3.4 хувь,
- хариуцуулж өгсөн эд хөрөнгийг завшсан 2 буюу 6.8 хувь,
- хаалга эвдэж 1 буюу 3.4 хувийг тус тус эзэлж байна. (График №41)

Хил хамгаалах байгууллагын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн дийлэнх нь хүч хэрэглэх аргаар үйлдэгдсэн байна. Зарим тохиолдолд дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх, догшин авирлах, хэрцгий байдлаар гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй гарчээ. Тухайлбал, Дорнод аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн харуулын дарга 2 байлдагчийг пароль буруу тавьсан гэх шалтгаанаар цэргийн дүрмийн бус байдлаар харьцаж, 9 км зайд мориор хөөж, бууны мөрлөгч модоор нуруун тус газарт нь цохиж, эрүүл мэндэд хохирол учруулсан[24], Завхан аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн заставын дарга захирагдагч нартай дүрмийн бус байдлаар харьцаж, өвөл цементэн талбайд алгаар нь суниалгасны улмаас 2 байлдагчийн гарын алга, хурууны өндөгний хэсэг хөлдсөн, харуулын даргыг өвдөглөж, зодсоны улмаас хавиргыг гэмтээж, эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан[25] зэрэг гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

График №41-Гэмт хэргийн үйлдлийн арга, тоогоор

[24] Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 162 дугаар шийтгэх тогтоол

[25] Завхан аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2011 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 11 дүгээр шийтгэх тогтоол



Хохирогчтой дүрмийн бус харьцсан, зодсон давтамжийн хувьд авч үзвэл, 1 удаа 19 буюу 90.4 хувь, 2-3 удаа 2 буюу 9.6 хувийг тус тус эзэлж байна. (График №42) Харин байнга дүрмийн бус харьцсан, зодсон тохиолдол байхгүй байна.

Эдгээрийг дүгнэн үзэхэд, цэргийн алба хаагчдын үйлдсэн, хохирсон гэмт хэрэг нь удаан хугацаанд хүчирхийлэл үргэлжилдэггүй, тохиолдлын шинж чанартайгаар үйлдэгддэг гэж дүгнэж болох боловч, мөрдөн байцаалтын явцад хүчирхийллийн давтамжийг шалгаж тогтоогоогүй байх магадлалтай.

График №42. Дүрмийн бус харьцсан, зодсон давтамж, тоогоор



Давтан үйлдсэн тохиолдлуудын үргэлжилсэн хугацааг тогтоох нь олон талын ач холбогдолтой. Тиймээс 2 ба түүнээс дээш удаа дүрмийн бус харьцсан, зодсон 2 тохиолдлын үргэлжилсэн хугацаанд дүн шинжилгээ хийж үзэхэд, 1-3 сар үргэлжилсэн байна.

График №43-Гэмт хэрэгт хамтран оролцогч, тоогоор



Гэмт хэрэг үйлдэхдээ зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл ашигласан байдлыг авч үзвэл:

- байлдааны галт зэвсэг 20 буюу хувь,
- тэсэрч дэлбэрэх бодис 1 буюу 10 хувь,
- дохионы буу 1 буюу 10 хувь,
- бууны мөрлөгч мод 1 буюу 10 хувь,
- хутга 4 буюу 40 хувь, труба 1 буюу 10 хувийг эзэлж байна. (График №44)

Гэмт хэрэг үйлдэгч нь хутга, байлдааны галт зэвсэг ихэвчлэн ашигласан байна. Гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг тодорхойлох шаардлагатай.

График №44-Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тоогоор



Шүүхийн шийтгэх тогтоолд дурдагдсан баримтад дүн шинжилгээ хийж үзэхэд, хохирогч шууд хохирохоос гадна тэдний эцэг болон бусад ойр дотны хүмүүст гэмт хэрэгтэй хамааралтай үр дагавар үүссэн байгааг гүйцэт шалгах шаардлагатай.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хувьд авч үзвэл:

- хохирогч нас барсан 3 буюу 8.5 хувь,
- хохирогчийн эрүүл мэндэд хохирол учирсан 23 буюу 65.7 хувь,
- үр хөндүүлсэн 1 буюу 2.8 хувь,
- эд хөрөнгөд хохирол учирсан 8 буюу 22.8 хувийг тус тус эзэлж байна. (График №45)

График №45-Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, тоогоор

Судалгаанаас үзэхэд, хохирогчдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учирсан тохиолдол түгээмэл байна.

Цэргийн албан хаагчдын үйлдсэн зарим хүнд гэмт хэргийн улмаас Хил хамгаалах байгууллага, хилчдийн нэр хүнд унах, олон нийт дээрх байгууллагыг буруутгах, иргэдийн дунд цэргийн алба хаахаас татгалзах байдлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар ихээр үүсч байна. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагчид цэргийн албанаас оргон зайлах гэмт хэргийг үйлдэх явцдаа байлдааны галт зэвсгээр бүрэн зэвсэглэсэн цэргүүд иргэдийн автотээврийн хэрэгслийг шалгах нэрийдлээр зогсоож, тээврийн хэрэгслийг авч зугтаан улмаар зам тээврийн осол гаргасан. Тухайн гэмт хэргийн шүүхийн хэлэлцүүлэгт "Эдгээр 2 байлдагч оргосноос хилийн цэрэг болохгүй, бүтэхгүй байгууллага юм шиг ойлголт иргэдэд төрсөн, Байгууллагын нэр хүнд унасан."[26] Шүүхээс энэхүү гэмт хэргийг шийдвэрлэхдээ авто тээврийн хэрэгслийг авч зугтаах, цэргийн албанаас оргон зайлах гэмт хэргээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна. Шүүхийн шийтгэх тогтоолын агуулгаас үзэхэд, байлдагчдын үйлдэл дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангахаар харагдаж байна.

[26] Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 53 дугаар шийтгэх тогтоол

Гэмт хэргийн улмаас 23 хүний эрүүл мэндэд хохирол учирсан байна. Гэмтлийн зэргээр ангилж үзвэл:

- 9 буюу 39.3 хувь нь хөнгөн,
- 4 буюу 17.3 хувь нь хүндэвтэр,
- 10 буюу 43.4 хувь нь хүнд байна.

Ийнхүү бусдын эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэг 43.4 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм. (График №46)

График №46 Эрүүл мэндэд учирсан хохирол, тоогоор



`Гэмт хэрэг үйлдэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдол цөөнгүй байна. (График №47) Тухайлбал, Хилийн цэргийн дугаар ангийн ахлах офицер нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ цагдаагийн алба хаагчийг хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж, эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан байна. Шүүгдэгч, мөрдөн байцаалтын явцад өгсөн мэдээлэхдээ "...би тухайн үед тасарчихсан байсан болохоор юу ч мэдэхгүй, санахгүй байна. Цагдаагийн алба хаагчтай таарсанаа ч мэдэхгүй байна." [27] Гэж мэдүүлжээ. Мөн Хилийн цэргийн дугаар ангид заставын дарга нь Улаанбаатар хотод найзындаа ирж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэж байхад шаардлага тавьсан алба хаагчийг эсэргүүцэж, зодсон, хувцасыг урсан.[28] Хэрэв согтууруулах ундаа хэрэглэсэн үед нь тээврийн хэрэгсэл жолоодох үйлдлийг таслан зогсоогоогүй бол ямар үр дагавар бий болохыг тааварлахад бэрх юм. Мөн Өмнөговь аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн заставын дарга сумын төвөөс буцах замдаа ахлагч нартайгаа согтууруулах ундаа уун улмаар заставын байрлалд архидан согтуурсан. Өглөө нь заставын бие бүрэлдэхүүнийг буунд нь дуудаж, гүйлгэсэн байна. Гүйх замдаа заставын орлогч гэрээт ахлагч М-тай маргаж, ахлагч М, Н нар бүлэглэж дарга, захирагчаа хүч хэрэглэн эсэргүүцэж, улмаар ахлагч М заставын орлогчийн шаардлагыг эсэргүүцэж, санаатай алах гэмт хэрэг үйлдсэн байна.[29]

Иймд хохирогчийн буруутай үйлдэл гэмт хэрэг үйлдэгдэх бас нэг шалтгаан болдогийг санаж байх нь зохилтой.

Харин гэмт хэрэг үйлдэх үедээ мансуурсан, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн тохиолдол байхгүй байна. Гэхдээ олсны төрлийн ургамал ургадаг бүс нутгийн цэргийн анги, байгууллага мансуурлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллах нь зүйтэй.

График №47 Гэмт хэрэг үйлдэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн, мансуурсан байсан эсэх, тоогоор

[27] Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 228 дугаар шийтгэх тогтоол

[28] Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 423 дугаар шийтгэх тогтоол

[29] Өмнөговь аймаг дахь Сум дундын шүүхийн 2011 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 63 дугаар шийтгэх тогтоол

Гэмт хэрэг үйлдэгдэхэд хохирогчийн буруутай үйл ажиллагаа нөлөөлсөн байдлыг судалж үзэхэд:

- хохирогч шүүгдэгчтэй маргасан 8 буюу 30.7 хувь,
- дүрмийн бус харьцсан 7 буюу 27 хувь,
- үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн 3 буюу 11.5 хувь,
- хэгжүүрхсэн,
- гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэсэн тус бүр 2 буюу 7.6 хувь,
- зодсон, доромжилсон 1 буюу 3.8 хувийг тус тус эзэлж байна. (График №48)

Дарга, захирагчид нь гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн бус байдлаар харьцаж, эрүүл мэндэд хохирол учруулах байдал цөөнгүй гарч байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн харуулын дарга байлдагчдыг захны даавуугаа угаа, гараа угаа, хиртай гараар хоол хийсэн, хоорондоо маргалдаж, оны ялгаа гаргах, нэгнийгээ дарамтлах байдал ажиглагдахаар нь дүрмийн бус харьцаж, зодсон,[30] Дорнод аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн хилчин байлдагч шинэ цэрэгт хувцасаа тайлж, эвхэж амрах шаардлага тавихад шинэ цэрэг нь уурлаж, тайлбар тавьсан учраас 1 удаа өвдөглөж, 1 удаа цээж рүү нь цохьсноос хохирогч нас барсан, Сүхбаатар аймгийн Хилийн цэргийн дугаар ангийн салаан захирагч хугацаат цэргийн алба хаагчийг жагсаалд ярьж болохгүй талаар хэлэхэд өөдөөс инээж, хэржүүрхсэн тул баруун гараараа зүүн шанаа руу нь нэг удаа цохиж, айлгах гээд гараа далайхад хальтирч унаад гэмтсэн[31] гэмт хэргүүд үйлдэгджээ.

График №48 Гэмт хэрэг үйлдэгдэхэд хохирогчийн буруутай үйл ажиллагаа нөлөөлсөн байдал, тоогоор

[30] Өмнөговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 5 дугаар шийтгэх тогтоол

[31] Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 58 дугаар шийтгэх тогтоол



Цэргийн албанд татагдсаны дараах шүүгдэгч, хохирогчидын сэтгэл зүйн байдлыг тогтоохыг оролдсон ч шүүхийн шийтгэх тогтоолд энэхүү мэдээлэл дутмаг байна. (График №49)

График №49 Шүүгдэгч, хохирогчийг цэргийн албанд татагдсаны дараа сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон байдал, тоогоор



Шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд, үйлдэгдсэн гэмт хэрэг ихэвчлэн дүрмийн бус харьцаа, галт зэвсэг, хэрэгсэлтэй харьцах болон Харуулын албаны журам зөрчсөн, гэрээ санасан, шантарсан, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, шийтгэлээс айсан, албаны үүргийг хангалтгүй биелүүлсэн, хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, шаардлага биелүүлээгүй зэрэг болон хоол хийхгүй, чанасан гурил өгөөгүй зэрэг “жижиг” шалтгаанаас үүдэн гарсан байна. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагч харуулын байранд чанасан гурил өгсөнгүй гэж хамт харуулын үүрэг гүйцэтгэж байсан байлдагчийг хутгалж, эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан[32], “Харуулын байрыг цэвэрлэхгүй, хэлсэн үгийг үл тоосон гэж нэг шанаа авна биздээ гэж хэлээд цохиж, эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан[33], хугацаат цэргийн алба хаагчид хоол хийхгүй гэж маргалдаж, зодолдож, унахдаа тохойгоо гэмтээсэн.[34]

4) Шүүхээс ял оногдуулсан байдал

[32] Завхан аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 21 дүгээр шийтгэх тогтоол
[33] Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 7 дугаар шийтгэх тогтоол
[34] Өмнөговь аймаг дахь Сум дундын 15 дугаар шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 32 дугаар шийтгэх тогтоол

График №50 Гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, тоогоор

Нийлбэр дүнгээр нь авч үзвэл, нийт ял оногдуулсан хэргийн 26 буюу 63.4 хувьд нь хорих ял оногдуулсан байна. Хорих ял оногдуулсан 26 тохиолдолд оногдуулсан ялыг авч үзвэл хугацааны хувьд 6 сараас 12 жил 1 сар байна.

Шүүхээс оногдуулсан хорих болон баривчлах ялын 15 буюу 46.8 хувийг биечлэн эдлүүлж, 17 буюу 53.2 хувийг тэнссэн. (График №51) Харин хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан тохиолдол байхгүй байна.

График №51 Оногдуулсан ялыг хэрэгжүүлсэн хэлбэр, тоогоор



Гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг анх удаа гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр хөнгөрүүлэх тохиолдол түгээмэл байна.

График №52 Гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн хөнгөрүүлэх нөхцөл байдал, тоогоор

Шүүх шийтгэх тогтоолдоо бүлэглэж, согтуугаар үйлдсэн гэдгийг тус бүр 3 удаа, гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, хохирогчийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулсан гэдгийг тус бүр 2 удаа дурдсан бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлыг 32 удаад хэрэглээгүй байна.

График №53 Гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн хүндрүүлэх нөхцөл байдал, тоогоор



Ял оногдуулахдаа харгалзан үздэг нэг зүйл нь гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо барагдуулсан эсэх асуудал байдаг. Судалгаанаас үзэхэд, нийт тохиолдлын 31 буюу 83.7 хувь нь хохирлыг барагдуулсан бол, 2 буюу 5.4 хувь нь хохирол нөхөн төлөөгүй, 10.8 хувь нь ямар нэгэн хохирол нэмхэмжлээгүй байна. (График №54)

График №54 Хохирол нөхөл төлсөн байдал, тоогоор



Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн, хохирсон гэмт хэргийн шүүхийн шийтгэх тогтоолд хийсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хил хамгаалах байгууллагын алба хаагчид ихэвчлэн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсч, хохирол хор уршигт зориуд хүргэж гэм буруугийн санаатай хэлбэрээр гэмт хэрэг үйлдэж байна.
2. Хил хамгаалах байгууллагын алба хаагчид нь ангилалын хувьд олон төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа хэдий ч үйлдсэн гэмт хэргийн бүтцэд хүнд, онц хүнд гэмт хэргийн эзлэх хувийн жин бага байна.
3. Хил хамгаалах байгууллагын алба хаагчид ихэвчлэн 18-24 насандаа гэмт хэрэг үйлдэж байгаа нь биеэ барих чадваргүй, зан төлөвийн хувьд бүрэн төлөвшөөгүй байдагтай холбон тайлбарлаж болохоор байна.

4. Шүүгдэгчдийн хүйсийн харьцааг авч үзвэл гэмт хэрэг үйлдсэн алба хаагчдын 40 буюу 95.2 хувь эрэгтэй, 2 буюу 4.8 хувь нь эмэгтэй байна. Гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчдаас эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байна.
5. Гэмт хэрэг үйлдсэн хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг боловсролын түвшингээр авч үзвэл, бүрэн дунд, дээд боловсролтой хүн гэмт хэрэг их үйлдсэн, боловсролгүй, бага болон бүрэн бус дунд боловсролтой хүмүүс гэмт хэрэг харьцангуй бага үйлдсэн нь харагдаж байна. Цэргийн алба хаагчид гэмт хэрэг үйлдэх нь боловсролын түвшинтэй шууд холбоотой гэж дүгнэх боломжгүй байна.
6. Шүүгдэгчийн мэргэжлийн байдлыг авч үзвэл, 20 буюу 47.6 хувь нь мэргэжилгүй, 3 буюу 7.1 хувь нь автомеханик, 2 буюу 4.7 хувь нь хилийн алба, жолооч, хүний их эмч, гагнуурчин, эрх зүйч, сантехникч, 1 буюу тус бүр 2.3 хувь нь хөгжимчин, хөгжмийн удирдаач, ар талын эдийн засагч, цахилгаанчин, холбоочин, нохой сургагч, нягтлан бодогч, бизнесийн менежмент зэрэг мэргэжилтэй байна. Эндээс үзэхэд, тодорхой мэргэжил эзэмшээгүй алба хаагч гэмт хэрэг үйлдэх явдал түгээмэл байна гэж дүгнэж байна.
7. Шүүгдэгчдийн 16 буюу 38 хувийг хилчин байлдагч, 8 буюу 19 хувийг харуулын дарга, үлдсэн хувийг бусад албан тушаалтан эзэлсэн байна. Эндээс үзэхэд, харуулын дарга, хилчин байлдагчид гэмт хэрэг үйлдэх нь их байна.
8. Хил хамгаалах байгууллагад өөр мэргэжлийн сургууль */цэргийн мэргэжлийн бус/* төгсөж ирсэн эмч, нохой сургагч, сургалт, биеийн тамирын ажилтан, хөгжмийн салааны удирдаач, боксын тамирчин зэрэг ажилтныг сонгон шалгаруулж авахдаа тухайн хүний боловсрол, ёс суртахуун, төлөвшил, өмнө нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж байсан эсэхийг сайтар нягталж, төрийн тусгай албанд томилох шаардлагатай байна.
9. Гэмт хэрэг үйлдэж, шүүхээс ял шийтгүүлсэн хил хамгаалах байгууллагын алба хаагчдын 14 буюу 33.3 хувь нь гэрлэсэн, 25 буюу 59.5 хувь гэрлээгүй, 3 буюу 7.1 хувь нь найз охинтой, 17 буюу 40.4 хувь нь хүүхэдтэй, 25 буюу 59.5 хувь нь хүүхэдгүй байна. Дээрх судалгаанаас үзэхэд, гэрлээгүй хүмүүс гэмт хэрэг илүү үйлдсэн байна. Гэрлэсэн, гэр бүлтэй хүн нийгэм, гэр бүлийн гишүүдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага илүү байдаг тул гэмт хэрэг үйлдэх магадлал бага байна. Иймд алслагдсан анги, заставд томилогдсон залуу алба хаагчдыг гэр бүлээ авч авах нөхцлөөр хангах, нийгэм, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх, гэр бүл болоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг дэмжих шаардлагатай байна.
10. Гэмт хэрэг үйлдсэн хил хамгаалах байгууллагын алба хаагчид өмнө ял эдэлж байсан эсэхийг авч үзвэл, 7 буюу 16.6 хувь нь өмнө нь ял эдэлж байсан байна. Үүнээс үзэхэд, хил хамгаалах байгууллагад ажиллаж байгаа болон хугацаат цэргийн албанд татагдаж ирж байгаа иргэд цэрэгт татагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх явдал их байгааг анхаарах шаардлагатай.
11. Санаатай гэмт хэрэг үйлдэж, шүүхээс ял шийтгэгдсэн алба хаагчдыг цэргийн албанаас чөлөөлөхгүй байгаагийн улмаас дахин гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй байна.
12. Гэмт хэрэг үйлдэж, шүүхээр шийтгүүлсэн хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг нутаг дэвсгэрийн харьяаллаар авч үзвэл, Улаанбаатар хот 16.6 хувь, орон нутаг 83.4 хувийг тус тус эзэлж байна. Дээрх тоо баримтаас үзвэл, орон нутагт төрсөн, тэнд өссөн хүмүүс шүүгдэгчдийн 83.4 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Монголчууд нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор хөдөө, орон нутгийн хүмүүсийг уужуу сэтгэлтэй, холч ухаантай, ёс зүй, зан заншлын хэм хэмжээг эрхэмлэх чанар хотын хүмүүстэй харьцуулахад өндөр байдаг гэсэн таамаглал цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн хувьд үгүйсгэгдэж байна. Энэ нь боловсролын түвшин, түүний чанараас хамааралтай байх магадлалтай.

13. Шүүгдэгчийн хувийн зан чанарын онцлогийг авч үзвэл, түргэн ууртай, түрэмгий, тогтворгүй зантай хүн хүч хэрэглэсэн гэмт хэрэг ихээр үйлдэж байна. Харин цэргийн албанаас оргон зайлах гэмт хэргийг бүрэг ноомой, бусадтай харьцдаггүй, дотогшоо, үг дуу цөөтэй, хартай, гэрээ болон найз охиноо санадаг, шантрамтгай зантай хүмүүс ихээр үйлдэж байна.
14. Шүүгдэгч архи, мансууруулах бодисоос хамааралтай эсэх, дондолт байгаа эсэх нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлоход ач холбогдолтой бөгөөд шүүхийн шийтгэх тогтоолуудаас үзэхэд, энэ талаарх мэдээлэл хомс байсан. Цаашид цэргийн албаны эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа шүүгдэгчийн донтолт, хамааралтай эсэхийг тогтоох нь зүйтэй байна.
15. Гэмт хэргийн улмаас хилийн цэргийн анги байгууллагад эд хөрөнгийн хохирол учирч байна. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагч байгаа газраа дур мэдэн орхиж явсан, оргон зайлсан тохиолдолд эрлийн баг гаргаж, удаан хугацаанд эрэн хайж, шатахуун, хүнсний ихээхэн зардал гаргадаг байна. Шүүх хуралдаанд ангийн захирагчийн тушаалаар томилогдсон алба хаагч иргэний нэхэмжлэгчээр оролцож, эрэн хайхад гарсан зардлыг нэхэмжилж ирсэн боловч зарим тохиолдолд шүүхээс иргэний журмаар нэхэмжлэх эрхтэйг дурдаж, нэхэмжлэлийг хангахгүй байна.
16. Хохирогчдын 22 буюу 84.6 хувь нь 1 хүртэл жил, 3 буюу 11.5 хувь нь 1-3 жил, 1 хувь 3.8 хувь нь 3-5 жил цэргийн алба хаасан байна. Эндээс үзэхэд, 5-аас дээш жил цэргийн алба хаасан алба хаагч гэмт халдлагад өртөөгүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь тухайн алба хаагч туршлагажиж, төлөвшсөн, аливаа асуудлыг эв дүйгээр зохицуулж, аюулаас зайлсхийх чадвар эзэмшсэнтэй холбоотой байх магадлалтай.
17. Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг үйлдэх байдал их байна. Иймд хилийн цэргийн анги байгууллагад дүрмийн бус харьцаа, хүч хэрэглэх явдлаас сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.
18. Хохирогчдын гэр бүлийн байдлыг авч үзвэл, 23 буюу 88.4 хувь нь гэрлээгүй, 3 буюу 11.6 хувь нь гэрлэсэн байна. Энэ нь хохирогчдын дийлэнх хувийг 23 хүртэлх насны залуус эзэлж байгаатай холбоотой гэж үзэж байна.
19. Цэргийн анги, застав, харуулын байранд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа нь цэргийн алба хаагч аюулгүй орчинд цэргийн алба хаах нөхцөл бүрдээгүй гэж дүгнэж болохоор байна. Иймд гэмт хэрэг ихэвчлэн үйлдэгдэж буй цэргийн анги, застав, харуулын байрыг бүрэн камержуулах, байнгын хяналт тавьж ажиллах, харуулын албаны дүрмийг чанд сахиулж ажиллах нь зүйтэй байна.
20. Шөнийн цагаар буюу 00-03 цагийн хооронд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна. Шүүхийн шийтгэх тогтоолоос үзэхэд, шөнийн цагаар харуулын үүрэг гүйцэтгэхдээ унтсан, харуулд гарахгүй гэж маргасны улмаас дүрмийн бус харьцсан тохиолдол цөөнгүй байна.
21. Гэмт хэрэг үйлдэгдсэн улирлын хувьд авч үзвэл, өвлийн улиралд 15 буюу 35.7 хувь, хаврын улиралд 7 буюу 16.6 хувь, намрын улиралд 11 буюу 26.1 хувь, зуны улиралд 9 буюу 21.4 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл, өвлийн улиралд гэмт хэрэг их үйлдэгдэж байна.
22. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг нь Баасан, Бямба, Ням гаригт хамгийн их үйлдэгдсэн байна. Харин Мягмар, Пүрэв гаригт хамгийн бага үйлдэгдэж, 7 хоногийн сүүл үед нэмэгдэх хандлагатай байна.
23. Хил хамгаалах байгууллагын алба хаагчийн үйлдсэн дийлэнх гэмт хэрэг хүч хэрэглэх аргаар үйлдэгдсэн байна. Зарим тохиолдолд дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэргийг үйлдэхдээ догшин авирлах, хэрцгий байдлаар үйлдэх явдал цөөнгүй гарчээ. Хохирогчтой дүрмийн бус харьцсан, зодсон давтамжийн хувьд авч үзвэл 1 удаа 19 буюу 90.4 хувь, 2-3 удаа 2 буюу 9.6 хувийг тус тус эзэлж байна. Харин байнга дүрмийн бус харьцсан, зодсон тохиолдол байхгүй байна. Эндээс үзэхэд, цэргийн алба хаагчдын үйлдсэн,

хохирсон гэмт хэрэг нь удаан хугацаанд хүчирхийлэл үргэлжилдэггүй, тохиолдлын шинж чанартайгаар үйлдэгддэг онцлогтой гэж дүгнэж болох боловч мөрдөн байцаалтын явцад хүчирхийллийн давтамжийг сайн шалгаж тогтоогоогүй байх магадлалтай.

24. Давтан үйлдсэн тохиолдлуудын үргэлжилсэн хугацааг тогтоох нь олон талын ач холбогдолтой. Тиймээс 2 ба түүнээс дээш удаа дүрмийн бус харьцсан, зодсон 2 тохиолдлын үргэлжилсэн хугацаанд дүн шинжилгээ хийж үзэхэд, 1-3 сар үргэлжилсэн байна.
25. Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгслийн хувьд авч үзвэл, байлдааны галт зэвсэг 20 буюу хувь, тэсэрч дэлбэрэх бодис 1 буюу 10 хувь, дохионы буу 1 буюу 10 хувь, бууны мөрлөгч мод 1 буюу 10 хувь, хутга 4 буюу 40 хувь, труба 1 буюу 10 хувийг эзэлж байна. Эндээс үзэхэд, гэмт хэрэг үйлдэхдээ хутга, байлдааны галт зэвсэг ихэвчлэн ашигласан байна.
26. Гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг тодорхойлох шаардлагатай. Энэ үүднээс шүүхийн шийтгэх тогтоолд дурдагдсан баримтад дүн шинжилгээ хийж үзэхэд, хохирогч шууд хохирохоос гадна тэдний эцэг болон бусад ойр дотны хүмүүст гэмт хэрэгтэй хамааралтай үр дагавар үүссэн байна. Судалгаанаас үзэхэд, хохирогчдын бие махбодид хохирол учирсан тохиолдол түгээмэл байна. Мөн цэргийн албан хаагчдын үйлдсэн зарим хүнд гэмт хэргийн улмаас хил хамгаалах байгууллага, хилчдийн нэр хүнд унах, олон нийт дээрх байгууллагыг буруутгах, иргэдийн дунд цэргийн алба хаахаас татгалзах байдлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар ихээр үүсч байна.
27. Гэмт хэргийн улмаас 23 хүний эрүүл мэндэд хохирол учирсан байна. Гэмтлийн зэргээр ангилж үзвэл, 9 буюу 39.3 хувь нь хөнгөн, 4 буюу 17.3 хувь нь хүндэвтэр, 10 буюу 43.4 хувь нь хүнд байна. Бусдын эрүүл мэндэд учирсан хүнд хохирол 43.4 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм.
28. Гэмт хэрэг үйлдэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдол цөөнгүй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн тохиолдол байхгүй байна. Гэхдээ олсны төрлийн ургамал ургадаг бүс нутгийн цэргийн анги, байгууллага мансуурлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллах нь зүйтэй.
29. Шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд, үйлдэгдсэн гэмт хэрэг ихэвчлэн дүрмийн бус харьцаа, галт зэвсэг, хэрэгсэлтэй харьцах болон харуулын албаны журам зөрчсөн, гэрээ санасан, шантарсан, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, шийтгэлээс айсан, албаны үүргийг хангалтгүй биелүүлсэн, хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, шаардлага биелүүлээгүй зэрэг хохирогчийн буруутай үйл ажиллагаа нөлөөлсөн байдал ажиглагдаж байна.
30. Шүүгдэгч, хохирогчийг цэргийн албанд татагдсаны дараа сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон байдлыг судалж үзэхэд, судалгаанд хамрагдсан шүүхийн шийтгэх тогтоолд энэхүү мэдээлэл дутмаг байна.
31. Шүүх шийтгэх тогтоолдоо эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрэглэхдээ бүлэглэж, согтуугаар тус бүр 3 удаа, гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, хохирогчийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулсан гэдгийг тус бүр 2 удаа дурдсан бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлыг 32 удаад хэрэглээгүй байна.
32. Ял оногдуулахдаа харгалзан үздэг нэг зүйл нь гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо барагдуулсан эсэх асуудал байдаг. Судалгаанаас үзэхэд, нийт тохиолдлын 31 буюу 83.7 хувь нь хохирлыг барагдуулсан бол 2 буюу 5.4 хувь нь хохирол нөхөн төлөөгүй, 10.8 хувь нь ямар нэгэн хохирол нэхэмжлээгүй байна.

ГЭМТ ХЭРГИЙН ХЯНАЛТЫН “COMPSTAT” ЦОГЦ СИСТЕМИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Ж.Эрдэнэболд
ДХИС-ийн докторант

Товч агуулга. Дэлхийн улсуудын томоохон хотуудад иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг бууруулах, хяналтад авах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг техник, технологи, бодит, мэдээлэл, дүн шинжилгээнд тулгуурласан оновчтой, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор гэмт хэргийн хяналтын CompStat цогц системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашигладаг. Иймд гэмт хэргийн цогц систем гэж юу болох, хэрхэн ажилладаг болон үйл ажиллагааны арга, хэлбэрүүд, олон улсын судлаачдын үнэлэлт, дүгнэлтийг нэгтгэн танилцуулж байна.

Түлхүүр үг. Гэмт хэргийн хяналтын цогц систем, CompStat, дэвшилтэт технологи, статистик, гэмт хэргийн цахим зураглал, дүн шинжилгээ, гэмт хэргийн гаралтыг бууруулах, удирдлагын манлайлал, цагдаагийн байгууллагын менежмент.

Удиртгал

Монгол Улсын хүн амын 67.2 хувь нь хот суурин газар, үүнээс 45.3 хувь буюу 1.500.000 орчим иргэн нийслэл хотод албан ёсны бүртгэлтэйгээр амьдарч байна. Тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 95.1 хувь нь төвийн 6 дүүрэгт амьдарч буй юм. Нийт нутаг дэвсгэрийн ердөө 0.3 хувийг эзлэх Улаанбаатар хотод хүн амын дийлэнх нь төвлөрч буйгаас харахад хотжилт, төвлөрөл үнэхээр эрчимтэй байгаа ба үүнийгээ дагаад гэмт хэргийн гаралт ихэсч хотын аюулгүй байдал, иргэд, оршин суугчдын амгалан тайван байдлыг хангахад ихээхэн бэрхшээлтэй болж байна. Тухайлбал, 2020 онд Нийслэл хотод 14.633 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 63.4 хувийг эзэлж байгаа нь Нийслэл хотод гэмт хэрэгтэй тэмцэх, хотын аюулгүй, амар тайван байдлыг хангахад ихээхэн хүчин чармайлт гаргаж, орчин цагийн дэвшилтэт, үр дүнтэй арга, барил, техник, технологи, инновацыг нэвтрүүлж, оновчтой, үр дүнтэй ажиллах шаардлагатайг харуулж байна.

Судлаачаас олон улсын гэмт хэрэгтэй тэмцэх цогц арга хэмжээ, шилдэг дэвшилтэт технологи, туршлагыг Монгол Улсын Цагдаагийн байгууллагад нэвтрүүлэх, ялангуяа Улаанбаатар хотын гэмт хэрэг, захиргааны зөрчлийг тодорхой хэмжээгээр бодитойгоор бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үр дүнтэй зохион байгуулах, энэ бүгдийн гол хөдөлгөгч хүч болсон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, арга барилыг оновчтой, үр дүнтэй болгох, эдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ямар боломж байгааг эрэлхийлж судалгаа, шинжилгээний ажлуудыг тодорхой үе шаттайгаар явуулсан.

Энэ ажлын хүрээнд дэлхийн олон орны мега хотуудад хэрэглэгдэж буй COMPSTAT гэмт хэргийн хяналтын систем буюу цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн гаралтыг бодитойгоор бууруулах, дэвшилтэт технологи, арга барилыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, менежментийн цогц аргыг сонгож тодорхой судалгаануудыг хийж байгаа ба энэхүү гэмт хэргийн цогц систем хэрхэн яаж ажилдаг, гадаад улс орнуудад хэрэгжүүлсэн байдал, гарсан үр дүн болон сул талууд, үйл ажиллагааны арга хэлбэрүүд болон судлаачдын судалсан судалгаа, тэдгээрийн үнэлэлт, дүгнэлтүүдийг судалсан.

Түүнчлэн, энэхүү судалгааны ажлын бас нэг гол зорилго бол өнөөгийн Улаанбаатар хотын гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал ямар байгаа, эдгээр нь юунаас шалтгаалж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх, Улаанбаатар хотын болон харьяа дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн үйл ажиллагаанд байгаа хүндрэл, бэрхшээл, арга барилын болон үйл ажиллагааны хоцрогдлууд, үүнийг хэрхэн сайжруулж үр дүнтэй оновчтой ажиллуулах, CompStat гэмт хэргийн цогц системийн Монгол улсад

таарч тохирох арга, хэлбэрүүдийг талаар болон Улаанбаатар хотод хэрэгжүүлэх шаардлага, хэрэгцээ, хэрэгжүүлж ажиллах боломжуудын талаар судалж тодорхой арга хэлбэрүүдийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, туршиж ажилласан.

Судлаачийн зүгээс энэхүү гэмт хэргийн цогц системийн үйл ажиллагаа, арга хэлбэр, хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар АНУ-ын Режисийн их сургуульд суралцаж Криминологийн шинжлэх ухааны магистрын зэрэг хамгаалсан ба тэрээр Цагдаагийн байгууллагад дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Гэмт хэрэгтэй тэмцэх ажил хариуцсан дэд дарга, Нийслэлийн цагдаагийн газрын даргаар ажиллаж байх хугацаандаа дээрх системийг Монгол улсад тэр дундаа цагдаагийн байгууллагад ашиглаж болох эсэх, таарч тохирох арга хэлбэрүүдийг судалж тодорхой дүүрэг, нутаг дэвсгэр, гэмт хэргийн төрөл болон нийслэл хотын хэмжээнд зарим арга хэлбэрүүдийг нь нэвтрүүлэн туршсан, практик үйл ажиллагааны түвшинд нэвтрүүлэн ашиглаж тодорхой үр дүнд хүрсэн зэрэг нь энэхүү судалгааны ажлын гол онцлог, үндэс суурь нь гэж үзэж байна.

Нэг.Compstat бол цагдаагийн байгууллагын удирдлагын болон үйл ажиллагааны загвар болох нь

АНУ-ын Нью-Йорк хот нь тус улсын болон дэлхийн бизнес, эдийн засаг, худалдаа, соёлын томоохон төв бөгөөд үүнийгээ дагаад тус хот нь 1920-иод оноос гэмт хэргийн гаралт болон гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа, учирч буй хохирлынхоо хэмжээгээр улсдаа дээгүүрт орох болсон. Түүнчлэн, тус хот нь 1990-ээд оны эхээр ойролцоогоор 7.3 сая орчим оршин суугчтай байсан ба зөвхөн 1993 онд гэхэд тус хотод 430.460 гэмт хэрэг бүртгэгдэж байсан байна. Иймээс тус хотын гэмт хэргийн гаралтыг бууруулах, нөхцөл байдлыг хяналтад авах зорилгоор тухайн үеийн Нью-Йорк хотын захирагч Руди Жулиани /Rudi Giuliani/ болон Цагдаагийн газрын дарга Уйльям Браттон /William Bratton/ тус хотод хэрэгжүүлэх шаардлагатай шинэ гэмт хэргийн хяналтын болон мэдээлэл, дүн шинжилгээнд тулгуурласан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны загвар, хэлбэрийг судалж шинээр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн ба үүнийгээ CompStat буюу компьютер статистик гэж нэрлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү цогц систем нь сүүлийн 20 жилийн хугацаанд Нью-Йорк хотын иргэдийн амьдралын болон аюулгүй байдлын түвшинг дээшлүүлж гэмт хэргийн гаралтыг хангалттай хэмжээгээр бууруулж чадсанаараа тэмдэглэгдэн үлдсэн. /Godown. 2009/.

CompStat нь компьютер статистик болон харьцуулах статистик /Comparative statistic/ үгийн товчлол бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн гаралтыг бууруулахын тулд бүх цагдаагийн нэгж, түвшинд үүсээд буй асуудлыг цаг алдалгүй богино хугацаанд олж тодорхойлон тухайн асуудалд тохирсон зөв оновчтой ажил, арга хэмжээ, тактикийг хэрэгжүүлж, асуудлыг шийдвэрлэх цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа, барьж ажиллах стратеги гэж ойлгож болно.

АНУ-ын Нью Жерси мужийн Нью-Арк хотын цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан Даниел Делорензи болон түүний судалгааны багаас CompStat-ын үйл ажиллагаа, үр дүнг судалж тодорхойлохдоо “CompStat нь гэмт хэргийн талаарх цугларсан мэдээлэл болон үүнд хийсэн дүн шинжилгээнд тулгуурласан иргэд, оршин суугчдын аюулгүй амар тайван амьдралын төлөө цагдаагийн байгууллагаас явуулж буй стратегийн хяналтын цогц үйл ажиллагаа /Strategic control system/ юм. Энэхүү үйл ажиллагааг дараах байдлаар хураангуйлан ойлгож болно. Мэдээллийг цуглуул, түүндээ дүн шинжилгээ хий, гэмт хэргийн цахим зураглалын мэдээлэл болон бусад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг бусад арга хэрэгсэл, дата мэдээллийг цуглуулан дээрх цугларсан мэдээ мэдээллүүд, нөхцөл байдалд тохирсон зохих арга хэмжээ, үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын зохих нэгжийн

удирдлагуудаас цаг алдалгүй авч хэрэгжүүлж үр дүнд хүрэх явдал гэж ойлгож болно”. /Delorenzi, 2006/.

CompStat-ын арга хэлбэрүүд:

1. Статистик харьцуулалт

Статистик бол үр ашигтай шийдвэр гаргахад шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах; боловсруулах; нэгтгэн дүгнэх; дүн шинжилгээ хийх; тайлбарлах; танилцуулах арга зүйн тухай шинжлэх ухаан юм. Өөрөөр хэлбэл бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх статистик нь гэмт хэргийн талаарх тоог цаашид уншиж, дүгнэж болох мэдээлэл болгон хувиргаж байгаа процесс гэж ойлгож байна.

CompStat нь компьютер статистик болон харьцуулах статистик /Comparative statistic/ үгийн товчлол. Энэхүү арга нь CompStat гэмт хэргийн хяналтын цогц системийн үндсэн гол хэлбэр бөгөөд тухайн хот, нутаг дэвсгэрт гарч байгаа гэмт хэрэг, зөрчил, дуудлага мэдээллийг 7 хоног, сар, жилээр гаргаж өмнөх хугацааны 7 хоног, сар, жилтэй харьцуулж гэмт хэргийн өсөлт бууралтыг байнга хянаж, дүн шинжилгээ хийдэг. Ингэснээр тухайн хот, нутаг дэвсгэрт ямар дүүрэг, хороо, байршилд ямар гэмт хэргийн гаралт ихэсч буурч байгааг богино хугацаанд бодитойгоор тодорхойлох боломжийг удирдлагад олгодог.

Дээрх байдлаар гэмт хэргийн нөхцөл байдлыг байнга, богино хугацаанд бодитойгоор тодорхойлж чадсанаар тухайн цагдаагийн нэгжийн удирдлага, шийдвэр гаргагчдаас ямар хүн хүчээр, ямар тактикаар тухайн нутаг дэвсгэр, гэмт хэргийн төрөлтэй тэмцэх талаар урьдчилан харж оновчтой бодлого, стратегийг хэрэгжүүлж ажилласнаар эерэг үр дүн гардаг.

Зураг 1. Нью-Йорк хотын хэмжээний 2016.01.18-ны өдрөөс 2016.01.24-ны өдрийн 7 хоногийн CompStat-ын мэдээлэл

Police Department
City of New York

Bill de Blasio
Mayor

William J. Bratton
Police Commissioner

Volume 22 Number 48

CompStat

Citywide

Report Covering the Week
11/23/2015 Through 11/29/2015

Crime Complaints

	Week to Date			28 Day			Year to Date*			2 Year	5 Year	22 Year
	2015	2014	% Chg	2015	2014	% Chg	2015	2014	% Chg	% Chg	% Chg	% Chg
Murder	7	5	40.0	19	24	-20.8	318	298	6.7	2.3	-35.8	-82.0
Rape	37	26	42.3	118	100	18.0	1,308	1,243	5.2	2.0	3.7	-56.3
Robbery	311	309	0.6	1,357	1,305	4.0	15,267	15,011	1.7	-12.5	-14.1	-80.5
Fel. Assault	346	342	1.2	1,426	1,464	-2.6	18,433	18,729	-1.6	-1.2	16.9	-51.7
Burglary	286	307	-6.8	1,197	1,266	-5.5	13,677	15,362	-11.0	-13.7	-20.2	-85.1
Gr. Larceny	782	772	1.3	3,571	3,340	6.9	39,614	40,238	-1.6	-4.0	14.5	-49.4
G.L.A.	127	133	-4.5	591	582	1.5	6,775	6,972	-2.8	1.1	-28.3	-93.4
TOTAL	*1,896*	*1,894*	*0.11*	*8,279*	*8,081*	*2.45*	*95,392*	*97,853*	*-2.51*	*-6.01*	*-1.13*	*-75.79*
Transit	57	33	72.7	224	186	20.4	2,231	2,051	8.8	-4.5	14.6	***.*
Housing	100	85	17.6	387	392	-1.3	4,610	4,595	0.3	-4.8	19.0	***.*
Petit Larceny	1,437	1,443	-0.4	6,213	6,285	-1.1	74,300	78,167	-4.9	-5.0	-0.8	***.*
Misd. Assault	747	738	1.2	3,092	3,097	-0.2	39,144	40,543	-3.5	-2.9	-7.5	***.*
Misd. Sex Crimes	47	60	-21.7	311	252	23.4	2,984	2,559	16.6	20.0	7.3	***.*
Shooting Vic.	26	21	23.8	84	95	-11.6	1,234	1,267	-2.6	2.4	-25.3	-77.4
Shooting Inc.	22	18	22.2	73	83	-12.0	1,042	1,069	-2.5	2.1	-23.4	-78.7

Historical Perspective

(Historical perspective is a complete calendar year of data.)

	1990	1993	1998	2001	2014	%Chg '14 vs '01	%Chg '14 vs '98	%Chg '14 vs '93	%Chg '14 vs '90	
Murder	2,262	1,927	629	649	333	-48.7	-47.1	-82.7	-85.3	Murder
Rape	3,126	3,225	2,476	1,930	1,352	-29.9	-45.4	-58.1	-56.7	Rape
Robbery	100,280	85,892	39,003	27,873	16,539	-40.7	-57.6	-80.7	-83.5	Robbery
Fel. Assault	44,122	41,121	28,848	23,020	20,207	-12.2	-30.0	-50.9	-54.2	Fel. Assault
Burglary	122,055	100,936	47,181	32,694	16,765	-48.7	-64.5	-83.4	-86.3	Burglary
Gr. Larceny	108,487	85,737	51,461	46,291	43,862	-5.2	-14.8	-48.8	-59.6	Gr. Larceny
G.L.A.	146,925	111,622	43,315	29,607	7,664	-74.1	-82.3	-93.1	-94.8	G.L.A.
TOTAL	*527,257*	*430,460*	*212,913*	*162,064*	*106,722*	*-34.1*	*-49.9*	*-75.2*	*-79.8*	*TOTAL*

All figures are subject to further analysis and revision. All degrees of rape are included in the rape category.
As of January 2013, complaints occurring within the jurisdiction of the Department of Correction have been disaggregated from the borough and precinct crime totals and are displayed separately on the Department of Correction CompStat page.
Crime statistics reflect New York State Penal Law definitions and differ from the crime categories used by the FBI Uniform Crime Reporting Program. All Crime statistics are translated to Uniform Crime Reporting categories for submission to the UCR Program.

Prepared by
NYPD CompStat Unit

CompStat

Гэмт хэргийн статистик харьцуулалт, дүн шинжилгээг хүснэгтэн харьцуулалт, график, диаграмм зэрэг харьцуулалт, дүн шинжилгээний олон арга хэлбэрийг ашиглан хийдэг байна.

Зураг 2. АНУ-ын Солт Лайк хотын Цагдаагийн газрын 2018.01.08-ний өдрөөс 2018.01.14-ний өдрийн 7 хоногийн CompStat-ын мэдээлэл



Salt Lake City Police Department

CompStat Report

Council District 5 - Breakdown of All Offenses

Report Covering the Week 01/08/2018 Through 01/14/2018 (Mon-Sun)

Volume 4 – Number 2

	Last 7 Days*				Last 28 Days*				Previous 28 Days* (Prior to Last 28 Days)			Year to Date (YTD)*			3-Year YTD Average*		5-Year YTD Average*	
	2018	2017	Chg	% Chg	2018	2017	Chg	% Chg	2017	Recent Chg	Recent % Chg	2018	2017	% Chg	Avg**	% Chg	Avg**	% Chg
Criminal Homicide	0	0	0	/0	0	1	-1	-100.0%	0	0	/0	0	0	/0	0.00	/0	0.40	-100.0%
Sexual Assault	2	0	2	/0	4	0	4	/0	3	1	33.3%	3	0	/0	2.33	28.6%	2.00	50.0%
Robbery - Business	0	1	-1	-100.0%	1	1	0	0.0%	1	0	0.0%	0	1	-100.0%	2.00	-100.0%	2.20	-100.0%
Robbery - All Other	1	0	1	/0	6	3	3	100.0%	5	1	20.0%	3	0	/0	1.00	200.0%	1.20	150.0%
Agg. Assault - Family	1	0	1	/0	2	1	1	100.0%	0	2	/0	1	0	/0	1.33	-25.0%	1.60	-37.5%
Agg. Assault - Nonfamily	1	1	0	0.0%	5	5	0	0.0%	9	-4	-44.4%	3	1	200.0%	3.67	-18.2%	3.80	-21.1%
Burglary - Residential	1	1	0	0.0%	5	12	-7	-58.3%	22	-17	-77.3%	3	3	0.0%	9.33	-67.9%	7.40	-59.5%
Burglary - All Other	1	1	0	0.0%	10	15	-5	-33.3%	9	1	11.1%	8	6	33.3%	5.33	50.0%	5.40	48.1%
Larceny - Vehicle Burglary	9	27	-18	-66.7%	38	68	-30	-44.1%	72	-34	-47.2%	15	43	-65.1%	38.33	-60.9%	31.60	-52.5%
Larceny - All Other	34	33	1	3.0%	145	139	6	4.3%	148	-3	-2.0%	71	73	-2.7%	80.67	-12.0%	72.00	-1.4%
Motor Vehicle Theft	7	10	-3	-30.0%	33	31	2	6.5%	26	7	26.9%	15	16	-6.3%	17.00	-11.8%	13.80	8.7%
TOTAL	57	74	-17	-23.0%	249	276	-27	-9.8%	295	-46	-15.6%	122	143	-14.7%	161	-24.2%	141	-13.7%

Note: Charts may erroneously show an apparent drop in the most current data due to some cases not yet having been reported and/or recorded.
The figures included in this report are preliminary figures for general situational awareness and trend purposes only. They do not represent the official figures of the Salt Lake City Police Department and are subject to further analysis and revision. Due to the statute-driven, changing nature of crime classification and area boundaries over time, be advised that the figures contained may not fully coincide with SLCPD statistical sources. Differences are reflective of the departmental procedures or policies that were in place at the time the events occurred and the date the data was compiled. In addition, data may be approximate in relation to indicated areas. Additionally, they are not Uniform Crime Reporting (UCR) or "crime rate" numbers and are not intended to be used as such. Rather, they are a breakdown of every offense within every case that occurred during the given time periods. Although every reasonable effort is made to verify their accuracy, the accuracy of any data is subject to the constraints of the report generation process as well as the manner, format, and point in time of any query.

** The above CompStat figures were generated on Tuesday, 2 day(s) after the closing date, which is indicated in the title. The figures are current as of the date generated.*

*** Averages greater than or equal to 100 are rounded to a whole digit to maintain a consistent column size.*

Page 7 of 9

2. Гэмт хэргийн цахим зураглал

CompStat-ын гэмт хэргийн цахим зураглалын технологи нь тухайн хот, дүүрэг, нутаг дэвсгэрт хаана, ямар байршилд, ямар гэмт хэрэг гарч байгааг болон гэмт хэргийн өсөлт, буурал, хэргийн өнгө, гаралтын нарийвчилсан байршлыг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан тухай бүр бодитойгоор тодорхойлох боломжийг олгодог. Энэ нь газрын цахим зураглал, хүснэгт, график, халуун цэгийн байршлын судалгаа зэрэг олон хэлбэрээр байдаг ба үүнийг зөв уншиж, ойлгож, дүн шинжилгээ хийж чадсанаар яг ямар байршил, газар нутагт аль төрлийн гэмт хэрэг тухайн хугацаанд тухайлбал өдөр, 7 хоног, сарын хугацаанд ихээр үйлдэгдэж байгааг бодитойгоор харах боломжийг өгдөг. Ингэснээр удирдлагаас хаана ямар байрлалд,ямар гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж ажиллах, тусгайлсан арга хэмжээнүүдийг зохион явуулах, цагдаагийн хүн хүч, эргүүл харуулыг хэзээ ажиллуулах зэргээр оновчтой, үр дүнтэй ажиллах боломжийг олгодог.

Зураг 3. АНУ-ын Флорида мужийн Дайтон Биич /Dayton Beach/-ийн гэмт хэргийн цахим зураглал

Энэ нь цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын менежментийг оновчтой, шуурхай хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Гэмт хэргийн цахим зураглал нь гарсан гэмт хэргийн байршлыг тодорхойлох, хэргийн өнгөөр ялгах, тодорхой хугацааны гэмт хэргийн гаралтын хөдөлгөөнийг хянах, гэмт хэргийн гаралтын халуун цэгийн судалгаа \hot spot analyzing system\ зэрэг олон төрлөөр хийгддэг байна.

Зураг 4. Халуун цэгийн цахим зураглалаар нэгэн дүүргийн орон байрны хулгай болон автомашины хулгайн гэмт хэргийн зураглалыг гаргасан байдал



3.Мэдээллийг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох

Энэхүү арга хэлбэр нь CompStat гэмт хэргийн цогц системийн гол үндсэн арга, үйл ажиллагааны үндсэн цөм гэж ойлгож болно. Дээр дурдагдсан олон талын мэдээлэл цуглуулах, нэгтгэх, нөхцөл байдлыг бодитой үнэлэх, мэдрэх, олж харах арга, хэлбэр, технологиудын тусламжтайгаар авагдсан мэдээллүүдийг нэгтгэн боловсруулж , тодорхой мэргэшсэн дүн шинжилгээний шинжээч нар болон орчин үеийн дэвшилтэт дүн шинжилгээний технологи, программ хангамжуудын туслалцаатайгаар хаана, ямар газар, байршилд, ямар цаг хугацаанд, ямар гэмт хэрэг ихээр гарч байгаа зэргийг нарийвчлан тодорхойлж ингэснээр цаашид цагдаагийн байгууллагаас хаана, хэзээ, ямар гэмт хэрэгт анхаарлаа хандуулах шаардлагатай байгааг, тухайн нутаг дэвсгэр, гэмт хэргийн төрлийн цаашдын чиг хандлага ямар байгааг тодорхойлон өгдөг. Ингэснээр цагдаагийн байгууллагын удирдлагаас цаашид ямар арга хэмжээ авах, ямар тактик, стратеги боловсруулж тэмцэх газрын зураг, хөтөч болж өгдөг.

4.CompStat-Удирдлагын хурал

Тухайн хотын тодорхой нутаг дэвсгэр хариуцсан болон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажил хариуцсан дарга, удирдах ажилтнууд 7 хоног, 1 сар тутам цуглаж дээрх гэмт хэргийн статистик харьцуулалт, гэмт хэргийн цахим зураглалууд, тэдгээрт хийсэн дүн шинжилгээний дүгнэлтийг хэлэлцдэг.

Ингэснээр тодорхой нутаг дэвсгэр, байршил, гэмт хэргийн гаралтын цаг хугацаа, гарч буй хэргийн төрлүүдэд үнэлэлт дүгнэлт өгч хаана ямар асуудал бий болоод байгааг цаг алдалгүй харж тодорхойлон, цаашид юунд анхаарал хандуулж ажиллах, цагдаагийн байгууллагын хүн, хүчийг хэрхэн зохион байгуулах, ямар арга тактикаар тэмцэх асуудлыг төлөвлөн хэлэлцдэг. Ингэж богино хугацаанд 7 хоног бүр хэлэлцэж, цаашдын ажиллах чиглэлийг тодорхойлж ажилласнаар удирдлагын түвшинд хугацаа алдалгүй шийдвэр гаргах боломжийг олгодог.

Зураг 5. Нью-Йорк хотын хэмжээний 7 хоногийн CompStat-ын хуралдаан



Мөн удирдлагын түвшинд нөхцөл байдлаа бодитойгоор харж, үнэлэн, тулгараад байгаа асуудлуудыг шийдвэрлэдэг байна.

5. CompStat-Удирдлагын төв

Дээр дурдагдсан CompStat-ын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахад статистик харьцуулалт, дүн шинжилгээ, гэмт хэргийн цахим зураглалыг ашиглах, , үүсэн бий болж буй асуудал, бэрхшээлүүдийг олж харах, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, CompStat-Удирдлагын хурлыг зохион байгуулж тодорхой шийдвэр гаргахад тодорхой дүн шинжилгээ, удирдлага зохион байгуулалтын хүн хүч, техник, тоног төхөөрөмж, программ хангамжаар тоноглогдсон CompStat-Удирдлагын төвийг ашигладаг байна.

Энэхүү удирдлагын төвийг хамгийн анх АНУ-ын Нью-Йорк хотод 2005 онд орчин үеийн техник, технологид тулгуурлан цагдаагийн байгууллагад цугларсан мэдээ, мэдээллийн дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэх, шаардлагатай дата, мэдээллийг үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчдад түгээх, дамжуулах, нөхцөл байдлыг бодитойгоор хугацаа алдалгүй мэдэрч, хянаж байх зэрэг CompStat-ыг үндсэн үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор байгуулсан байна. Энэхүү удирдлагын төвийг Real-Time crime center буюу RTCC гэж товчлон нэрлэдэг байна. Энэ нь гэмт хэргийн бодит нөхцөл байдал, цаг хугацааны удирдлагын төв гэж ойлгогдон орчуулагдаж байна. Одоо дээрх удирдлагын төвийг АНУ-д хэдэн сая хүн амтай том метрополис хотуудаас авхуулаад жижиг хотууд, суурин газруудад хүртэл оршин суугчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор ашигладаг талаар олон тайлбар, судалгаанд тэмдэглэсэн байна.

Зураг 6. Real-Time crime center буюу RTCC

Энэхүү төв нь дээрх мэдээллүүдийг цуглуулах, дүн шинжилгээ хийж нэгтгэн боловсруулах, гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, удирдлагыг мэдээллээр хангах, цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг цаг алдахгүй, байнга шуурхай зохион явуулж байх үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг байна. Судалгааны явцад энэхүү төвийн ажиллах зарчим,

хэрэгжилт, зохион байгуулалт, үр дүн болон Монгол улсад байгуулсан талаар судлан танилцуулах болно.

Хоёр.Compstat-ын хүрсэн үр дүн, амжилтууд

Судлаач Винцент Е. Хенри \Vincent E. Henry\ CompStat-ын талаар дүгнэхдээ "Орчин цагийн АНУ-ын хууль сахиулах салбарын түүхэнд тод томруунаар тэмдэглэгдэн үлдсэн, олон талаас нь сайтар судлагдсан асуудал бол CompStat-ыг Нью-Йорк хотод нэвтрүүлэн ашиглаж тус хотын гэмт хэргийн гаралтыг 1993 оноос хойш урьд өмнө байгаагүй хэмжээгээр бууруулж чадсан явдал юм. Чухамдаа Нью-Йорк хотын үндсэн гэмт хэргийн гаралт сүүлийн 13 жилийн хугацаанд тогтмол буурсаар байгаа ба тус хот ч АНУ-ын аюулгүй байдлын түвшингээрээ тэргүүлж буй томоохон хотуудын нэгд тооцогдсоор байна. \Хэнри, 2007. p.1\

Түүнчлэн, Хэнри CompStat-ын үр дүнгийн талаар тэмдэглэхдээ "Нью-Йорк хотын Цагдаагийн газрын хийсэн тооцооллоор бүртгэгдсэн нийт гэмт хэргээс үндсэн 7 төрлийн \major felony\ гэмт хэргүүд нь 2003 онд урьд өмнө гарч байгаагүйгээр буюу 1993 оныхоос хойш 65,9 хувиар буурсан байна. 2003 тус хотод 146.397 гэмт хэрэг гарсныг 1993 онд гарч бүртгэгдсэн 430.460 гэмт хэрэгтэй харьцуулахад 2003 онд тус хотод үйлдэгдэж бүртгэгдсэн гэмт хэрэг болон гомдол мэдээлэл нь сүүлийн 30 жилийн хугацаанд хамгийн бага үзүүлэлт нь байна. Нью-Йорк хотын гэмт хэргийн түвшин-бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн гаралтын хувь 1963 оноос хамгийн бага түвшиндээ очсон байна." гэжээ. Тэрээр "Судалгааны явцад АНУ-ын Холбооны мөрдөх товчооны Гэмт хэргийн гаралтын бүртгэл \ Uniform Crime Report data of FBI\-ийн 2005 оны мэдээллээр 2003 онд Нью-Йорк хот нь 100.000 хүн ам тутамд ноогдох гэмт хэргийн индексээрээ АНУ-ын 100.000-аас дээш хүн амтай 230 хотоос 211-т орж үнэлэгдэж байна. Энэ нь үнэхээр гайхалтай амжилт, үр дүн ба тус хот нь дээрх үзүүлэлтээр 1996 оны эхний хагас жилд 144-т эрэмбэлэгдсэн, 1993 онд 87-д үнэлэгдэж байсан зэргээс харж болно. \Henry. 2007, p.2\

Түүнчлэн Нью-Йорк хотын гэмт хэргийн түвшний мэдээллээр тус хотод CompStat-ыг нэвтрүүлж ашиглаж эхэлснээр гэмт хэргийн гаралтыг хангалттай хэмжээгээр буулгаж, гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагааг бодитойгоор хязгаарлаж, тус хотын болон иргэд, оршин суугчдын аюулгүй, амар тайван амьдралыг хангахад ахиц дэвшил гаргаж чадсан байна. Ялангуяа үндсэн гэмт хэргүүд болох хүний амь хохироох, дээрэм, хулгайн гэмт хэргүүд их хэмжээгээр буурсан байна.

Гурав.Compstat-ын хэрэгжилтийн үйл ажиллагааг харьцуулан судалсан нь

Судлаач James Willis, Stephen Mastrofsky болон David Weisburd нараас АНУ-ын зарим хотууд дахь CompStat-ын хэрэгжилтийн үйл ажиллагаанд хамтарсан судалгаа, дүн шинжилгээ хийсэн байна. Тэд тайландаа CompStat хэрэгжиж буй АНУ-ын 3 хот болох Нью-Жерси мужийн Нью-Арк хот, Массачустес мужийн Ловел хот, Миннесота мужийн Миннеаполис хотуудын болон Цагдаагийн газрын CompStat хэрэгжилтийн үйл явц,ад хийсэн үнэлгээ, дүгнэлтийг оруулж өгсөн байна.

Судлаачдаас CompStat хэрэгжиж буй хүн амын тоо, гэмт хэргийн нөхцөл байдал, цагдаагийн байгууллагын хүчин чадал зэрэг нь харилцан адилгүй дээрх 3 хотыг сонгож судалгаа явуулсан байна. Судалгааны явцад тэд тэмдэглэхдээ " Үндэсний гэмт хэргийн мэдээлэл \Uniform Crime Report\-ийн 2001 оны тайланд дурдсанаар Ловел хотод 105.668 хүн амд 260 цагдаагийн алба хаагч ажилдаг, Миннеаполис хотын 386.726 оршин суугчдад 919 цагдаагийн алба хаагч ажилдаг бол харин Нью-Арк хотын 275.823 хүн амд 1445 цагдаагийн алба хаагч ажилдаг байна.

1980-1990 онд дээрх 3 хотод олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаанд тулгуурласан ихээхэн өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн байна. Шийдвэр гаргалтыг албан тушаалын эрэмбийн дагуу \10-тын систем шиг\ хэрэгжүүлж ажилласнаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн ахиц гарч, байгууллагын уян хатан байдал, хурд сайжирч төвлөрлийг дүүргүүд болон тодорхой нутаг дэвсгэр

хариуцсан нэгжүүдэд хуваарилан саармагжуулсан. Цаашлаад тэднийг хотын иргэд, оршин суугчидтай дотно харилцаа бий болгоход дэмжлэг үзүүлж, иргэдийг аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт үйл ажиллагаанд татан оролцуулах, тухайлбал иргэд, оршин суугчдын уулзалт зохион байгуулах \Хөршийн холбоотой ижил\, иргэд оршин суугчдын оролцоог нэмэгдүүлэх зэргээр иргэдийн дунд эерэг найрсаг уур амьсгалыг бүрдүүлдэг.

Нэмж хэлэхэд дээрх 3 хотын цагдаагийн газарт гурвууланд нь Олон нийтийн хариу үзүүлэх баг \ Community Response Team\ ажилдаг ба энэхүү багийн гол үүрэг нь иргэд, оршин суугчдад бий болсон тодорхой асуудал, түгшүүрийг шийдвэрлэхэд чиглэдэг \Willis, Mastrofsky, Weisburd. 2003, p 5\.

Түүнчлэн тус судалгааны баг дээрх хотуудад CompStat буюу гэмт хэргийн хяналтын шинэ систем нэвтэрч эхэлсэн болон үр дүнг нь тооцох боломжтой хугацаа болох 1996-2003 он хүртэлх гэмт хэргийн гаралтын үзүүлэлтүүдийг харьцуулан судалсан байна. Тэд энэ ажлынхаа хүрээнд дээрх 6 жилийн хугацаанд уг 3 хотын гэмт хэргийн гаралт хангалттай хэмжээгээр буурсныг олж тогтоосон байна. Тухайлбал Нью-Арк хотын гэмт хэргийн гаралт 1996 онд 13.500 байсан бол 2003 онд 7000 орчим болж буурсан байна. Харин Миннеаполис хотод 1996 онд 11.200 орчим гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2001 онд 7000 гэмт хэрэг бүртгэгджээ.

График 1. Дээрх 3 хотын гэмт хэргийн гаралтын график



Дээрх харьцуулсан графикаас харахад дээрх 3 хотуудын гэмт хэргийн гаралт CompStat хэрэгжиж эхэлснээс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр буурч үр дүнгээ өгсөн байна.

Судлаачдаас энэхүү судалгааны үр дүнг дүгнэхдээ “Эцэст нь хэлэхэд судалгаанд оролцсон 3 хотын харьцуулалтууд болон эдгээр хотуудын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өөрчлөлт үр дүн нь тухайн хот, цагдаагийн байгууллагын өмнө нүүрлээд буй гэмт хэрэг, аюулгүй байдлын асуудал болон байгууллагын удирдлага, зохион байгуулалтын асуудал, хүндрэлийг шуурхай олж тогтоон, олон нийтийн дэмжлэг, оролцоонд тулгуурлан зөв, оновчтой тактик, үйл ажиллагааг явуулан цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, хотын аюулгүй байдлыг хангах ажилд томоохон шинэчлэл, өөрчлөлт хийж үр дүн гаргах боломжтойг харуулж байна” гэжээ.

CompStat гэмт хэргийн хяналтын цогц системийг АНУ-ын Сан-Франциско, Лос-Анжелос, Филадилфиа, Мариланд, Балтиморе, Канад улсын Ванкувер хотын цагдаагийн газар зэрэг олон том хотууд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хэлэлцүүлэг

Судлаач Делорензи, Шэйн болон Амазела нар CompStat-ыг судалсан талаарх тайлан илтгэлдээ тэмдэглэхдээ “CompStat-ын үйл ажиллагаа нь удирдагчдыг хөгжүүлэх болон удирдлагын манлайллыг дээшлүүлэх боломжийг олгодог”. Түүнчлэн тэд дээрх илтгэлдээ удирдлагын гүйцэтгэлийн үүрэг, үр дүнг хөгжүүлэх асуудал болон CompStat-ын хурлын үеэр болон хэрэгжүүлэх үеийн удирдлагын манлайллын талаар онцлон дурдсан.

Дээрх байдлаар CompStat-ын үйл ажиллагааг хэрэгжүүлснээр удирдлагын чадавхыг нэмэгдүүлж, хувь хүмүүсийн хоорондын харилцаа, ойлголцлыг сайжруулах замаар байгууллагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хамтын оролцоотой болгож байна.

CompStat-ын арга хэлбэрүүдийг ашигласнаар удирдлагыг хөгжүүлж, зөв, чадварлаг удирдах ажилтнуудыг бий болгож, томилон ажиллуулснаар бүтээлч, хамтарч асуудлыг шийдвэрлэдэг соёл, нөхцөлийг бий болгож иргэд, оршин суугчдын аюулгүй байдлыг хангахын тулд зохион байгуулалтын өөрчлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой \р.2\.

Мөн судлаач Фордхэйм \2009\ дүгнэхдээ “CompStat нь дунд шатны удирдах ажилтнуудыг бүтээлч болон оролцоотой болохыг шахсанаар гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын зөв хандлага, үзэл санааг хөгжүүлэн дэмжсэн. Энэ нь мөн CompStat-ын амжилтын нэгэн гол түлхүүр хэсэг болох бүх шатны удирдлагууд, албан тушаалтнуудын дунд мэдээллийг шуурхай, бодитойгоор харилцан солилцож байх боломж, арга замыг нээж өгсөн явдал юм. \р.3\.

CompStat-ын хэрэгжилтийн амжилт, үр дүн нь дор хаяж 6 сараас 24 сарын хугацааны дараах гэмт хэргийн болон аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн статистик тоо баримт болон байгууллагын удирдлагаас өгч буй үнэлэлт, дүгнэлтээр хэмжигдэнэ. Тухайлбал гэмт хэргийн цахим зураглал болон статистик үзүүлэлтүүд тухайн нутаг дэвсгэр дахь гэмт хэргийн гаралт, түүний өсөлт бууралт, илрүүлэлтийн хувь болон тухайн цагдаагийн байгууллагын ажлын үр дүн хэр бодитой байгааг харуулах болно. Түүнчлэн гэмт хэргийн цахим зураглал нь хаана ямар байршилд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгааг болон ямар төрлийн гэмт ихээр гарч байгааг харуулах болно. Дээрх мэдээллүүдийг авч дүн шинжилгээ хийж нэгтгэн дүгнэснээр CompStat-ын үйл ажиллагаа нь дунд шатны нэгжийн \Дүүргийн газар хэлтсийн болон тодорхой гэмт хэргийн төрөл хариуцсан нэгжийн дарга нар\ удирдлагуудад ямар төрлийн гэмт хэрэгт, ямар байршил, газарт онцгой анхаарлаа хандуулах вэ, хаана ямар газар, цаг хугацаанд цагдаагийн байгууллагын хүн хүч, эргүүлийг зөв оновчтой байршуулах вэ, нууц, далд, тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулах эсэх, хяналт шалгалтын нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохиох эсэх болон оршин суугч, иргэдийн оролцоонд тулгуурласан урьдчилан сэргийлэх тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах олон бодит боломжийг олгодог.

CompStat нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах 2 зүйлийг нэгэн зэрэг хэрэгжүүлдэг.

1. Тодорхой асуудлыг илрүүлэх, тодорхойлж түүнийгээ хяналтад авах \ тухайлбал байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны доголдол эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн болон гэмт хэргийн нөхцөл байдал г.м\
2. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх болон иргэд, оршин суугчидтай хамтран ажиллах \Фордхэйм, 2009\.

Мөн судлаач Делорензи тэмдэглэхдээ” CompStat-ын үйл ажиллагааг богино үгээр товчлон тайлбарлавал -мэдээллийг цуглуул, дүн шинжилгээ хий, гэмт хэргийн гаралтыг цахим зураглалаар бүртгэ, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үндсэн үзүүлэлтээр хэмжиж, дүгнэ, цагдаагийн удирдлагуудын ажлын үр дүнг гарч ирж буй үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэ. Энэхүү тайлбар тодорхойлолт нь бүх шатны цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнг тооцох үлгэрчилсэн

загвар болж байна” гэжээ. Түүнчлэн тэрээр CompStat-ын үндсэн үйл ажиллагааны онолын маргашгүй зүйл бол” Зөв чиглүүлэх болон хэрэгжилтийг хянах” явдал бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэргийн нөхцөл байдлыг хянахад ихээхэн үр дүнтэйг харуулсан болохыг онцлон тэмдэглэсэн.

АНУ-ын Лос-Анжелос хотын Цагдаагийн газрын CompStat-ын үйл ажиллагааг хариуцсан ажилтан, шинжээч Жеф Годовн \Jeff Godown\ Делорензигийн багийн дээрх тайлбар, дүгнэлтийг дэмжсэн ба тэрээр онцлохдоо “CompStat-ын үйл ажиллагааны бодит байдал бол зөвхөн ямар нэгэн орчин үеийн тусгай программ хангамж, компьютер биш. CompStat нь менежментийн үйл ажиллагааны үр дүнг тооцох механизм, арга барил ба гэмт хэргийн нөхцөл байдлыг хянах философи юм. CompStat нь асуудлыг түргэн шийдвэрлэх хариулт биш харин сайтар зохион байгуулагдсан итгэл, үнэмшил, зүй зохицол, хатуу чанд удирдлагын манлайллын үр дүнд гэмт хэргийн гаралтыг хангалттайгаар бууруулж эерэг үр дүн авчрах явдал юм” гэж дүгнэсэн. Түүнчлэн тэрээр “CompStat нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны менежментийн олон талт тогтолцоо юм. АНУ-ын болон дэлхийн олон улс орнуудын хууль сахиулах байгууллагуудын хэрэгжүүлсэн туршлагаар CompStat нь тухайн байгууллага, нэгжийн урдаа тавьсан зорилго, зорилтод хүрэхэд тусалдаг шинэчлэн сайжруулсан ажил хэргийн удирдлагын процесс, тогтолцоо, стратегийн арга зүй юм. Арга хэлбэрүүд нь шилжин хувьсах чадвартай, ямар ч байгууллага, орчин нөхцөлд тохирох, хэрэглэж болохоор байна.

CompStat-ын бас нэг үүрэг нь гэмт хэргийн хяналтын үйл явцыг 7 хоног бүр зохион явуулдаг CompStat-ын хуралдаанаар илэрхий тодоор харуулж танилцуулах явдал бөгөөд ингэснээр тухайн байгууллагаас хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ нь ямар үр дүнд хүрч байгааг болон цаашид юуг сайжруулах, ямар асуудалд анхаарах ёстой вэ гэдгийг тодорхойлж өгдөг. Энэхүү тухайн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үзэл баримтлал, үндсэн зарчим болон хэрэглэх аргууд нь нийлээд тухайн байгууллага, нэгжийн бүх шатанд асуудлыг шийдвэрлэх, хариуцлага, үр дүнг тооцох арга замууд болж өгдөг” хэмээн өөрийн дүгнэлтээ хуваалцсан байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны явцад CompStat-ын үйл ажиллагааг нэвтрүүлж ашигласнаар Нью-Йорк, Ванкувер зэрэг дэлхийн олон метрополис хотуудад үр дүн гарч, амжилт дагуулсныг харж болох ба CompStat нь Хойд Америкийн олон томоохон хотуудад үр дүнтэй хэрэгжиж, тухайн цагдаагийн газар, нэгжүүдийн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа, арга хэлбэрт ахиц дэвшил, үр дүнгээ өгсөн байна гэж үзэж болохоор байна.

Ялангуяа энэхүү гэмт хэргийг хянах арга хэлбэр нь цагдаагийн байгууллагын удирдлагын манлайллын хөгжилд, тухайлбал бодит статистик, мэдээлэлд үндэслэн тулгамдаж буй асуудлыг олж тодорхойлох, үүн дээр үндэслэн хууль эрх зүйн хүрээнд шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэхэд үр дүнгээ өгсөн байна.

Судлаач Годовн нь CompStat-ын ашиг тус, үр дүнг тодорхойлон хэлэхдээ “ Асуудлыг шийдвэрлэх загвар хэлбэрийн хүрээнд CompStat-ын үйл ажиллагаа нь шийдвэр гаргагч, удирдлагуудыг бий болоод байгаа асуудлыг олж тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг боловсруулан хэрэгжилтийг хангах, мөн гарч буй үр дүн, түүний үр ашигтай ажиллаж байгаа байдалд дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх явдал юм.

Энэхүү хэлбэр, загварыг бий болгож буй үйл ажиллагааны менежментийн үндсэн 4 зарчмаас бүрдэх ба эдгээр нь нийлээд гэмт хэргийн гаралтыг бууруулах болон тухайн байгууллагын төсөв, санхүүг үр ашигтайгаар зарцуулах боломжийг олгодог.

Годовн дээрх 4 төрлийн зарчмыг дараах байдлаар тодорхойлсон.

- Нарийвчилсан болон тодорхой цаг хугацааны мэдээлэл. Ингэснээр хаана, хэзээ, юу болж байгааг мэдэх

- Оновчтой, үр дүнтэй тактик. Урьдчилан сайтар төлөвлөсөн байх
- Шуурхай томилгоо, гүйцэтгэлүүд. Түргэн хэрэгжүүлэх, хурдтай байх
- Авч буй ажил, арга хэмжээгээ эцсийн үр дүнг тооцох, дүгнэх хүртэл хэрэгжүүл. Хэрвээ амжилттай хэрэгжиж үр дүн гарч байвал цааш нь улам төгөлдөржүүлэн хэрэгжүүлэх, харин үр дүн гарахгүй байвал өөр тохирсон үйл ажиллагаа явуулах.

CompStat-ын үйл ажиллагаа нь өнөө цагийн болон өнгөрсөн үеийн нийгмийн дэг журмыг сахиулах, хотын аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн гаралтыг бууруулах, хяналтад авах зэрэг олон арга зүйн хэлбэрийг агуулсан шилдэг, арга, туршлага юм. Энэ нь үр дүнтэй цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын хувилбарууд, зарчмууд болон олон нийтийн оролцоонд тулгуурласан болон асуудлыг олж тодорхойлон, шийдвэрлэх зарчмууд буюу “Хагархай цонх”-ны /Broken windows/ онолуудын хэрэгжилтийг багтаасан байна. Энэ нь үнэлгээ, хяналт шалгалт, хөндлөнгийн хяналт, судалгаа, дүн шинжилгээ, мэдээлэл дамжуулах болон цуглуулах цогц үйл ажиллагаа юм \Годовн. 2009\.

Дээрх судлаачдын CompStat-ыг судалсан судалгааны дүгнэлт, түүний үр дүнгийн талаарх тодорхойлолт, тайлбарууд болон судлаачийн Монголын цагдаагийн байгууллагад шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх шатанд ажилласан ажлын туршлага, түүнд тулгуурласан дүгнэлтээс үндэслэн дүгнэхэд CompStat-ын зарим арга, хэлбэрүүд нь нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад болон Нийслэлийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй тохирч ажиллах боломжтой.

Ерөнхийдөө судлаачаас CompStat-ын үндсэн арга хэлбэрүүд болох гэмт хэргийн цахим зураглал, дүн шинжилгээ, эдгээрт тулгуурласан 7 хоног бүрийн CompStat-ын хуралдаан \ рапорт\-д онцгой анхаарлаа хандуулж эдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал бодит мэдээ, мэдээллийг цуглуулж түүнд хийсэн дүн шинжилгээгээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх, гол нь гэмт хэргийн гаралтыг бууруулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг оновчтой, хүртээмжтэй болгох, иргэд, оршин суугчдын аюулгүй байдлыг хангах явдалд бодит үр дүн гарна гэж үзэж байна.

Нөгөөтээгүүр CompStat-ын хэрэгжилт нь цагдаагийн байгууллагын нэгж, дүүргийн дарга нарын удирдлагын манлайлалд ихээхэн ахиц, дэвшил авчрах ба тухайлбал тухайн нэгжийн дарга нар нь өөрийн хариуцсан цагдаагийн байгууллагыг хэрхэн илүү үр ашигтайгаар удирдах, тэдний үүрэгт ажлаа хэрэгжүүлэх чадвар сайжрах, түүнчлэн байгууллагын удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааг илүү оновчтой, шинэлэг болгож бүтээлч менежерүүдийг бий болгоно.

Мөн CompStat-ын үйл ажиллагаа нь нутаг дэвсгэр, нэгж хариуцсан удирдах ажилтнуудыг чадавхжуулах, тэднийг шуурхай шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх чадварыг сайжруулна.

Улаанбаатар хотын гэмт хэргийн нөхцөл байдал болон гэмт хэргийн статистик үзүүлэлтүүд нь нийслэл хотод шинэ, үр дүнтэй, илүү сайжруулж, технологижсон гэмт хэрэгтэй тэмцэх цогц үйл ажиллагааг шаардаж байна.

Мөн одоо Улаанбаатар хотын цагдаагийн газарт болон хотын аюулгүй байдлыг хангахад ашиглаж байгаа арга, хэлбэрүүдийг CompStat-тай нийлүүлж, тааруулж хэрэглэж болно. Хэрэв ингэж ажиллуулж чадвал хотын гэмт хэргийн нөхцөл байдалд хийж буй мониторинг, дүн шинжилгээ болон тавих хяналт сайжрах болно.

CompStat нь хууль сахиулах болон цагдаагийн байгууллагад илүү их нарийвчилсан, тодорхойлон дүрсэлсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг бэлтгэж өгөх ба ингэснээр тухайн нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх илүү оновчтой үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх боломжтой.

Энэхүү судалгаанд үндэслэн CompStat гэмт хэргийн хяналтын цогц системийг Улаанбаатар хотод хэрэгжүүлж ажилласнаар цагдаагийн байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлж, үнэлэх үнэлэмж оновчтой болж, гэмт хэргийн болон нөхцөл байдлын бодит судалгаа, мэдээлэл, дүн шинжилгээ, үр дүнтэй, оновчтой, шинэлэг,

технологид тулгуурласан гэмт хэргийн нөхцөл байдлыг хяналтад авах, гэмт хэргийн гаралтыг бууруулах, тодорхой асуудлыг цаг алдалгүй олж харан, шийдвэрлэхэд чиглэсэн стратеги, тактик, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил авчрах боломжтой.

Ном зүй

- Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2020
- Статистик мэдээллийн нэгдсэн сан. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_071V3
- University of Regis. By Erdenebold Jamiyansengee. Proposal for the application the CompStat-Crime reduction management program to the Ulaanbaatar police department of Mongolia. A Research Project Presented in Partial Fulfillment of the Requirements for the Degree
- Willis, J., Mastrofski, S., & Weisburd, D. (2004). *CompStat in Practicve: An in Depth Analysis of three cities.* Retrieved from: http://www.policefoundation.org
- Trochim, W., & Donnely J. P, (2011). *The Research Methods knowledge base.* (3rd ed).
- Mason. USA. Gengage learning.
- Delorenzi, D. (2006). The CompStat Process: Managing Performance on the Pathway to Leadership. The Police Chief Magazine. May 2012.
- Henry, V. E. (2007). CompStat management in the NYPD: Reducing crime and improving quality of life in New York City. Retrieved from: http// www. unafei.org
- Jeff Godown (2009). The CompStat Process: Four Principles for Managing Crime Reduction, The Police Chief. Retrieved from: http://www.policechiefmagazine.org/magazine
- Federal Bureau of Investigation (2005). Uniform Crime Reports, Crime in the United States, 2003.Retrieved January 3, 2005 from Federal Bureau of Investigation website: http//:www.fbi.gov/
- Robert Zink (2004). The Trouble with Compstat. Retrieved from: http://www.nycpba.org/publications/mag-04-summer/compstat.html

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Б.Батбаяр
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн дэслэгч

Товч агуулга. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүний шалтгаан, нөхцлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга замын талаар санал боловсруулсан.

Түлхүүр үг. Бага насны хүүхэд, хүчиндэх гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил.

Удиртгал

Монгол Улсын хүн амын 46.6 хувийг хүүхэд эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хүүхдийн эсрэг гэмт хэргийн гаралт өсөж, хүүхэд хүчирхийлэлд өртөх явдал нэмэгдэж байгаагаас үзэхэд, хүүхэд хамгаллын төрийн бодлого, тогтолцоо хангалтгүй байгааг илтгэнэ.

Хүүхдийн эрхийн зөрчлийн ноцтой хэлбэр нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг”-ийг хуульчилж өгсөн. Гэвч хүүхэд, түүн дотор бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн гаралт тогтвортой буурахгүй байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна.

Хүчиндэх гэмт хэргийн түвшин (2009-2020), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд дунджаар 345, сард 29, хоногт 1 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.[35] Үүнээс 2019 онд хүчиндэх гэмт хэрэг улсын хэмжээнд 481 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 38 хэргээр буюу 7.3 хувиар буурчээ. Нийслэлийн хэмжээнд 55 хэргээр буюу 20.4 хувиар буурсан, орон нутгийн хэмжээнд 18 хэргээр буюу 7.2 хувиар өссөн байна.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн байдал

2019 онд 338 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 34 буюу 11.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Холбогдогчдын 3 буюу 0.9 хувь нь эмэгтэй, 335 буюу 99.1 хувь нь эрэгтэй, тэдний 24 буюу 7.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс хэрэгт холбогдсон эрэгтэй 10.9 хувиар, эмэгтэй 50.5 хувиар тус тус өсөж, хүүхэд 20 хувиар буурсан байна.

[35] Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 176 дахь тал

Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогсдын тоон үзүүлэлт

2019 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 487 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 119 буюу 32.3 хувиар өссөн байна. Үүнээс 2 хүн нас барж, 89 хүний эрүүл мэндэд хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 1 буюу 2 дахин өсөж, эрүүл мэндэд хохирол учирсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

№	Үзүүлэлт		Хугацаа				Өсөлт, бууралт[36]		Хугацаа		Өсөлт, бууралт	
			2015 он	2016 он	2017 он	2018 он	Тоо	Хувь	2019 оны эхний 8 сар	2020 оны эхний 8 сар	Тоо	Хувь
1	Хүчиндэх гэмт хэрэг		279	290	376	519	143	38.0	385	285	100	-26.4
2	Хүчиндэх гэмт хэргийн хохирогч		287	295	368	487	119	32.3	386	290	96	-24.8
3	Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг		134	140	183	235	52	28.4	134	153	19	14.1
4	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/		139	143	187	238	51	27.3	137	160	23	16.7
5	Үүнээс	0-7 нас	7	18	20	20	0	0.0	6	9	3	50.0
6		8-13 нас	47	45	59	91	32	54.2	26	39	13	50.0
7		14-17 нас	85	80	108	127	19	17.6	45	64	19	42.2

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл амьдрахын халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг нийгэмд хор аюул их учруулдаг гэмт хэрэг юм. Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1437 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсжээ. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал 2015 онд 134 гэмт хэрэгт 139, 2016 онд 140 гэмт хэрэгт 143, 2017 онд 183 гэмт хэрэгт 187, 2018 онд 235 гэмт хэрэгт 238, 2019 онд 134 гэмт хэрэгт 137, 2020 оны эхний 8 сарын байдлаар 153 гэмт хэрэгт 160 хүүхэд тус тус

[36] Сүүлийн 2 жилийн байдлаар

хохирчээ. **Үнээс 2015 онд 54, 2016 онд 63, 2017 онд 79, 2018 онд 111, 2019 онд 32, 2020 оны эхний 8 сарын байдлаар 48 бага насны хүүхэд хохирсон байна.**[37]

Гэмт этгээдүүд ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай бага насны хүүхдийг биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байгааг далимдуулан хүч хэрэглэн заналхийлэх аргаар хүчиндсэн байна. Эцэг, эхдээ болон бусдад хэлбэл ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна хэмээн заналхийлж, бага насны хүүхдийг хүчиндсэн байх бөгөөд хохирогч айж эмээсний улмаас гэмт этгээдийн үйлдлийг нууж өнгөрдөг нь дахин хүчиндүүлэх, цаашид удаан хугацаанд энэ гэмт хэргийн халдлагад өртөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Бага насны хүүхдийг хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн тохиолдол цөөнгүй хувийг эзэлж байна. Тухайлбал, судалсан хэргийн дийлэнх хувийг хохирогч хүчиндүүлсний улмаас жирэмсэн болсноор гэмт хэрэг илэрсэн байх бөгөөд хэрэв хохирогч жирэмсэн болоогүй бол тэр хэрэг илрэхгүй байх магадлал өндөр юм.

Бага насны хүүхдийг хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэлсэн тохиолдолд бүгд (100 хувь) үр хөндүүлсэн байгаа нь хохирогчийн цаашдын эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны хөгжилд асар хортой талаар мэргэжлийн эмч хэлдэг. Мөн хохирогчийг хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчин халдаасан тохиолдолд бага насны хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн хохиролтой бөгөөд хохирогч хүчиндүүлсний улмаас сэтгэцийн өвчтэй болсон, амиа хорлосон, амиа хорлохоор завдсан, хүчиндүүлснээс хойш бусадтай замбараагүй бэлгийн харьцаанд орсон явдал түгээмэл байна. Тухайлбал, насанд хүрээгүй хохирогч Ц.Б нь хойд эцэг С.С-д 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд удаа дараа хүчиндүүлсэн. Хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтээ "...Намайг харж хамгаалах ёстой хүн С.С-д хүчиндүүлсэндээ гутарч, сэтгэл санаагаар унасандаа асрамжийн газрын галч А.С, харуул К.Х нартай бэлгийн харьцаанд орсон." гэжээ.[38]

Учирсан хохирол

Хүчиндэх гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 482.6 сая төгрөгийн хохирлын 66.1 хувийг нөхөн төлүүлж, 65.9 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ.

Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг юуны өмнө дотоод буюу субъектив, гадаад буюу объектив хүчин зүйл гэж ангилж болно. Объектив хүчин зүйлд ядуурал, ажилгүйдэлт, сургууль завсардалт, эцэг, эхийн хайр халамж дутах, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчийн таагүй харьцаа, найз нөхдийн сөрөг нөлөө зэрэг хамаарна.

Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь нэгдүгээрт гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн таагүй орчин, хоёрдугаарт эцэг эхийн хараа хяналт сул байдал, гуравдугаарт хүүхэд хамгааллын тогтолцоо бүрэн бүрдэж, үйл ажиллагаа нь жигдрээгүй, дөрөвдүгээрт ахуйн хүрээний архидалт, тавдугаар нийтийн сүлжээний хяналтгүй байдал, зургаадугаарт гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал /боловсролын түвшин, эрхэлсэн ажилгүй, хувь хүний төлөвшил, ёс суртахуун/, долоодугаарт хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг байна.

Энэ оны эхний найман сарын байдлаар гэмт хэргийн улмаас 762 хүүхэд хохирсон бөгөөд эдгээрээс 82 хүүхэд нас барж, 290 нь гэмтсэн аж. Мөн тус хугацаанд улсын хэмжээнд 162 хүүхэд бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болжээ.

Гэтэл үүнийг зарим үед торгох ял шийтгэлтэй гэж буруу ташаа ойлгогдохоор мэдээллийг цацдаг. Нөгөө талд энэ ташаа мэдээллийг сонссон янз бүрийн санаа

---

[37] С.Гантулга, Б.Энхболд, Б.Мөнхзул. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ" бодлогын судалгааны тайлан. УБ., 2020 /Нээлттэй нийгэм форум/. 35 дахь тал

[38] Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар шийтгэх тогтоол

зорилготой хүмүүс гэмт хэрэг үйлдэхээр зэхэж байдаг юм. Жишээ нь нэг аймагт 10 настай охин хүчиндүүлсэн гэх мэдээг "ийм хэрэг гарчээ" л гэж мэдээлдэг бөгөөд уг хэрэг хэрхэн шийдэгдсэн талаар огт мэдээлдэггүй. Тухайн этгээд нь Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдээд, хариуцлага хүлээж байхад хариуцлагын асуудал яригддаггүй.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллага нягт хамтран ажиллаж, иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан олон талт арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай. Тухайлбал,

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам хамтран гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, гэр бүл салалтаас үүсэх үр дагаврын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутан, хугацаат цэргийн алба хаагч нарт сургалт явуулах ажлыг тогтмолжуулах;
- Хүүхдийн эрхийн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахад чиглүүлэх, ажлын үр дүнг тооцож, ажиллах;
- Садар самуун явдал, биеэ үнэлэх, хардалт, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернет орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах;
- Бага насны хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрх бүхий байгууллага, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, гэр бүлийн гишүүдэд цаг алдалгүй хандах талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар мэдээлэл хүргэх зэргийг хэлж болохоор байна.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллага хамтрах, иргэдэд тулгуурласан олон талт арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах хэрэгтэй. Хамгийн гол нь гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх нь чухал байна.

Санал

- Цагдаагийн байгууллагад “Хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгж” байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.
- Сэтгэл зүйн байдлаас хамаарч гэмт хэрэгт өртсөн хүүхэдтэй ажиллахдаа мэргэшсэн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ажиллуулах.
- Ерөнхий боловсролын сургуульд “Хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-г байгуулах, “Өсвөрийн цагдаагийн бүлэг”-ийг нээх. Сургууль цэцэрлэгийн захиргааны оролцоог нэмэгдүүлэх.

- Нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран хүүхдийн дуу хоолойг сонсох, “Хүүхдэд нээлттэй өдөр”-ийг сар тутам явуулж хэвших, хүүхдэд тулгамдсан асуудлыг хүлээн авч шийдвэрлэж байх.
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж зар түгээх зэрэг ажлыг зохион байгуулах.

Ном зүй

- Н.Гаваасүрэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба цагдаагийн байгууллага. УБ., 2013
- А.Отгонбаяр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоо. УБ., 2011
- Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааны тайлан. УБ., 2020 /Нээлттэй нийгэм форум/.
- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал. Гэр бүл хүчирхийлэл, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэргийн оролцоо, нөлөөлөл, чиг хандлага. УБ., 2014

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Г.Гантөмөр
Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор

Товч агуулга. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулан судалж, санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үгс. Гэмт хэрэг, хөөн хэлэлцэх хугацаа, эрүүгийн хууль тогтоомж, эрх зүйн бүл.

Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацааны нэг төрөл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа юм.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа нь зөвхөн материаллаг эрх зүй болох эрүүгийн эрх зүйд төдийгүй процессын эрх зүй – эрүүгийн процессын эрх зүйд онолын болон практик ач холбогдол бүхий ойлголт, судлагдахуун, институт мөн.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны үндэсний эрх зүйн зохицуулалтын асуудал манай улсын эрүүгийн эрх зүйд сурах бичиг, нэг сэдэвт бүтээлийн хүрээнд харьцангуй судлагдсан[39] боловч уг асуудлыг гадаадын орнуудын Эрүүгийн хуульд хуульчилсан байдлыг тусгайлан судалсан бүтээл одоогоор байхгүй байна.

Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгох зорилгоор гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн үүднээс судлах хэрэгцээ, шаардлага илүүтэй тавигдаж байгаа билээ.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд өөр өөр эрх зүйн бүлийн төлөөлөл болгон 30 гаруй улсын эрүүгийн хууль тогтоомжийг судалсан бөгөөд үр дүнг дараах байдлаар тоймлон авч үзэж байна. Үүнд:

1.Хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хууль тогтоомжид хуульчилсан байдал. Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд хэргийг хөөн хэлэлцэх хугацааг өөр өөрийн онцлогтойгоор холбогдох хууль тогтоомжид хуульчилсан ба хэрхэн хуульчилсан байдлаас нь хамааран хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа хуульчилсан, Эрүүгийн процессын хуульдаа хуулчилсан гэж ангилж болохоор байна.

Ихэнх улс /Азербайджан, Армен, Украйн, Беларусь, Молдов, Казакстан, Кыргызстан, Узбекистан, Гүрж, Тажикстан, Туркменистан, ОХУ, БНХАУ, Монгол, Тайланд, Австри, Болгар, Польш, ХБНГУ, Голланд, Швед, Швейцари, Турк, Аргентин/ гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа зааж өгчээ.

Эдгээрээс ОХУ болон ТТУХН-ийн гишүүн дийлэнх улсууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн "*Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх",* Аргентин улс "*Эрүүгийн хариуцлага /ял/ хүлээлгэж болохгүй байдал",* Болгар, Голланд, Дани, Турк улсууд *"Гэмт хэргийн үр дагавар арилах"* гэсэн бүлэгт хуульчилсан бол Австри, Герман, Польш, Швейцари, Тайланд улс *"Хөөн хэлэлцэх хугацаа"* гэсэн бие даасан бүлэгт шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй

[39] Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс. Ерөнхий анги. УБ.1973 он, С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ. 1999 он, С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. II боть. Ялын тухай сургааль. УБ.2014 он, Г.Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги. УБ., 2020 он, Г.Гантөмөр, О.Амарсайхан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа. УБ., 2004 он.

хугацааны хамт хуульчилсаны зэрэгцээ, хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх гэмт хэргүүд, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журмыг нарийвчлан зааж өгсөн нь илүү оновчтой зохицуулалт болсон гэж үзэж байна.

Харин Франц, Бельги, Израйль, Япон, Солонгос зэрэг улс гэмт хэргийг хөөн хэлэлцэх /эрүүгийн хариуцлагад татах/ хугацааг Эрүүгийн хуульд зааж өгөөгүй, эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны өөр нэг төрөл болох шүүхийн шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацааг зааж өгсөн нь ихээхэн анхаарал татаж байна. Дээрх орнуудад хэргийг хөөн хэлэлцэх хугацааг *эрүүгийн журмаар мөрдөн шалгах /мөшгих/ хугацаа* хэмээн тодорхойлж, түүнийг процессын агуулгаар нь Эрүүгийн процессын хуульд тодорхойлжээ. Тухайлбал, Япон Улсын Эрүүгийн процессын хуулийн 2 дугаар хэсгийн *"Прокурор яллах*" гэсэн 2 дугаар бүлгийн 250 дугаар зүйлд "Цаазаар авах ялтай хүн амины хэргээс бусад хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй. Үүнд:

- Цаазаар авах ялтай бусад гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил,
- Хугацаагүйгээр хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 25 жил,
- 15 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил,
- 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 7 жил,
- 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил,
- 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 3 жил,
- Баривчлах, торгох ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол..."[40] гэж заасан байна.

Англи-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд бус, процессын хуульд заадаг нь уг эрх зүйн бүлийн жишиг юм. Бидэнд биетээр байгаа Австралийн Холбооны Улсын Эрүүгийн хууль, АНУ-ын Техас муж улсын Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг заасан хэм хэмжээ байхгүй.

Харин АНУ-ын зарим муж улсын хууль тогтоомжид мисдиминор ангилалын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 2 жил байхаар заасан тухай энэ чиглэлээр гарсан зарим бүтээлд дурджээ.[41]

Мусульманы шашинт орнуудын Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зааж өгөөгүй, зааж өгөөгүйн учир нь Мусульманы шашны ариун, үнэт зүйлд халдсан ноцтой гэмт хэрэг, ялангуяа худуд, тазир ангиллын хэрэг нь хэзээ үйлдсэнээс үл хамаарч нүгэл, муу зан үйлд тооцогддогтой холбоотой. Харин зарим оронд /Сири, Иорданий/ зөвхөн шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа буюу ялыг эдлүүлэх хугацааг заасан байдаг.[42]

2.Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлсон нэр томъёо. Судалгаанд хамрагдсан орнуудын Эрүүгийн хуульд судалж буй ойлголт, ухагдахууныг хуульчлахдаа өөр өөр нэр томъёо хэрэглэсэн байна. Хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан болон социалист системийн орнуудад хамаарч байсан ихэнх улсуудын Эрүүгийн хуульд *"хэргийн хөөн хэлэлцэх хугацаа", "эрүүгийн хариуцлагад татах хугацаа*", *"эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа"*, Литва, Швед улсад *"Ял оногдуулж болохгүй хугацаа"*, Польш, Дани улсад "*эрүүгийн хэргийн ял хүлээх үр дагавар арилах хугацаа"* гэсэн материаллаг эрх зүйн үүднээс нэр томъёо хэрэглэсэн бол Ром-Германы эрх зүйн бүлийн зарим орнууд, тухайлбал, Голланд, Австри,

[40] www.http://law.e-gov.go.jp/htmldata-S23/S23HO131.html
[41] В.Н.Додонов. Сравнительноле уголовное право. Учебник.изд.Юрлитинформ.М.2009 г. стр 392
[42] Г.Ф.Елаян. Основы мусульманского уголовного права. Учебное пособие. Махачкала. 2002 г. стр 72-73

Аргентин, Швейцари, Турк болон Тайланд улсад процессын эрх зүйн утгаар "*эрүүгийн журмаар мөрдөн шалгах хугацаа", "эрүүгийн журмаар мөрдөн мөшгих хугацаа",* Япон улсад *"яллагдагчаар татаж болохгүй хугацаа"* гэсэн нэр томъёогоор хууль тогтоомждоо тодорхойлсон байдаг.

3.Хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо баримталсан шалгуур, үндэслэл.

Судалгаанд хамрагдсан орнууд хэргийг хөөн хэлэлцэх тогтоохдоо:

а.Гэмт хэргийн ангилал

б.Гэмт хэргийн төрөл /хэргийн өнгө/

в.Гэм буруугийн хэлбэр

г.Гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл

д.Гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан тодорхой ялын хэмжээ гэсэн 5 шалгуурыг харгалзан тогтоосон нь харагдаж байна.

Хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэргийн ангилалыг харгалзан тогтоосон орнууд. ОХУ болон ТТУХН-ийн гишүүн ихэнх орнуудын Эрүүгийн хуульд[43] хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн 4 ангилалыг шалгуур болгон хуульчилсан юм. Үүний учир нь 1995 онд батлагдсан ТТУХН-ийн гишүүн орнуудын *"Эрүүгийн загвар хууль"*-ийн 77 дугаар зүйлд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дээрх шалгуураар хуульчилсан зөвлөмжийг баримтлан гишүүн орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ижил төстэй байдлаар хуульчилсан байдагт оршино. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлд "Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

а.Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 2 жил

б.Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш 6 жил

в.Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил

г.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн бол..." гэж заажээ.[44]

Харин Молдова Улсын Эрүүгийн хуулийн 60 дугааар зүйлд:

а.Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 2 жил

б.Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил,

в.Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил

г.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил

д.Туйлын /онцгой/ хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 25 жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнөгэж хэргийн хөөн хэлэлцэх 5 хугацааг заажээ.[45]

Мөн ТТУХН-ийн гишүүн бус ч хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэргийн ангилалыг шалгуур болгосон бусад орнууд бий. Жишээ нь: Эстони улсын Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд "Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурьдсан хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй" гээд хөөн хэлэлцэх хугацааг

а.Гуравдугаар зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 2 жил өнгөрсөн,

б.Хоёрдугаар зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 5 жил өнгөрсөн.

в.Нэгдүгээр зэрэглэлэийн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн бол гэж заасан байдаг.[46]

***Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжэээнээс хамаарч хуульчилсан орнууд*:** Ийм орнуудад Австри, Аргентин, Болгар, Герман, Дани, Швейцари, Турк, Тайланд, Хятад, Япон зэрэг улс хамаарна.

---

[43]Литва, Эстони, Гүрж улсыг эс тооцвол. Зохиогч

[44] Уголовный кодекс Российской Федерации / по состоянию на 01.09.1916 года/. М. Изд. Проспект. 2014 г.

[45]Молдов улсын Эрүүгийн хуулийн 16-р зүйлд зааснаар гэмт хэргийг нийгмийн хор аюулын шинжээр 5 зэрэглэлд ангилдаг. Уголовный кодекс Республики Молдова. г.Кишинев. 2003 г. стр 6

[46] Уголовный кодекс Эстонской Республики. Изд Юридический Центр Пресс. СПб. 2001г. стр 34

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн V хэсгийн *“Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа”* гэсэн 1 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд:

- Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн,
- Арваас дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн,
- Таваас доошгүй арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,
- Нэгээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,
- Нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу бусад төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 3 жил өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар тогтоожээ.[47]

Тайландын Вант Улсын Эрүүгийн хуулийн *“Хөөн хэлэлцэх хугацаа”* гэсэн 9 дүгээр бүлгийн 95 дугаар зүйлд зааснаар

- Цаазаар авах, бүх насаар нь хорих болон хорин жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн,
- Долоогоос дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,
- Нэгээс жилээс дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,
- Нэг сараас дээш нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,
- Нэг сар хүртэл хугацаагаар хорих эсвэл өөр төрлийн ялаар шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол эрүүгийн журмаар мөрдөн шалгахгүй, шүүхэд татагдахгүй[48].

Мөн манай урьд хөрш БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг тухайн хэрэгт тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээнээс хамааран:

- 5 жил хүртэлх хорих ял шийтгэлээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,
- 5-10 жил хорих ял шийтгэлээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,
- 10 жилээс дээш хугацаатай хорих ял шийтгэхээр заасан ял гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,
- Хугацаагүй хорих ял, цаазаар авах шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн байхаар тогтоосон юм.[49]

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг заахдаа холимог шалгуурыг хэрэглэсэн орнууд: Ийм орнууд нь хэргийн хөөн хэлцэх хугацааг дээр дурьдсан гэмт хэргийн ангилал, гэмт хэргийн төрөл /хэргийн өнгө/, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ зэрэг 2-3 шалгууруудыг үндэслэн тогтоосон байх ба Литва, Гүрж, Польш, Голланд зэрэг орнуудыг нэрлэж болно. Тухайлбал, Голланд Улсын Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд эрүүгийн журмаар мөрдөн шалгах хугацааг заасан ба дор дурьдсан хугацаа өнгөрсөн бол мөрдөн шалгаж болохгүй.

а)Эрүүгийн зөрчил үйлдсэн бол 2 жил өнгөрсөн,

б)Торгох ял болон 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 6 жил өнгөрсөн,

---

[47] Уголовный кодекс ФРГ. Изд МГУ.М.1996 г. стр 60.
[48] Уголовный кодекс Тайланда. Изд Юридический Центр Пресс.СПб.2005 г. стр 68-69
[49] Уголовный кодекс КНР. Изд Юридический Центр Пресс.СПб.2001 г. стр 52-53

в)3-10 жил хорих ял оногдуулсан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 12 жил өнгөрсөн,

г)10 жилээс дээш хугацаатай хорих ялаар шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

д)Бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 18 жил өнгөрсөн бол гэж зааснаас үзэхэд гэмт хэргийн ангилал[50], гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээг шалгуур болгосон нь харагдаж байна.

Мөн Литва улсын Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлд:

а.Эрүүгийн зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн,

б.Болгоомжгүй гэмт хэрэг эсвэл хөнгөн болон хүндэвтэр гэмт хэргийг санаатай үйлдсэнээс хойш 4 жил өнгөрсөн,

в.Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 8 жил өнгөрсөн,

г.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 12 жил өнгөрсөн,

д.Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн бол ял оногдуулж болохгүй." гэж хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа гэмт хэргийн ангилал, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн төрөл гэсэн 3 шалгуурыг удирдлага болгосон байх жишээтэй.[51]

4. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны төрөл, хэмжээг тогтоосон байдал. Гадаадын улс орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа төрөл, түүний доод дээд хэмжээг харилцан адилгүй хуульчилсаныг харж болно.

ОХУ болон ТТУХН-ийн гишүүн зарим орнууд, Хятад, Монгол, Дани улс гэмт хэргийн ангиллаас хамааран хөөн хэлэлцэх төрлийн 4 хугацааг заасан бол Австри, Аргентин, Болгар, Герман, Голланд, Польш, Литва, Молдов, Тайланд - 5, Итали, Турк - 6, Эстони, Швейцарь хамгийн цөөн буюу 3, Испани, Сан-Марино, Япон хамгийн олон буюу 7 хугацааг зааж өгчээ.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хэмжээг /доод ба дээд хэмжээг/ заасан байдлыг авч үзвэл Латви 6 сараас 15 жил, Туркэд 6 сараас 25 жил, Австри, Испани, Тайланд 1 жилээс 20 жил, Эстони 5 жилээс 10 жил, Аргентин, Армен, Беларусь, Дани, Казакстан, Кыргызстан, Литва, ОХУ, Украйн, Тажикстан, Туркменистан 2 жилээс 15 жил, Голланд 2 жилээс 18 жил, Швейцари, Хятад 2 жилээс 20 жил, Молдов, Норвеги, Гүрж, Швед 2 жилээс 25 жил, Польш 1 жилээс 30 жил, Герман 3 жилээс 30 жил, Болгар 2 жилээс 35 жил гэх мэтээр тогтоосон байх ба дундажаар авч үзвэл доод хэмжээ нь хэмжээ 2 жил, дээд хэмжээ нь 15-20 жил байна.

5. Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх нөхцөл /хэргүүд/.

Судалгаанд хамрагдсан орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчилахдаа хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тохиолдол, гэмт хэргүүдийг харилцан адилгүй зааж өгчээ.

1968 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр НҮБ-аас баталсан *"Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай"* Конвенци, 1974 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн "*Хүн төрөлхтний эсрэг болон цэргийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай* Европын конвенци, 1998 оны "*Олон улсын Эрүүгийн шүүхийн /Ромын/ дүрэм"*-ийг соёрхон баталсан, нэгдэн орсон улс орнууд энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тухай заалтыг үндэсний хууль тогтоомжид хуульчилжээ. Ийм зохицуулалт Беларусь улсын Эрүүгийн хуульд бие даасан зүйл буюу 85 дугаар зүйлд, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Молдов улсын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Кыргызстан улсын Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг[52], Болгар улсын Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт бий.

Зарим орны Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхүй байх ердийн эрүүгийн хэргийг заасан нь манай улсын эрүүгийн эрх зүйд судалж үзэх туршлага байж болох талтай. Тухайлбал, Япон Улсын Эрүүгийн процессын хуулийн 250 дугаар зүйлд

---

[50] Голланд удсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгийг эрүүгийн зөрчил, гэмт хэрэг гэж хоёр ангилдаг. Уголовный кодекс Голландии. Изд Юридический Центр Пресс. СПб. 2001г. стр 190-191

[51] Уголовный кодекс Литовской Республики. Изд Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 19

[52] Уголовный кодекс Кыргызской Республики. Бишкек. 2003 г.

цаазаар авах ялтай хүн амины хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй[53], Австри улсын Эрүүгийн хуулийн 57 дугаар параграфт бүр насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй[54] байхаар заажээ.

Түүнчлэн, цаазаар авах болон бүх насаар нь хорих ялтай хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх, зарим оронд прокурор шийдвэрлэх талаар заасан орнууд /Азербайджан, Армен, Гүрж, ОХУ, Казакстан, Кыргыкстан, Латви, Монгол, Молдов, Узбекстан, Хятад/ байна. Тухайлбал, Латви улсын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "...энэ зүйлийн 1.5-д заасан цаазаар авах, бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн бол хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино."[55] гэж заасан манай улсын эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ойролцоо юм.

Мөн Гүрж улсын Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн дэх хэсэгт хугацаагүй хорих ял шийтгэхээр заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.Хэрэв хөөн хэрэлцэх хугацааг шүүх хэрэглэхгүй гэж үзвэл хугаагүй хори ялыг хугацаатай хорих ялаар солино гэж заасан байна[56].

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар цаазааар авах болон бүх насаар нь хорих ялтай гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг Бүх Хятадын Ерөнхий Прокуорор шийдвэрлэдэг.[57]

6.Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолоох журам. Эрүүгийн эрх зүйд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг онолын хүрээнд төдийгүй хууль тогтоомжийг хүрээнд тодорхойлдог. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам гэдэг ойлголтонд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх, хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, үргэлжлүүлэн тоолох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах зэрэг ойлголтууд хамаарах бөгөөд улс орнууд тэдгээрийг өөр өөрийн гэсэн онцлогтойгоор эрүүгийн хууль тогтоомждоо хуульчилсан байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ямар хугацааны дотор /эхлэх, дуусах/ тоолох онцлог. Австри, Болгар, Герман, Латви, Дани, Норвег, Испани Польш Турк, Швед, Швейцари, Эстони зэрэг улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эрүүгийн журмаар мөрдөн шалгах өдөр хүртэл, Голланд улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэний дараа маргааш өдрөөс эрүүгийн журмаар мөрдөн шалгах өдөр хүртэл тоолдог бол Тайландын Вант улсад хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хэргийг /хэрэгтнийг/ шүүхэд шилжүүлэх хүртэл, Японд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс прокурор хэргийг яллах хүртэл, Кыргызстан, Турк, Литва улсад гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шүүхийн шийтгэх тогтоол гаргах хүртэл тоолдог онцлогтой.

Харин ОХУ болон ТТУХН-ийн гишүүн зарим орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт этгээдэд ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл тоолно. Ийм зохицуулалт ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байдаг нь манай улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зогсох, сэргээн тоолох, тасрах, шинээр тоолох онцлог. Болгар Улсын Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "...эрх бүхий байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгах зорилгоор тодорхой ажиллагаа явуулсанаар, Швейцари улсын Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 2 дах хэсэг, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар параграф, Турк улсын Эрүүгийн хуулийн 104 дүгээр

[53] www.http://law.e-gov.go.jp/htmldata-S23/S23HO131.html
[54] Уголовный кодекс Австрии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 108
[55] Уголовный кодекс Республики Латвии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 19
[56] Уголовный кодекс Грузии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 134
[57] Уголовный кодекс КНР. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 53

зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоологдож эхэлсэн хэргийн хөөн хэлэлцэх сэжигтэн, яллагдагчийг мөрдөн шалгах зорилгоор процессын ямар нэг ажиллагаа /хуулийн байгууллагаас зарлан дуудах хуудас явуулах, баривчлах, түр саатуулах, үзлэг, нэгжлэг хийх, байцаах, эрүүгийн хэрэг үүсгэх г.м/ явуулснаар, Гүрж улсын Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт зааснаар гэмт хfрэг үйлдсэн этгээдийг яллагдагчаар татсанаар, Испани улсын Эрүүгийн хуулийн 132 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэснээр, Голланд улсын Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгаж эхэлсэн тухай эрх бүхий байгууллагаас түүнд мэдэгдсэнээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох ба энэ ажиллагаанууд дуусахад уг хугацааг үргэлжлүүлэн тоолно.

Харин ОХУ /Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/, Казахстан /Эрүүгийн хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг/, Кыргызстан /Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/, БНХАУ /Эрүүгийн хуулийн 88 дугаар зүйл/, Молдов /Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 5 дахь хэсэг/ зэрэг улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлсэнээс хойш гэмт этгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс орговол хөөн хэлэлцэх хугацаа зогсох бөгөөд уг этгээд өөрөө сайн дураар хуулийн байгуулагад хэргээ илчлэн ирэх, эсвэл түүнийг хуулийн байгууллагаас эрэн сурвалжилж баривчлах, саатуулах үеэс уг хугацааг үргэжлүүлэн /сэргээн/ тоолохоор заасан нь манай улсын Эрүүгийн хуулийн зохицуулалттай үндсэндээ ижил байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолохтой холбоотой зохицуулалт гадаадын зарим орнуудын Эрүүгийн хуульд байгааг үндэсний Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгоход анхаарах нь зүйтэй гэж судаалчийн хувьд үзэж байна.

Зарим орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, сэргээн тоолоход гэмт этгээдийн эхний болон дараагийн үйлдсэн гэмт хэргийн ангилал, төрөл, ялын хэмжээ ач холбогдол үзүүлдгийг судалгаа харууллаа.

Украйн, Латви, Литва, Эстони, Молдов, Хятад зэрэг орны Эрүүгийн хуульд өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад /тоологдож байхад/ шинээр гэмт хэрэг үйлдвэл сүүлийн үйлдсэн хэргийн ангилал, төрөл, гэм буруугийн хэлбэр, оногдуулах ялын хэмжээ хамаарахгүйгээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах ба сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолох журам үйчилдэг. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлд *"...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор <u>шинээр гэмт хэрэг</u> үйлдвэл өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасарч, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно..."* заасан байдаг.

Харин Кыргыз улсын Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт *"...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор <u>шинээр санаатай гэмт хэрэг</u> үйлдвэл өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасарч, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно...",* Молдов улсын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор *<u>хоёр жил хүртэл хугацаагаар хорих оногдуулахаар заасан гэмт хэрэг</u>* шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх тухай тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн хэрэг үйлдсэн өдрөөс шинээр тоолох заалт байгаа нь манай өмнөх эрүүгийн хууль буюу 1986 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зохицуулалттай ижил байна.

Мөн Армен улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт *"...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор <u>хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг</u> шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх тухай тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг шинээр гэмт хэрэг үйлдсэн өдрөөс сэргээн тоолно..." гэж з*аасан нь хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолоход сүүлийн үйлдсэн хэргийн ангилал, ялын төрөл нөлөөлж байгаагийн жишээ мөн.

Үүний эсрэг гэмээр зохицуулалт Казакстан улсын Эрүүгийн хуулийн 69 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт бий. Уг хэсэгт *"Хэрэв <u>урьд нь хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн</u> этгээд хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор дахин шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн үйлдсэн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шинээр тоолно. Харин бусад гэмт хэрэг үйлдсэний дараа дахин шинээр гэмт хэрэг үйлдвэл хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрахгүй, хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа*

зэрэгцэн тоологдоно." гэж заасан нь тус улсын хууль тогтоогч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолоход эхний үйлдсэн гэмт хэргийн ангилалыг харгалзсаныг гэрчилж байна.

Зарим орнуудын /ОХУ, Азербайджан, Гүрж, Туркменистан/ хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа шинээр гэмт хэрэгт үйлдэхэд тасрах, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолох ойлголт байдаггүй, харин эхний гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зэрэгцэн тус тусдаа тоологдох журам үйлчилнэ. Тухайлбал, Азербайджан Улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт *"Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор гэмт хэрэг шинээр үйлдвэл хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тус тусдаа зэрэгцэн тоологдоно*."[58] гэж заажээ.

Дүгнэлт

1.Судалж буй асуудал болох гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гадаадын улс орнууд өөрийн эрх зүйн уламжлал, эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн түвшин, эрх зүйн бүлийн болон өөрийн орны онцлог зэргийг харгалзан харилцан адилгүйгээр үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо хуульчилсан байна.

2.Гадаадын орнуудын эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн хүрээнд судалж, авч үзэж буй судлагдахууны талаарх орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний хөгжил, эрх зүйн зохицуулалт, олон улсын жишиг, чиг хандлагыг тодорхойлвол, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэргийн ангиллаар бус гэмт хэргийн төрөл, гэм буруугийн хэлбэр, оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ зэргийг харгалзан илүү олон төрөлтэйгээр, түүний доод, дээд хэмжээг харьцангуй доошлуулах замаар, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг гэмт хэрэгтэнд илүү энэрэнгүй байдлаар ялгамжтайгаар хуульчлах чиг хандлага ажиглагдаж байна.

3.Гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан эрх зүйн зохицуулалт, олон улсын жишиг, чиг хандлагыг тодорхойлж судлахгүйгээр үндэсний эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох боломжгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд тусгах, санаа авахуйц, цаашдын судалгаанд анхаарахуйц онолын үзэл баримтлал, шинэлэг санаа, шийдэл цөөнгүй байгааг анхаарах хэрэгтэй.

[58] Уголовный кодекс Республики Азербайджан. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 92

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН МӨРДӨН БАЙЦААЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ, АГУУЛГА, МӨН ЧАНАР

Н.Манлайбаатар
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Эрүүгийн процессын эрх зүйн мөрдөн байцаалтыг харьцуулан судлах шаардлагыг үндэслэн, онолын үндэслэл, эх сурвалжийг эрэлхийллээ. Мөрдөн байцаалтын агуулгыг органик, функциональ чиг үүргийн төдийгүй, хэлбэр, баталгаа, үзэл баримтлал, хэм хэмжээ, философийн утгаар нь харьцуулах шаардлага байсаар байна.

Түлхүүр үг. Мөрдөн байцаалт, харьцуулсан судлал, эрх зүйн бүл, үзэл баримтлал, мөрдөн байцаалтын ажиллагаанд холбогдох түүх.

Мөрдөн байцаалтыг харьцуулан судлах нь түүний хэлбэрийг төдийгүй агуулга, үзэл баримтлал, учир холбогдлыг нээн илрүүлэхэд тустай учир бид юуны өмнө мөрдөн байцаалт чухам түүхэн, эрх зүйн, улс төр, эдийн засаг, шашны гээд олон утгаар тайлбарлаж болох ойлголт гэдгийг энэ дэд хэсэгт судлах юм. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалтын ажиллагааг эрх зүйн харьцуулсан судлал талаас нь төдийгүй, мэдлэгийн бусад тогтолцоонд хэрхэн бүрэлдсэн болохыг бид харьцуулах шаардлагатайг илтгэж байна.

Нэгэнт мөрдөн байцаалт нь хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд хамаарч буйн хувьд “харьцуулсан эрх зүй”-н агуулгаар өргөтгөн авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, харьцуулсан эрх зүйн философид эрх зүй гэдэг энэ ойлголт /эрүүгийн процессын үе шатууд/ нь хэрхэн олон янз байдалтай байгааг танин мэдэх, улмаар эрх зүйг илүү бодитойгоор харахад дэм болох юм[59] гэж үзсэн нь үндэслэлтэй. Мөрдөн байцаалт нь урлаг гэж эхэн үедээ хөгжиж байсан нь криминалистикийн мэдлэгийн тогтолцоотой уялдах ойлголт, мөн цэвэр эрх зүйн харилцаа байгаагүй болохыг илэрхийлдэг. Хэрэг маргааныг шалгаж тогтоох гэдэг нь нэг талаас шашин, бөөгийн, эзэн хааны, түшмэдийн эсхүл тэнгэрийн онцгой зөнтэй хүний үйл байсан нь эргэлзээгүй.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь гадаад улс орнуудын эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээнд тусгалаа олсон зохицуулалт бөгөөд эрх зүйн тогтолцооны хувьд ялгаатай байдлаас хамааран зорилт нь харилцан адилгүй байна. Юуны өмнө мөрдөн байцаалт шударга байх явдлыг хангах үүднээс манай улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ЭХХШ тухай хуулийн үзэл баримтлал тэр дундаа мөрдөн байцаалтыг хэрхэн томьёолж байсан, хөгжлийн зүй тогтол, онолын үндэсийг авч үзье.

Шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх нь нийтийн хүсэл зориг хэдий боловч олон зуун жилийн турш түүний мөн чанарыг таних эрэл хайгуул үргэлжилсээр байна. Эрх зүйн хөгжлийн явцад XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед “хэдийгээр шүүх шуларга байж болох ч түүнээс өмнөх шатанд гэмт хэргийг шалгаж, мөрдөн нотлох ажиллагаа нь нэг талыг барихгүй, эрүүдэн шүүлт тулгахгүй, зохиомол хилс хэрэг бүрдүүлж, нотлох баримтыг хуурмаглахгүй байх баталгаа, түүний шударга байдлыг хэрхэн хангах вэ?” гэсэн асуудал тулгамдсан[60] нь шударгаар шүүлгэх эрхийн

---

[59] Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. (Эрх зүйн голлох бүлүүд) Уб., 2005 он. 9 дэх тал.

[60] Г.Эрдэнэбат нар. Эрх зүйн шинэчлэл: Зарим асуудал. Бодлогын судалгааны эмхэтгэл. Уб., 2020 он. 9 дэх тал.

шаардлагын үүднээс “Due process[61]” үүссэн байна. Үүний эх үндэс нь Магна хартын 39 дүгээр зүйлд заасан “Шүүхийн шийдвэр эсхүл газрын хуульд зааснаас бусад тохиолдолд ямар ч чөлөөт иргэнийг баривчлах, хорих, эрх болон эзэмшлийг нь хязгаарлах эсхүл бусад аргаар түүний эрх зүйн байдлыг дордуулах, хөөхгүй ба түүний эсрэг хүч хэрэглүүлж болохгүй[62]” гэсэн заалтаас эхээ авсан “common law” систем мөн. Уг системд XVIII зуунд томоох реформ хийгдсэн нь “гэм бурууг өөрөөр нь хүлээлгэх, айлгаж сүрдүүлэх, тамлан зовоож авсан баримт нь нотлох баримт гэж үзэх маш эргэлзээтэй байдлыг үүсгэх бөгөөд түүнд ямар ч итгэл үнэмшил өгөх ёсгүй[63]” гэж үзсэн нь мөрдөн байцаалтын ажиллагааны төдийгүй /АНУ-ын Үндсэн хуульд/ Үндсэн хуулийн эрх зүйн хөгжилд хүний эрхийн томоохон өөрчлөлтийн үзэл баримлалыг шингээх үндэс болжээ.

Өөрөөр хэлбэл, ардчилсан улс орнуудын Үндсэн хуульд “хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх, түүний шийдвэрт давж заалдах гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шүүхээс гэм буруутайд тооцох хүртэл гэм буруугүйд тооцогдох...” зэрэг эрхийг эдлэж байгаа нь хэрэг маргааныг эрүүдэх, тамлах, айлгах зэргээр хууль зүйн бус хэлбэртэй ажиллагаагаар тогтоож байсныг халах үндсэн эх сурвалж болсон байна.

Үүний эсрэг нь “civil law” тогтолцоо гэдгийг бид өмнөх бүлэгт тодорхой авч үзсэн. Эрх зүйн шинэтгэл нь эрүүгийн процессын тэр дундаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын тогтолцоог эргэж харахад хүргэсэн билээ.

Дээрх нөхцөл байдлаас улбаалж бид эрх зүйн бүлийн, институтийн, хэм хэмжээний, зүйл заалтын хүрээнд харьцуулалт хийх, тэдгээрийн онцлог мөн чанар, хууль зүйн рецепци зэргийг авч үздэг бүхэл бүтэн харьцуулсан эрх зүйн мэдлэгийн тогтолцоог бүтээсэн нь эрүүгийн процессын мөрдөн байцаалтанд буюу институтийн хэмжээнд авч үзэх шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Мөрдөн байцаалт явуулах эрх зүйн үндэс нь эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол билээ. Үүний өмнө хэрэг бүртгэлтийн ажиллагаа хэрхэн дуусах, түүний үр дүнгийн талаарх зарим асуудлыг авч үзье. Хэрэг бүртгэлт дуусах үндсэн хоёр хэлбэртэй. Үүнд: а/ хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, б/ эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах гэсэн хэлбэрүүдийг ЭХХШ тухайн хуульд хуульчилсан.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах ажиллагаа нь чухам мөрдөн байцаалтын ажиллагаа /зарим судлаач бүтээлдээ үе шат гэсэн нь бий/ явагдах эрх зүйн үндсэн болсон яллагдагчаар татах санал, яллагдагчаар татах тогтоол ямар үе шат, шалгууртай хийгддэг талаарх хууль зүйн хэлбэрийг тодотгоё.

1. Хэрэг бүртгэлтийн явцад ЭХХШ тухай хуулийн 1.5 дугаар зүйлд заасан тохиолдолд үүсгээгүй[64], тухайн хүн, хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон, яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой бол мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлэх[65] бөгөөд прокурор дараах шийдвэрийн аль нэгийн гаргана.
2. Шийдвэр нь:
   а/ нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг буцаах;
   б/ эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэх;
   в/ хэрэг бүртгэлтийн хэргийг хаах зэрэг шийдвэрүүдийн аль нэгийг гаргана.

---

[61] Г.Эрдэнэбат нар. Дурдсан бүтээл. Мөн тэнд. Хуульд заасан журмаар ажиллагаа явуулаагүй, процессын явцад оролцогчдын эрхийг зөрчсөн бол тухайн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим юм.

[62] Магна Харт. Орчуулсан П.Амаржаргал. Хоёр дахь хэвлэл. Уб., 2016 он. 28 дахь тал.

[63] Welsh S. White, James j. Tomkovicz. Criminal procedure: Constitutional constraints on investigation and proof. /Cases and materials series/. USA, New York., 1990. p447.

[64] Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй. (Альбом-схем). Уб., 2018 он. 6 дахь тал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдлууд.

[65] Б.Бат-Эрдэнэ. Дурдсан бүтээл. 155 дахь тал.

3. Хэрэв прокурор ЭХХШ тухай хуулийн 30.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэж, прокурорын нэгдсэн бүртгэлт бүртгүүлэх бөгөөд мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулах[66] бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа нь тухайн эрүүгийн хэрэгт нотолбол зохих байдлыг тогтоох үндсэн зорилтыг хэрэгжүүлэхээр явагдана.

Дээрх зохицуулалт нь мөрдөн байцаалт хэрхэн эхлэх, улмаар мөрдөн байцаалт явуулах эрх зүйн үндэсийг тодорхойлон тогтоосон хэм хэмжээ мөн. Бид эрх зүйн зохицуулалтын бүхий л зохицуулалт бус харин мөрдөн байцаалтын ажиллагаа хэрхэн эхлэж байгаа тухай авч үзлээ.

Мөрдөн байцаалтыг хэрхэн явуулах, түүний агуулга мөн чанарыг нээн илрүүлэхийн тулд гадаад улс орнуудын хийгээд, зарим бүтээлд буй онцлог нөхцөл байдал байгаа нь илэрхий. Тухайлбал; Ромын эрх зүйн /МЭӨ 753-МЭ476/ эх сурвалжаас авч үзвэл шүүхийн өмнөх болон шүүхийн шатны тогтолцоо бүрдсэн байсныг судлаачдын бүтээлээс[67] бид судалсан билээ.

Аливаа хэрэг маргаан, эрх зүйн зөрчил, гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл тодорхой үе шат дамжсан, тэрхүү үе шатууд нь улс орнуудын соёл иргэншлийн харилцан адилгүй улс төр, нийгэм эдийн засаг, түүх уламжлалын тогтолцооноос үүдэн хэлбэрийн хийгээд агуулга, үзэл санаа, онол, арга зүйн онтологийн ялгаатай системийг бүтээжээ.

Хүн төрөлхтний түүхийн эхэн үед хамаарах Ромын эрүүгийн процессын эрх зүйн хөгжил нь:

1. Төр, шүүхийн маш хязгаарлагдмал нөхцөлд буюу нэхэмжлэгчийн санаачлагыг гол үндэслэл болгон, хариуцагч талтай мэтгэлцэх ажиллагааг баталгаажуулах замаар явуулж байсан процесс,

2. Хэрэг маргааныг шийдвэрлэхэд төр, шүүхийн албан тушаалтнууд шууд болон шууд бус оролцох болсон буюу ажиглагч, баталгаажуулагч оролцогчоос санаачлагч, шийдвэрлэгч оролцогч болсон процесс,

3. Төр, шүүгчийн оролцоо өндөр, эрүүгийн процессын үе шатгүй буюу хэрэг маргааныг шүүгч шалгахаас эхлээд шийдвэрлэх хүртэл эрхлэн явуулдаг байсан процесс,

4. Төр, шүүгчийн оролцоонд тулгуурласан, шүүхийн санаачлагатайгаар тусгайлан томилогдсон эрх бүхий түшмэл /квестр/ мөрдөн байцаалтыг эрхлэн явуулж, улмаар шүүх хэрэг маргааныг шийддэг байсан процессын үе шатыг[68] дурьдаж болохоор байна.

Дэлхий дахинд соёл иргэншил харилцан адилгүй үүсч, хөгжлийн чиг баримжаа, үзэл баримтлалаараа адилгүй систем бүрэлдэж эхэлсэн МЭӨ 3000 жилийн тэртээгээс эх авсан соёлууд тухайн оршин буй тогтолцоогоо улам боловсронгуй болгоход чиглэж, Ромын эрүүгийн процессын эрх зүйн түүхэн эх сурвалжийг бүтээжээ. Энэ үйл явц улам бүр тэлсээр бусад соёлуудад хэрхэн нөлөөлж, дэлхий дахинаар ижилсэх, эсхүл хослосон тогтолцоог бүтээж буйг бид өнөөдрийн эрх зүйн рецепцийн үзэгдлээс ажиглаж болохуйц болжээ. Ромын эрх зүй дэх эрүүгийн процессын эрх зүйн хөгжлийн үе шатыг дорно дахинд ч давсан нь нийгмийн хөгжлийн зүй тогтол гэж үзэх үндэслэлтэй.

Монголчууд бид анх төр улсаа байгуулсан цагаас аливаа нийгэмд харш хэрэг маргааныг шийдвэрлэх тодорхой арга зүйг хэрэглэж ирсэн бөгөөд эзэн хаан хийгээд түүний тусгайлан томилсон хүн шүүгчийн үүргийг гүйцэтгэж байсан нь дээр дурьдсан

---

[66] Б.Бат-Эрдэнэ. Дурдсан бүтээл. 157 дахь тал.

[67] Д.Баярсайхан. Ромын эрх зүй. Уб., 2000 он. 146-152 дугаар тал, Петер Штайн. Европын түүхэн дэх Ромын эрх зүй. Орчуулсан Р.Янжмаа. Уб., 2016 он. 10-11 дүгээр тал.

[68] Д.Баярсайхан. Дурдсан бүтээл. 150-152 дугаар тал.

үе шатыг дамнасан байх үндэслэлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, иргэд эсхүл тухайн нутаг дэвсгэрт орших хэн боловч өөр хоорондоо үүссэн хэрэг маргааны талаар хаан эзэнд заавал айлтгахгүйгээр тохирох, өс тайлах /амийг амиар, ясыг ясаар/, хариу авах зэргээр шийдэж байсан нь гэж үзвэл төр, шүүхийн хувьд ажиглагчийн статустай оролцож байжээ гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна.

Харин хүмүүс нийтээр амьдрах, нэгдэн нягтрах тусам хоорондын зөрчил ихсэхэд төр шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж хэрэг маргааныг шийдвэрлэхэд оролцох шаардлага үүсдэг зүй тогтолтой гэж болохоор байна. Үүнийг бататгаж, Хүннү болон Хан улстай байгуулсан Энх ургийн гэрээ нь худалдаа хийх, дайн самууныг зогсоох, татвар өргөл барих зэрэг олон асуудлыг тохирч байсан[69] нь улс гүрний дунд үүссэн асуудлыг зохицуулах, улмаар гэрээг зөрсөн бол цаазлан хороохоор тохирсон явдал нь хаадын дунд байгуулсан гэрээний хувьд хэн нэгэнд эрх өгөх утга агуулаагүй нь тодорхой.

Хэдийгээр хүннүгээс хойш олон зуун жилийн турш дурьдсан хэлбэртэй эрүүгийн процесс явагдаж байсан ч шүүх, шүүгчийн тогтолцоо бүрэлдэх зүй тогтолын дагуу Монголын түүхийн дараа дараагийн хөгжлийн үе шатанд шүүх тогтолцоо бүрэлдэж, улмаар тодорхой хэргийг шийдвэрлэхийн тулд тусгайлан томилсон түшмэд мөрдөн шалгах, хааны алба хийгээд томоохон жанждын хэрэгт анхаарал хандуулж улмаар эрүүдэх, тамлах зэргээр хэрэг хүлээлгэдэг байсан тухай бид авч үзсэн билээ.

Монголчууд төрт улсаа байгуулсан цагаас хойш хууль цаазын томоохон сан хөмрөг үүсгэсэнтэй зэрэгцэн дэлхий дахинд хууль тогтоомж, эрүүгийн процессын тэр дундаа мөрдөн байцаалтын хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж, үзэл санаа, номлол улам бүр баяжиж байсан ажээ. Тухайлбал, Англид Магна Харт “Due process of law” /зүй зохистой эрх зүйн хэм хэмжээ/ бүтээж байсан бол, Шихихутуг мэдүүлэг авахад бусдад “айж эмээхгүй үнэнийг өч” гэж өнөөгийн эрүүгийн процессын болон криминалитстикийн тактикийн хувьд анхаарч авч үзэх түүхэн судлагдахуун, эх сурвалж болохыг илтгэнэ.

Дурьдан буй үеийн тухайд монголчууд дэлхийн эрх зүйн тогтолцоонд Их засаг хуулийг Ил хаант улсын шариатын хуультай эрлийзжүүлэх алхам хийсэн. Энэ ч утгаараа монголчуудын дэлхийн эрх зүйн тогтолцоонд оруулсан хувь нэмэр нь Магна хартаас дутахгүй нөлөөтэй.

Мэтгэлцүүлэн шүүх тогтолцоо Англи улсад дараах гурван үе шаттай хөгжсөн. Үүнд: 400-1300 он, 1300-1700 он, 1700 оноос хойш гэж үзсэн[70] байна.

Дундад зууны түүхэнд дэлхийн ихэнхи улсад хэмжээгүй эрхт хаант төрийн тогтолцоо[71] оршин байсан учир, түүний оршихуйг бурханчлан үзэх хандлага тухайн улс бүрт байжээ. Энэ нь хаант засгийн эсрэг, бурханы номын эсрэг агуулгатай хэрэг маргааныг шуурай шийдэх зорилгоор хэрэгтнийг буг чөтгөр, албинд хорлогдсон мэтээр ард түмнийг мунхруулах, шулам, чөтгөр гэж эрүүдэх, тамлах, гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектийг хүссэнээрээ тодорхойлж, мөрдөх, шийтгэх явдал[72] газар авсан байжээ.

Арванесдүгээр зуунаас Европын олон орнуудад хүний жам ёсны эрхийг жинхэнэ утгаар нь хүлээн зөвшөөрч, улс төрийн ардчилсан тогтолцоог бий болгохыг зорьж эхэлсэн нь нийтийн эрх зүйг өмнөхөөс ялгаатай байдлаар харах түүнд

---

[69] Сыма Чянь. Түүхийн тэмдэглэл. /Хүннүгийн түүх, цадиг/. Хятад хэлнээс орчуулсан Г.Элдэв-Очир. Уб., 2017 он.

[70] Д.Зүмбэрэллхам. Шүүхийн мэтгэлцээн. Уб., 2002 он. 10-11 дүгээр тал. Энэ үе шатуудыг Америкийн Нэгдсэн Улсын хуульч Херберт Д.Боумэн авч үзсэн тухай үзнэ үү.

[71] Х.Баярмаа. Шинэ үеийн дэлхийн түүх. I дэвтэр. (Өрнө дахин) Уб., 2019 он. 30-44 дэх тал. XV-XVI дугаар зууны зааг үеэс Европт хэмжээгүй эрхт хаант төр үүсжээ.

[72] Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Уб., 2011 он. 129 дүгээр тал. Эр тахиа өндөглөсөн тул гал дээр шарж цаазалсан түүх 1414 онд Германд болсон, Дошгин Иван хааны дүү Дмитрий 1593 онд нас барахад хонх дуугарч, Дмитрийг алсан хүнийг шийтгэж байхад дуугарсан хонхны улмаар иргэд цуглаж хөл үймээн болсон тул хонхыг ташуурдах болон цөлөх ял шийтгэсэн байна.

анхаарлаа хадуулах үндсийг бий болгосон юм. Ингэснээр өмнө нь бурханаас олгогдсон эрхтэй байсан хаан буюу төр нь хүний жам ёсны эрхийг хангахад саад тотгор болж байгаа хүчин зүйл гэдгийг аажмаар хүлээн зөвшөөрч, засаглалын эрх нь уам ёсны эрхийг зөрчихгүй байх бодит байдлыг хайхад хүргэсэн[73] гэсэн нь бидний үзэж байгааг бататгаж улмаар гэмт хэргийг шалгах, тогтоох томоохон сэтгэлгээний эрин үе эхэлсэн байна.

Түүнчлэн 1800 оны дунд үед "Францад Наполеоныг хүртэлх цагдаагийн албад эрүүгийн хэргийг илрүүлэхээсээ илүүтэй Францын хаадын улс төрд хүчин зүтгэж ирсэн"[74], мөн "хөрөнгө /капитал/ эзэмшигчид ажиллах хүчний хөдөлмөрийг сорон мөлжиж боолчох зэргээр ажиллуулж, тэдний эрх ашгийг хамгаалахгүйгээр үл барам, улс төрд нөлөөлж, өөрсдийн гэм үйлдлээ хаацайлах, хүүхэд эмэгтэйчүүдийг хууль бусаар хөдөлмөрлүүлж, Английн доод танхимаас хууль бус шийдвэр гаргуулахад нөлөөлж, гэрчийг дахин байцаах гэсэн үгээр аргацааж байна[75]" гэсэн нь бидний үзэж байгааг аль ч үед байсныг бататгаж байна.

Ийнхүү хууль бус мөрдөн шалгах ажиллагаа, эрүүдэн шүүх явдал гарч байсан[76] нь шинжлэх ухааны хөгжлийн түвшинг илтгэхийн зэрэгцээ хууль тогтоох эрхийг гагцхүү хаан мэдэж байсан монист үзэл санаатай хамаатай гэж үзэж болно. Гэтэл хааны оюун санааны үндэс нь шашин, лам, хуварга, шашны ном, номлол байсан нь үзэл санааг мунхруулах эсхүл энэрэнгүйн ёсонд нийцүүлэх, зарим тохиолдолд аль ч учраа олохгүй байх нөхцөл байдлыг үүсгэж байсан нь илэрхий.

Шашны эсхүл хааны нөлөөг хамгаалах гэсэн үзэл номлолын эсрэг олон бүтээл хэвлэгдсэнээс Чезаре Беккариагийн "Гэмт хэрэг ба ялын тухай" бүтээл нь гэмт хэргийг танихуйн шинжлэх ухааны үндэс болсон бөгөөд өнөөдөр ч үнэ цэнэтэй зарчим томьёолсон гэж үзсээр байна. Гэвч уг бүтээл нь зөвхөн материаллаг эрх зүйн онолын эх сурвалж төдийгүй, эрүүгийн процессын эрх зүйн институтыг ч авч үзсэн байна. Тухайлбал, гэрчийн тухай[77], нотлох баримт хийгээд нотолгооны журам[78], эрүүдэн шүүх тухайд[79], тангараг өргүүлдэг талаар[80], нотлоход төвөгтэй гэмт хэрэг[81], мэдүүлэг, хөтөлж байцаах[82] зэрэг мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааг хууль зөрчиж явуулахыг зөвтгөж болохгүй тухай тэмдэглэсэн нь XVIII зууны Европын хууль тогтоомжид тусгалаа олж, улмаар өнөөдрийн эрүүгийн эрх зүй - хүн төрөлхтний үнэт зүйлд тооцогдохын үндэс[83] гэж үзэж байгаатай бид санал нэг байна.

Эрүүгийн процессын эрх зүйн үнэт зүйлсийг Ч.Беккариа томьёолсон нь өнөөдөр ч мөн үнэ цэнэтэй гэж үзэх үндэслэлийг бид орхигдуулж болохгүй. Тухайлбал, Аристотелийн "гэрч"-ийг тодорхойлж байсан шиг тэрээр гэрчийн мэдүүлгийн процессын шийдвэр гаргах баримт болгоход найдвартай байдал чухал гэж бичсэн байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үгээр үйлдэгдсэн бол гэрчийн мэдүүлэгт итгэхгүй байхыг зөвлөөд, хүч хэрэглэсэн, гэмтэл үлдээсэн үйлдэл нь тухайн гэмт хэргээ ямар байсныг илэрхийлэх ул мөр үлдээдэг гэжээ. Үг бол зөвхөн сонсогчийн ой ухаанд үлдэж, тэгээд ихэнхи хэсэг нь төөрөгдөл, хуурмаглалд хучигдсан байдаг[84] гэж

---

[73] Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. (Эрх зүйн голлох бүлүүд) Уб., 2005 он. 71-72 дугаар тал.
[74] Юрген Торвалд. Криминалистикийн зуун. Орчуулсан Б.Жаргалсайхан. Уб., 2019 он. 17 дахь тал.
[75] Карл Маркс. Капитал. I боть. Уб., 1999 он. Орчуулсан Б.Бирваа. 560-561 дэх тал.
[76] Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орчуулсан Г.Эрдэнэбат. Уб., 2021 он. 109 дэх тал. Тэрээр "Бүхэл Европыг цусанд үйж байсан нэгэн төрлийн гэмт хэргийн тухай огт хөндөлгүй байсаар ирлээ. Тэр үед амьд хүнээр гол ороож байгаад зул өргөж байв. Хөөрхий түүний амь тавин бархирах нь, арьс, яс шуугин шатах нь, эрдэнэт хүмүүний бие утаа болон замхрах нь ердөө л бусдыгаа дагах нэрийн дор бултаар ухаан сэхээгээ гээж үймсэн олныг зугаацуулах үзмэр төдий зүйл болгоод өнгөрдөг байв." гэсэн нь үүний баталгаа болно.
[77] Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орчуулсан Г.Эрдэнэбат. Уб., 2021 он. 48-49 дүгээр тал.
[78] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 50-52 дугаар тал.
[79] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 55-61 дүгээр тал.
[80] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 63-64 дүгээр тал.
[81] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 93-95 дугаар тал.
[82] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 108 дахь тал.
[83] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 8-9 дүгээр тал.
[84] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 48-49 дүгээр тал.

өөрийн санаагаа бататгасан нь мөрдөн байцаалт, криминалистикийн тактик зүйн хувьд сонирхолтой судлагдахуун, эх сурвалж болохыг илэрхийлж байна.

Мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулаагүй бол үндэслэлтэй, зөв шийдвэр гарахгүй гэж үзэж байсан нь түүний эрүүгийн процесст оруулсан том хувь нэмэр гэж үзэхээс өөр аргагүй билээ. Нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийн нотлох баримт нь бүхэлдээ гэмт үйлдлийг нотлож байгаа эсэх, эсхүл гэмт үйлдлийг нотлож байгаа нотлох баримтыг нотлож байна уу гэсэн рациональ фиолософи нь Ч.Беккариагийн мөрдөн байцаалтыг няцаах, няцаагдахгүй байхын үндэс болсон, орчин үед ч хөндөж байх асуудал болохыг илэрхийлж байна. Түүний "нотлох баримт хийгээд нотолгооны журам[85]" хэсэгт орчин цагийн гэмт хэргийн нотолгооны онолын үндэс тавигдсан нь илэрхий байгааг бид цаашид дагнан судлаж, мөрдөн байцаалт ба нотолгоо чиглэлийн асуудлыг хууль зүйн техникийн хийгээд мэдлэгийн тогтолцооных нь хувьд цэгцлэх шаардлагатайг илтгэж байна.

Мөрдөн байцаалт яагаад чухал болохыг хөндөж байгаа хамгийн гол аргумент нь "Хэрэг шийдэхийн тулд яллагдагчийг эрүүдэх нь уламжлалаар зөвтгөсөн харгислал. ...Бүр байчихаад үйлдчихсэн атлаа хэлээгүй байж магадгүй хэргээ хүлээ гэж эрүүдэж байна[86]" гэсэн нь орчин үеийн мөрдөн байцаалтад ч илэрдэг үзэгдэл болохыг Хүний Эрхийн Үндэсний комиссын тайлан илтгэлүүдэд дурьдагджээ. Мөн тэрээр "Хэн ч шүүхээр нотлогдоогүй байхдаа гэмт хэрэгтэнд тооцогдох ёсгүй. Тэгээд ч хамгаална гэж баталгаа өгчихөөд тийнхүү хамгаалуулах гэрээгээ зөрчсөн эсэх нь тогтоогдоогүй байхад нийгэм хүнээ өөрийн хамгаалалтгаас гаргах ёсгүй. Тэгэхлээр гэм буруутай, буруугүй нь тогтоогдоогүй байхад хүчирхийллээс өөр юу шүүхэд хүнийг шийтгэх, хүч хэрэглэх эрх олгох билээ? Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон нотлогдоогүй гэсэн хоёрхон гаргалгаатай[87]" гэж эрүүгийн процессын эрх зүйн үндсэн зарчмыг тунхаглаж өгсөн нь түүний бүтээлийн амин сүнс ажээ.

Мөн тэрээр тангарагт итгэх талаар тэмдэглэсэн нь бий. Өөрөөр хэлбэл, "Хүнд худал хэлэх нь хамгийн ашигтай байгаа яг тэр агшинд үнэн зөв мэдүүлэг өгөхийг шаардаж байгаа нь хууль хийгээд хүний язгуур ашиг сонирхолын хооронд зөрчилдөөн үүсгэж байгаа юм. Хүн өөрийнх нь ашиг сонирхолын тухай асуудал яригдаж байхад хүсэл сэтгэл, хэрэгцээ сонирхол нь огт хамаагүй болж өөрийгөө баллахын тулд бурхандаа тангараг өргөр ёстой юм гэнэ. Хүн төрөлхтөн хөгжлийг бүх үеийнхээ турш шашин гэгч тэнгэр бурхны хишгийг бусад бүх юмнаас илүүтэй хортойгоор ашигласаар ирсэн[88]" гэсэн нь тангарагын учир холбогдолд задлан шинжилгээ хийсэн тохиолдол гэлтэй. Бид энэ тухай нарийвчлан авч үзэх шаардлагагүй. Уг асуудлаар Аристотель ч тодорхой байр суурьтай байсан талаар эхний бүлэгт авч үзсэн.

Ч.Беккариагийн үзэж байгаагаар "мэдүүлэг, хөтөлж байцаах" талаар өнөөгийн бидний үздэг нийтлэг утгаар тайлбарлаж байсан байна. Тэрээр "Криминалистуудын үздэгээр асуулт нь фактыг тойрон спираль маягаар дөхөх учиртайгаас бус шууд чиглэсэн байж болохгүй. Энэ дүрэм нь нэг бол яллагдагч дагуулж хариулсаар өөрийгөө яллах, эс бөгөөс ял завшихад хүргэхгүй гэсэн зорилгоос үүдэлтэй[89]" гэжээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь онолын хувьд дэлхийн философийн хийгээд үзэл санааны үндэс болсон улс орнуудад өөр өөрийн төлөөлөгчдөөр нь дамжин үсрэнгүй хөгжсний илэрхийлэл болсон Италийн нэрт философич, криминологич, процессуалист Ч.Беккариагийн онол, арга зүйн томьёоллыг эрүүгийн процесст тэр дундаа шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд оруулсан түүний үнэлж баршгүй хувь нэмэр гэж үзэж болно.

---

[85] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 50-51 дүгээр тал.
[86] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 55 дахь тал.
[87] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. Мөн тэнд.
[88] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 63 дахь тал.
[89] Чезаре Беккариа. Дурдсан бүтээл. 108 дахь тал.

Аж үйлдвэрийн хөгжлийн эрин үетэй зэрэгцэн сонгодог утгаараа хөгжиж эхэлсэн мөрдөн байцаалтын үзэл баримтлал, зарчим, тодорхой ажиллагаа ийнхүү томьёологдож эхэлсэн нь түүхийн сонгодог эх сурвалжуудаас тодорч байна.

Үүний нэгэн баримт бол XIX зууны дунд үе хүртэл "гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн байцаалт"-ыг "урлаг" гэж үзэж байсан[90], түүнчлэн "Монголчуудын гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх урлаг эртнээс улбаатай[91]" гэсэн нь бидний судлан буй сэдвийн агуулга, мөн чанарыг тодорхойлох, нээн илрүүлэхэд учир холбогдолтойн зэрэгцээ өнөөгийн ба хэтийн төлөвийг тодорхойлоход дэм үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, криминалистик хэмээх ухааныг гэмт хэрэг мөрдөхөд хэрэглэхийн чухлыг дэлхий улс орнууд нилээд эртнээс мэдэж байсан боловч уг ухаан өөрөө бүрэлдэн төлөвшөөгүй байсан тэр цаг чухам юуг, хэрхэн ашиглах эвээ олохгүй байсан учраас гэмт хэрэгтэй тэмцэхдээ шинжлэх ухааны мэдлэгийг огт ашиглахгүй, зөвхөн гэрч, хохирогчийн харсан гэх мэдүүлгээр хэргийг шүүж байсан үе түүхэнд тэмдэглэгдсэн[92] болохыг бид авч үзсэн билээ.

Ромын эрх зүйн хөгжлийн эхэн үе шатанд шүүхийн оролцоо багатай хэрэг маргааныг шийдвэрлэж байсан үеэс үндсэндээ 2000 орчим жилийн дараа хүртэл ийнхүү шүүн шийдэж байсан нь мөрдөн байцаалт нь хөгжлийн хувьд ахиц гараагүй шахам байсны гэрч баримт гэж үзэх нөхцөлийг бүрдүүлж байна.

"Гэмт хэрэг илрүүлэх урлаг" гэсэн нэр томьёо нь мөрдөн шалгах ажиллагааг агуулж байгаа бөгөөд улмаар уг ажиллагаа нь шинжлэх ухаанчаар хөгжих зүй тогтол 1884 оноос эхтэй гэсэн нь хүн судлалын хэмжил зүйг Францын цагдаад эхлэн хэрэглэсэн нь шинжлэх ухаанч криминалистик системтэй бүрэлдэх нөхцөл болсон[93] байна гэснээс үзвэл мөрдөн байцаалтын ажиллагаанд шинжлэх ухааны үзэл санаа, тэр дундаа криминалистикийн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо анхлан нэвтэрсэн нь энэ үеэс эхтэй гэж үзэж болохоор байна. Хэдийгээр дорно дахин, ойрхи дорнод, европд аливаа хэргийг нотлоход өөр өөрийн өвөрмөц арга барилаар хор судлах, мөр мөшгөх зэрэг мэдлэг хэрэглэгдэж байсан боловч энэ нь хэлбэржин тогтоогүйгээс мөрдөн байцаалт нь шинжлэх ухаанч биш хэлбэртэй байсан ажээ.

Криминалистикийн мэдлэгийн тогтолцоо нь бие даасан шинжлэх ухаан бөгөөд мөрдөн байцаалтыг түүний философи, хэл, нэр томьёо, үзэл баримтлалтай холбож авч үзэх нь эрүүгийн процессын эрх зүйн хийгээд бидний онол, практикийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал. Мөрдөн байцаалт нь криминалистикийн бүхий л тогтолцоотой харилцан шүтэлцээтэйн зэрэгцээ бид "гэмт хэрэгтэй тэмцэх сургааль нь криминалистик мөн" гэсэн үзэл санааг дэмждэг билээ. Тэгвэл эрүүгийн процесс дахь "мөрдөн байцаалт"-ын шинжлэх ухааны үндэс нь криминалистикийн онол, криминалистикийн техник зүй, криминалистикийн тактик зүй, криминалистикийн арга зүй мөн гэж үзэх нь зүйтэй. Зөвхөн мөрдөн байцаалтын гэсэн нь логикийн алдаатай гэж үзвэл бид мөрдөн байцаалтын хүрээг өргөтгөн харах шаардлагатай. Тухайлбал, мөрдөн байцаалт нь эрүүгийн процессын эрх зүйн зорилтыг хангах үүднээс явагддаг ажиллагаа болохыг анхаарвал түүний үзэл баримтлалд – гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэргийг нотлон мөрдөх, мөрдөн шалгах ердийн болон тусгай ажиллагаа /нууц мөрдөн шалгах ажиллагаа/, мөрдөн мөшгөх, эрэн сурвалжлах, мөр хөөх, нотлох баримт эрэх, хайх, цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх гэзэг шүүхийн өмнөх шатны бүхий л цар хүрээг хамарна. Гэхдээ шүүхийн шатанд нотлох баримтыг шинжлэн судлах, цуглуулах талаар тодорхой ажиллагаа явуулдаг нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад "шүүхийн мөрдөн байцаалт" явуулж буйн илэрхийлэл юм.

Дээрхээс үзвэл мөрдөн байцаалт нь бусад мэдлэгийн тогтолцоотой холбогдох өргөн хүрээтэй ойлголт болохын зэрэгцээ криминалистикийн шинжлэх

---

[90] Юрген Торвалд. Криминалистикийн зуун. Орчуулсан Б.Жаргалсайхан. Уб., 2019 он. 3-4 дүгээр тал.
[91] Б.Бат-Эрдэнэ. Криминалистик. (лекцүүд). Хоёр дахь удаагийн хэвлэл. Уб., 2017 он. 5 дахь тал.
[92] Юрген Торвалд. Дурдсан бүтээл. Мөн тэнд.
[93] Юрген Торвалд. Дурдсан бүтээл. Мөн тэнд.

ухааны мэдлэгийн тогтолцоо, философи, нэр томьёо, онол, номлолд үндэслэсэн бүхэл бүтэн мэдлэгийн бие даасан тогтолцоо болохыг бид үүгээр бататгаж байна.

Ном зүй

- Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. (Эрх зүйн голлох бүлүүд) Уб., 2005 он.
- Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй. (Альбом-схем). Уб., 2018 он.
- Б.Бат-Эрдэнэ. Криминалистик. (лекцүүд). Хоёр дахь удаагийн хэвлэл. Уб., 2017 он.
- Х.Баярмаа. Шинэ үеийн дэлхийн түүх. I дэвтэр. (Өрнө дахин) Уб., 2019 он.
- Д.Баярсайхан. Ромын эрх зүй. Уб., 2000 он.
- Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Уб., 2011 он.
- Д.Зүмбэрэллхам. Шүүхийн мэтгэлцээн. Уб., 2002 он.
- Карл Маркс. Капитал. I боть. Орчуулсан Б.Бирваа. Уб., 1999 он.
- Магна Харт. Орчуулсан П.Амаржаргал. Хоёр дахь хэвлэл. Уб., 2016 он.
- Петер Штайн. Европын түүхэн дэх Ромын эрх зүй. Орчуулсан Р.Янжмаа. Уб., 2016 он.
- Сыма Чянь. Түүхийн тэмдэглэл. /Хүннүгийн түүх, цадиг/. Хятад хэлнээс орчуулсан Г.Элдэв-Очир. Уб., 2017 он.
- Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орчуулсан Г.Эрдэнэбат. Уб., 2021 он.
- Г.Эрдэнэбат нар. Эрх зүйн шинэчлэл: Зарим асуудал. Бодлогын судалгааны эмхэтгэл. Уб., 2020 он.
- Юрген Торвалд. Криминалистикийн зуун. Орчуулсан Б.Жаргалсайхан. Уб., 2019 он.
- Welsh S. White, James j. Tomkovicz. Criminal procedure: Constitutional constraints on investigation and proof. /Cases and materials series/. USA, New York., 1990.

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Т.Болор-Эрдэнэ
ОТИС-ийн ХЗС-ийн дадлагажигч багш

Товч агуулга. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах эрх зүйн зохицуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг боловсронгуй болгох талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Урьдчилсан хэлэлцүүлэг, нотлох баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэргийг прокурорт буцаах.

Удиртгал

Шударга ёсыг тогтоох, хүний эрхийг хамгаалах үзэл хандлагын үүднээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтыг шинээр тодорхойлсон билээ. Хэдийгээр эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлт хэрэгжиж эхлээд 4 жил гаруй болсон хэдий ч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас аль болох зайлсхийх, улмаар хохирогч, яллагдагч, бусад оролцогчийн эрхийг бүрэн хангахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх хандлагатай байна.

Эрүүгийн хэргийн оролцогч талууд болон шүүх энэ ажиллагааны талаар өөр өөр байр суурьтай байгаа нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ач холбогдлыг бууруулж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэх шаардлагатай асуудлыг орхигдуулж байна. Тухайлбал, шүүх өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг хийхдээ шүүхийн өмнөх процесс шударга явагдсан эсэхэд ач холбогдол өгөхөөс илүү хэргийн ачааллаа бууруулахад ашиглаж байгаа бол прокурорын хувьд энэ ажиллагаа нь ажлын ачааллын үндсэн шалтгаан, ажлын үнэлгээг бууруулах хүчин зүйл болдог тул огт хэрэггүй процесс гэж үзэх хандлага давамгайлж, харин өмгөөлөгч өөрийн хүсэлтийг хангах, хэргийн шийдвэрлэлтийг удаашруулах хэрэгсэл болгон ашиглаж байна.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн төслийн анхны буюу 2015 оны үзэл баримтлалд ухралт хийж, 2017 онд батлагдахдаа шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар тусгасан дэвшилтэт шийдлүүд хасагдаж “хавтаст хэрэг дагадаг” уламжлалт тогтолцоо, “бодит үнэнийг тогтоох зарчим” хэвээр үлдсэн. Ингэхдээ яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааны талаарх бүлгийн нэг зүйл хэсэгт багтаан тусгасан байна.[94]

Дээрх ухралтаас үүдэж одоогийн байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн гүйцэтгэх үүрэг сарнин хүний эрхүүдийг зохистойгоор хангах боломж хаагдаж, урьдчилсан хэлэлцүүлгийг буруу жишиг, хандлагаар хэрэглэх суурь тавигдсан гэж үзэж болохоор байна. “Цаашид мэтгэлцэх зарчим руу шилжих, оролцогчдын тэгш боломжийг хангасан шүүхийн урьдчилсан шатны хэлэлцүүлгийн төрлийг нэмэх, зөвшөөрлийн системийг уян хатан болгох чиглэл рүү хөгжих нь зүйтэй ” гэж судлаачид дүгнэжээ.[95]

Иймд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зохих ёсоор явуулж, мөрдөн шалгах ажиллагаа шударга явагдах нөхцлийг бүрдүүлэх, хүний эрхийг үр дүнтэй хангах талаар онолын асуудлыг судалж, Оросын Холбооны Улсын эрүүгийн хэргийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтуудыг харьцуулан судаллаа. ОХУ-ын сайн туршлага бүхий зохицуулалтуудыг илрүүлэх замаар үндэсний эрх зүйн хүрээнд зохицуулагдсан урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах талаар санал, дүгнэлт гаргахыг зорилоо.

---

[94] Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, 2015 он. ХЗЯ

[95] Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх нь, судалгааны тайлан. Эрүүгийн эрх зүйн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ,дэд тайлан. ХЗҮХ. 2017 он

Үндсэн хэсэг

Нэг.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ойлголт, онцлог

Урьдчилсан хэлэлцүүлэг бүхий шүүхийн анхны тогтолцоо Англи Улсад 1200-аад онд бий болохын[96] зэрэгцээ гэмт хэргийг шашин, ёс суртахуун эсвэл тусгайлсан хууль цаазаар тухайн орон нутгийн хашир туршлагатай ахмад настан, хошуу ноёд, түшмэдээр шийдвэрлүүлж байсан ажээ. Шүүхийн тогтолцоо бий болсноос хойш 1700-аад оны үед Европын тэргүүлэх гүрнүүдийн колоничлол, соёлын нөлөөгөөр *trial* буюу шүүх ажиллагаа дэлхий нийтэд түгж, шударга ёсыг тогтоох үзэл санаа хууль дээдлэх зарчимд тулгуурлан хөгжиж ирсэн түүхтэй.

Шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн хөгжлийн явцад XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед "хэдийгээр шүүх шударга байж болох ч түүнээс өмнөх шатанд гэмт хэргийг шалгаж, мөрдөн нотлох ажиллагаа нь нэг талыг барихгүй, эрүүдэн шүүлт тулгахгүй, зохиомол хилс хэрэг бүрдүүлж, нотлох баримтыг хуурмаглахгүй байх баталгаа, түүний шударга байдлыг хэрхэн хангах вэ?" гэсэн асуудал тулгамджээ. Чухамхүү энэ л шалтгаанаар шударгаар шүүлгэх эрхийн шаардлагын үүднээс "*due process*" үүсэн бий болсон байна. "*Due process*" нь хуульд заасан журмаар ажиллагаа явуулаагүй, процессын явцад оролцогчдын эрхийг зөрчсөн бол тухайн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим юм. [97]

"*Due process*"-ийн зөвхөн нэг арга хэрэгсэл бол "шүүхийн өмнөх хэлэлцүүлэг" бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагаа шударга байх явдлыг хангах үүднээс эрүүгийн хэрэг үүсгэх, нотлох баримтыг үнэлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт процессын ажиллагааг алдаагүй явуулах төрөл бүрийн хэлэлцүүлгүүдээс /hearing/ бүрддэг.[98]

Монгол Улсын хувьд дээрх олон улсын чиг хандлагыг харгалзан үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн "...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй...", 13 дахь хэсэгт "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй", Арван есдүгээр зүйлд заасан төрийн "хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй"[99] гэснийг хэрэгжүүлэх зорилгоор 2015, 2017 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан хэрэгжүүлээд 4 жил гаруй болж байна. Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд энэхүү эрүүгийн эрх зүйн шинэчлэл чиглэсэн.[100]

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т заасан "…хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох…" эрхэд нийцүүлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.8 дугаар зүйлд яллагдагч буюу шүүгдэгчийг анхан шатны шүүх хуралдаанд биечлэн оролцуулахаар хуульчилсан бөгөөд яллагдагч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргавал талуудын саналыг харгалзан шүүх шийдвэрлэхээр заажээ.[101]

---

[96] Judges and the law. 2016. The open University. page 11.

[97] Due process, the concept that governments must respect the rule of law

[98] Тухайлбал, World Justice Project байгууллагаас жил бүр "Эрх зүйт èс" (Rule of Law)-ны индексийг боловсруулж, 1.Хязгаарлагдмал засаг төр (Limited Governance), 2.Авлигыг хүлцэн тэвчих байдал (Absence of Corruption), 3.Дэг журам, аюулгүй байдал (Order and Security), 4.Хүний үндсэн эрхийн хэрэгжилт (Fundamental Rights), 5.Нээлттэй засаг (Open Government), 6.Хууль тогтоомжийн хэрэгжилт (Regulatory Enforcement), 7.Иргэний процессын ажиллагаа (Civil Justice), 8.Эрүүгийн процессын ажиллагаа (Criminal Justice), 9.Мэдээлэл хайх, олж авах байдал (Informal Justice) зэрэг 9 хүчин зүйлээр улс орнуудыг хэмждэг. Эдгээр шалгуур хүчин зүйлсийн дийлэнх нь Эрх зүйн зайлшгүй процесс (Due Process of Law)-ын шалгуурыг багтаасан нь санаандгүй хэрэг биш бөгөөд төрөөс хүний эрхэд халдах ажиллагаа стандарттай байх èстойг илтгэнэ.

[99] Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992 он

[100] Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, 2015 он. Хууль зүйн яам

[101] Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хууль бусаар халдсан, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур мөрдөн шалгах ажиллагаа явуулж, оролцогчдын эрхийг зөрчсөн тохиолдолд тухайн асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлүүлэх боломжийг олгожээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой баталгааг хангахын тулд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан хүний эрхийн зөрчил, алдааг олж тогтоох, залруулах, хөндөгдсөн эрхийг сэргээх, хэргийг бүрэн дүүрэн шалгаж шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлжээ.

Хоёр.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцогч талуудын чиг үүрэг, шүүхийн ажиллагааны журам

Шүүх хуралдааны ажиллагаа нь эрүүгийн процессын нийтэд илүү нээлттэй байдаг хэсэг тул түүний шударга үр дүнтэй ажиллагаа нь шүүх эрх мэдлийн шударга ёсны байдалд итгэх олон нийтийн итгэлийг бий болгодог.

Эрх тэгш байх ба шударга шүүхийн зарчмыг хангах үүднээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын чиг үүргийг тодорхойлж, шүүх ажиллагааны журмыг тогтоож өгсөн байна. Үүнд:

- Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд яллах болон өмгөөлөх талын оролцоог хангах, шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүн таслах ажиллагааг шуурхай, тасралтгүй, чирэгдэлгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, процесс ажиллагааны зөрчлийг илрүүлж зөвтгөх зорилготойгоор ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хуульчлагдсан.
- Талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргаагүй, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зайлшгүй явуулах нөхцөл үүсээгүй гэж шүүгч үзсэн, талууд нэгдсэн саналд хүрсэн буюу маргаангүй бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах шаардлагагүй.[102] Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулахаар заасан байна.
- Өмгөөлөгчийн явуулах үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, оролцоог өргөжүүлэхээр тусгасан. Тухайлбал, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай, мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх тухай хүсэлт тавьж, урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг прокурорт буцаах шийдвэр гаргуулж болохоор заасан. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед өмгөөлөгчөөс гаргасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх санал, хүсэлтийг шүүх хангахаар тусгасан.
- Урьдчилсан хэлэлцүүлгийн үед хэргийг буруу тусгаарласан бол, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх бол, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн бол шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ.[103]
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчдод мэдэгдэх ба хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм

[102] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/-ийн 33.1 дүгээр зүйлийн 33.1.6 дах хэсэг. https://www.legalinfo.mn/law/details/12694?lawid=12694

[103] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/-ийн 33.3 дугаар зүйлийн 33.3.1 дэх хэсэг https://www.legalinfo.mn/law/details/12694?lawid=12694

буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй гэж заажээ.

Гурав.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн орчин үеийн чиг хандлага

Төрийн эрүүгийн бодлого (*public criminal policy*) нь нийгэмд шууд нөлөө үзүүлдэг төдийгүй Эрүүгийн эрх зүйн чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад нийгмийн харилцаанд оролцогчид бодлогын шийдлийг шууд буюу шууд бусаар сонирхож байдаг. Эрүүгийн бодлого гэдэг нь хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, тэдгээрийг оногдуулах, эсхүл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм”[104] гэж доктор, профессор С.Жанцан тодорхойлжээ.

Баруун Европ буюу эх газрын системийн онол, хандлагаар авч үзвэл, өмгөөлөх тал нь нотлох баримтыг шалгах, үнэлэх эрхгүй, харин нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэхэд зарим хязгаарлагдмал эрх эдлэх ба шүүхээс өмнөх шатанд мэтгэлцээний зарчим шууд утгаар үйлчлэхгүй, харин шүүх хуралдаан дээр мэтгэлцэх процесс нь шүүхийн дэг, шүүхийн хяналтаар дамжиж хэрэгждэг ажээ.[105] Шүүхээс өмнөх шатанд сэжигтэн, яллагдагчийн эрхийг хамгаалж өмгөөлөгчөөр оролцох боломжтой боловч эрүүгийн процессын болон органик хууль, процедурын журмуудаар нэлээд тохиолдолд хязгаарлагдсан шинжтэй байдаг. Харин Англи-Америкийн эрүүгийн процессын онол,[106] зарчмаар авч үзвэл, хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий хуульч өмгөөлөгч нь нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх эрхээс гадна прецедент, жишиг, хуулиар хориглоогүй нөхцөлд нотолгооны үйл явцад идэвх санаачилгатай оролцох, нотлох баримтыг шалгахад оролцох, мөн үнэлэх тохиолдолд санал хүсэлт гаргах, чөлөөт мэтгэлцээн, ялын тохиролцооны хэлбэр, зарчмыг үйл ажиллагааны гол баримтлал болгох, шүүхийн төдийгүй шүүхээс өмнөх шатанд яллагчтай харилцан ажиллах, нотолгоог хамтран явуулах зэрэг өргөн эрхтэйн дээр өмгөөллийн үйл ажиллагаа харьцангуй уян хатан, нээлттэй явагддаг байна.[107]

Дээрхээс дүгнэн үзвэл, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах чухал баталгаа бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа шударга явагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг арга болдог байна.

2.Оросын Холбооны Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах нь

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түүхэн уламжлал нь ОХУ-ын нөлөөгөөр хөгжиж ирсэн бөгөөд хоёр улс нь Ром-Германы эрх зүйн бүлд хамаардаг. Иймээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зарим зохицуулалтын хувьд ойролцоо, ижил төстэй байгаа тул уг харилцааг зохицуулсан зүйл, хэсгийг харьцуулан судлах, манай улсын хууль тогтоомжид байхгүй дэвшилтэт шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлэх боломжтой болно.

ОХУ-ын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь холбооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгэн адил үйлчилдгээрээ бусад холбооны улсуудаас ялгаатай ба Мөн ОХУ-ын Дээд Шүүхийн бүгд хурлын удирдамж, хууль тайлбарласан акт, албан ёсоор нэгтгэн дүгнэсэн шүүхийн практик нь хууль тогтоомжийг хэрэглэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

---

[104] Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2002 он 24 дэх тал

[105] Головка Л.В Реформа уголовного процесса во Франции.Государство и право 2001 №8

[106] АНУ-ын Эрх Зүйн Тогтолцооны Товчоон, https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf

[107] Гученко К.Ф Филипинов Б.А Уголовный процесс зарубежных государств I.,2004

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2001 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Энэ хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар 38 дугаар бүлгийн 234-239 дүгээр зүйлд анх тусгаж өгсөн байна. Энэхүү хуулиар шүүх талуудын хүсэлтээр, эсвэл өөрийн санаачилгаар дараах тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг хийхээр тусгасан.[108] Үүнд:

1.Яллагдагчид яллах дүгнэлтийг гардуулснаас хойш долоо хоногийн дотор эрүүгийн хэргийн материалыг уншиж танилцуулсны дараа буюу эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага, хэрэг бүртгэгч хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж бэхжүүлсэн нотлох баримт нь нотлох хүчин чадлаа алддаг. Хуульд заасан шаардлагыг зөрчиж олж авсан нотлох баримт нь хүчин төгөлдөр бус бөгөөд аливаа нөхцөл байдлыг нотлоход ашиглах яллах үндэслэл болдоггүй төдийгүй хэргийн ямар ч нөхцөл байдлыг нотлох үндэслэл болохгүй байхаар заасан.

Холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөөгүй нотолгоо нь дараах зүйлийг агуулна. Үүнд: "*сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчгүй явуулсан мөрдөн шалгах ажиллагаа, өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд өмгөөлөгчтэй явуулахаар заасан ажиллагааг өмгөөлөгчгүй явуулсан, тухайн ажиллагааг өмгөөлөгчгүй явуулсныг сэжигтэн яллагдагч баталгаажуулаагүй бол; гэрч, хохирогч өөрийн таамаглал, дам сонссон ярианд үндэслэн мэдүүлэг өгсөн, мэдүүлгийн эх сурвалжаа тодорхой заагаагүй, хуулийн шаардлагыг зөрчиж" мэдүүлсэн* тохиолдолд нотлох баримтад тооцогдохгүй. Талуудын аль нэг нь нотлох баримтыг хүчингүйд тооцохыг эсэргүүцэж байгаа бол шүүгч эрүүгийн хэрэгт байгаа мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл болон бусад баримт бичгийг нөгөө талд танилцуулах эрхтэй.

2.Шүүгч талуудын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулж дараах тохиолдолд шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаана. Үүнд: "*Яллах дүгнэлт болон ялын санал нь хуулийн шаардлагад нийцээгүй, яллах дүгнэлт болон ялын саналыг яллагдагчид гардуулаагүй, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах үндэслэлтэй хэрэгт яллах дүгнэлт болон ялын саналд энэ тухай тусгаагүй"* эдгээр тохиолдолд шүүгч гаргасан зөрчлийг 5 хоногийн дотор арилгахыг прокурорт үүрэг болгох ба ингэхдээ шүүгдэгчид оногдуулсан таслан сэргийлэх арга хэмжээг мөн шийдвэрлэнэ.

3.Эрүүгийн хэргийг "*хэрэгсэхгүй болгох"* хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байвал шүүх урьдчилсан хэлэлцүүлэг явуулна. [109]

Урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнд шүүгч эрүүгийн хэргийн харьяаллыг тогтоох, прокурорт буцаах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох, шүүх хуралдааныг товыг тогтоох тухай шийдвэрийн аль нэгийг гаргана.

3.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явагдсан эрүүгийн хэрэгт хийсэн судалгаа

3.1.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан хууль зүйн үндэслэл, шалтгаан

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээс өмнө прокурор болон оролцогч талуудын гаргасан хүсэлт, гомдлоор эсхүл шүүгчийн санаачилгаар хийгдэж болохоор хуульчилсан бөгөөд шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа юм.

Прокурорын байгууллагын 2019 оны эхний хагас жилийн мэдээгээр анхан шатны шүүхээр 7334 хэрэг хэлэлцэгдсэнээс 1068 хэрэг буюу 14.6 хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн байна. Урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн хэргээс шүүх 465 хэрэг буюу 43.5 хувийг шүүгчийн захирамжаар прокурорт буцааж, 603 хэрэг

[108] https://www.uia.gov.mn/uploads/trans/attach/20182.pdf
[109] ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2001/-ийн 38-р бүлгийн 234-239-р зүйл

буюу 56.5 хувийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гарган шийдвэрлэжээ.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийсэн хууль зүйн үндэслэлийг судлахдаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ болон сүүлийн жилүүдийн гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан дараах дүүргүүдийг сонгон авч судалгааныхаа үндэслэл болгов. Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зарласан 2019 оны эхний хагас жилийн тоон судалгаанаас дараах нөхцөл тогтоогдож байна. Үүнд:[110]

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.15 дахь заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтээр 52 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.13 дахь заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдлоор 39 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.12 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлтээр 31 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдлоор 27,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.5 дахь заалтад заасан яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт 5 хэрэг;

Үндэслэлийг судлан үзэхэд, мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлтийг гаргах явдал нийтлэг байна.

3.2.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хүсэлт, гомдолыг шийдвэрлэсэн байдал

Дээрх прокурорын байгууллагаас гаргасан 2019 оны эхний хагас жилийн статистик судалгаанаас шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зарласан хэргээс харахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.15 дахь заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх 52 хүсэлтээс 25, 6.13 дахь заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан 39 гомдлоос 12, 6.12 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой 31 санал, хүсэлтээс 11, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай 27 гомдлоос 2, 6.5 дахь заалтад заасан яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай 5 хүсэлтийг тус тус бүрэн хангаж шийдвэрлэжээ.

Дээрх тоон үзүүлэлтээс дүгнэлт хийхэд мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийгдсэн, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн нь 41 хувьтай буюу өндөр байх бөгөөд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүрэн хийгдээгүй, оролцогчдын эрх хангагдаагүй байж болох нөхцөлийг засахад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой гэж дүгнэж болохоор байна.

Мөн шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаадаг хуулийн зохицуулалт орсноос хэрэг шийдвэрлэгдэхгүй удах, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дуусаж ял завших нөхцөл байдал үүсэж байгаа таагүй дүр зураг ажиглагдл

[110] Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой статистик мэдээлэл нь прокурорын байгууллагын статистик судалгаанаас харагдах боломжтой учир прокурорын байгууллагын гаргасан статистик мэдээллийг авч ашигласан болно.

Дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах 17 үндэслэлийг заасан боловч ямар үндэслэл, журмыг ямар хэлбэрээр зөрчсөн тохиолдолд урьдчилан хэлэлцүүлэг явуулах тухай иш татаж[111] тодорхой заагаагүйгээс энэ тухай хүсэлтийг хэрэг бүрт гаргах хандлага ажиглагдаж, шүүхийн ачааллыг зохиомлоор нэмэгдүүлж байгаа нь тогтоогдов. Энэхүү тодорхойгүй байдал нь хуулийн үзэл санаа, ач холбогдлыг алдагдуулж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэргийг прокурорт буцаах, хэргийн хугацааг сунжруулж гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг дуусгавар болгох зорилгоор ашиглах нөхцөл болж байна.

ОХУ-ын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар эрх зүйн орчныг судлан үзвэл, хүнийг хууль бусаар хилс хэрэгт холбогдуулан шалгах явдлыг шийдвэрлэх, таслан зогсоох зорилгоор урьдчилсан хэлэлцүүлэг хийж байна. Өөрөөр хэлбэл, хүнийг хэрэгт холбогдуулан шалгахаас эхлээд урьдчилсан хэлэлцүүлгийг өргөнөөр ашиглан хүний эрхийг хангах тогтолцоог бүрдүүлж байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед хууль зөрчиж, эсхүл эрүүдэн шүүж авсан мэдүүлэг, нотлох баримт зэрэг хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж цуглуулсан нотлох баримтыг хүчингүйд тооцох боломжийг олгох нь зүйтэй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг болон урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6 дахь хэсгийн 6.13 дахь заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, 6.15 дахь заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасан. Гэтэл урьдчилсан хэлэлцүүлгийн дийлэнх нь эдгээр асуудлаар хийгдэж, хэргийг буцааж шийдвэрлэж байгаагаас үзэхэд, хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна гэж дүгнэлээ.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар зөрүүтэй байр суурь, хэрэглээний явцад хүндрэл, бэрхшээлийг арилгахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлсан бүлэг болгон оруулах. Энэхүү тусгайлсан бүлэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго, ач холбогдол, шийдвэрлэх асуудал, арга хэлбэр, үе шатын талаар дэс дараатайгаар тусгах.
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах талаар гомдол, хүсэлтэд тавигдах шаардлага, үндэслэлийг тодорхой болгох. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ямар үндэслэл, журмыг, ямар хэлбэрээр зөрчсөн тухай үйл баримт, мэдээлэл, бусад эх сурвалжийг гаргах тухай зохицуулалтыг нэмэх.
- Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан алдаа, хүний эрхийн зөрчлийг арилгах үүднээс урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шүүгчийн гаргах шийдвэрийн төрөл, хэлбэрийг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Тухайлбал, урьдчилсан хэлэлцүүлгийн явцад

[111]Эрүүгийн хэргийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь яллагдлагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэх хангах ажиллагаа буюу хэргийг прокурор шүүхэд ирүүлнээс хойш 15 хоногийн дотор талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1-33.6.17-т заасан 17 үндэслэл бүхийн асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргахаар хуульчилсан. Гэвч урьчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хүсэлт, гомдолд ямар учир шалтгаан үндэслэл журмын дагуу урьдчилсан хэлэлцүүлгийг явуулах талаар шүүх, прокурор, өмгөөлөгч нар тодорхой дурддагүй ерөнхийлөн гэнэт урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт гомдол гаргаж, шүүх өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэгийг явуулж байгаа нь практикт ажиглагдсан.

нотлох баримтыг хүчингүйд тооцох, хүний эрхийн зөрчилтэй холбоотойгоор зарим шийдвэрийг өөрчлөх, тодорхой ажиллагаа хийхийг даалгах зэрэг шийдвэр гаргах боломжийг олгох.

Ном зүй

Хууль тогтоомж

- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2017

Ном, сурах бичиг, гарын авлага

- Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001
- Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг УБ. 2011
- Осакве К., Харьцуулсан эрхзүй судлал: Ерөнхий ба тусгай анги УБ. 2005
- Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрхзүйн тогтолцоо олон улсын Симпозиумын илтгэлүүдийн эмхэтгэл УБ. 2000 он
- Penny Darbyshire, Eddey and Darbyshire on the English Legal system, Sweet and Maxwell, 7th ed., 2001
- См.:Комментарий к УПК РФ подред. Лебедева, Божьева. М. 2003. С.455.
- См.,например: Лазарев В.А. Предварительное судебное производство. - М. С.54.

Цахим эх сурвалж

- АНУ-ын эрх зүйн тогтолцооны товчоон 2007 он https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf
- Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэлэн. Судалгааны тайлан эмхэтгэл 2020 он https://drive.google.com/file/d/1q4Q7p7zoewazochw1ZIB22zHjxbnhZWU/view
- Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн номын сан, мэдээлэл хариуцсан ахлах референт С.Билгүүн. Хүний салшгүй эрхийн баталгаа-эрх зүйн зайлшгүй процесс (due process of law) 2019 http://resource3.sodonvision.com/shuuh/file/2014/5/7ktfh9nposimzbs5yxo95vpdf
- Оросын Холбооны Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2001 он http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН ТОО БҮРТГЭЛД ХҮНИЙ ДҮР ТӨРХ СУДЛАЛЫГ АШИГЛАЖ ИРСЭН НЬ

Г.Бямбадорж
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Цагдаагийн тоо бүртгэлд хүний дүр төрх судлалыг ашиглаж ирсэн уламжлалыг судалж, гэмт хэрэгтэй тэмцэхэд хүний дүр төрх судлалыг ашиглахын ач холбогдлыг тодорхойлсон.

Түлхүүр үг. Цагдаагийн байгууллага, цагдаагийн тоо бүртгэл, гэмт хэрэг, хүний дүр төрх, криминалистик.

Криминалистикийн шинжлэх ухаанд хүний дүр төрх судлал нь мэдлэгийн нэгэн тусгай салбар болон хөгжиж ирсэн. Энэ нь хүний гадаад төрх байдал, түүний ангилал, онцлог, шинж чанарын талаар авч үздэг.

Хүний дүр төрхийг судлах, түүний шинж тэмдгийг тодорхойлох үйл явц МЭӨ 4 дүгээр зууны үед Эртний Египтэд зугтаж гарсан хүмүүсийг хайх зорилгоор тэдний гадаад төрх, нас, өндөр, зургийн онцлог, арьсны өнгө, үс, нүд, нүүрний хэлбэр зэрэг шинж тэмдгийг ашиглан эрэн хайж байжээ.[112] Тухайлбал, түүхч И.Ф.Крыловын тэмдэглэлд МЭӨ 4 дүгээр зууны эхэн үед Аристогены залуу боол, Крисиппусын хүү Александрия руу зугтав. Боолын нэрийг Херман, хоч нь Нейлос. Тэрээр Сирийн уугуул 18 настай, тэрээр дунд зэргийн өндөр, сахалгүй, шулуун хөлтэй, уруулын зүүн хэсэгт сорви, хамрын зүүн талд тууралттай, нөмрөг, арьсан хормогчтой боолыг эрэн сурвалжилж барьсан тухай тэмдэглэсэн байна.

Түүнчлэн, гадаад шинж тэмдгүүдийг тайлбарлах үйл явц үргэлжилж XVIII зууны төгсгөлд Оросын Холбооны Улсад гэмт хэрэгтнүүдийн гадаад төрх байдлын талаарх мэдээллийг бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж байсан нь 1843 онд олджээ.

Францын эрүүгийн цагдаагийн үүсгэн байгуулагч "Сурте" цагдаагийн газарт бүртгэлтэй байсан бүх гэмт хэрэгтнүүдийн тухай мэдээллийг цуглуулж архив байгуулжээ. Уг архивт гэмт хэрэгтнүүдийн нэр, үйлдсэн гэмт хэргийн төрөл, гадаад төрхийг тодорхойлж бичжээ.

1829 онд Парис хотод Шүүгчийн дэргэд гэмт хэрэгтнүүдийг олж тогтоох зорилгоор бүртгэлийн карт хөтөлж хадгалах ажлыг эхлүүлж бүртгэгдсэн гэмт хэрэгтнүүдийн нэрээр картуудыг цагаан толгойн үсгээр дараалан хэдэн арван жилийн турш байрлуулсан байв.

Ийм картын индексийг ашиглан цагдаагийн байгууллагаас саатуулагдсан хүний хэн болохыг тогтоох боломжтой байсан. Гэхдээ тэр нь жинхэнэ овог, нэр эсэх нь эргэлзээтэй байв. 1870-аад оны сүүлчээр хэдэн сая ийм карт цуглуулсан байсан ч шүүхийн танхимын үр ашиг тийм ч өндөр биш байв.[113]

Гэмт хэрэгтнүүдын зургийг 1840-өөд онд авч эхэлсэн бөгөөд гэрэл зургуудыг бүртгэлийн картад нэмж оруулан 1874 оны 1 дүгээр сараас эхлэн Парисын цагдаагийн байгууллага гэмт хэрэгтнүүдийн гэрэл зургийн цомгуудыг цуглуулж эхлэв. Берлиний Эрүүгийн цагдаагийн газарт 1876 онд гэмт хэрэгтнүүдийн зургийн цомгийг нэвтрүүлж, тэнд байгаа гэрэл зургуудыг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж байжээ.

---

[112] Крылов И.Ф. Очерки истории криминалистики и криминалистической экспертизы. Л., 1975. С-78
[113] Торвальд Ю. Сто лет криминалистики. М., 1974. С-98

Харин Америкт 1820-1850 онд хүний гадаад шинж чанараас зан авир, зан байдлын талаар дүгнэлт гаргахыг оролдсон. Хүний гаднах шинж чанаруудыг дотоод бие махбодын шинж чанаруудтай өөрөөр хэлбэл, тархины хэлбэрийг харьцуулахыг оролдсон бөгөөд энэ нь мэдэгдэхүйц дэвшил байв.[114]

Дарвины онолыг суурь болгон ашигласан хүмүүсийн нэг Ломбросо юм. Тэрээр гэмт хэрэгтнүүд нь гэмт хэрэг үйлдээгүй хүмүүс шиг хувьсан өөрчлөгдөөгүй бөгөөд гэмт хэрэг нь гэмт хэрэгтнүүд ба гэмт бус хүмүүс хоорондын биологийн ялгаанаас үүдэлтэй гэж үзэж байв.

Ломбросо нь ноцтой гэмт хэрэгтнүүд эрүүгийн шинж чанараа өвлөж, төрдөг гэж тайлбарласан. Тэд хүчтэй эрүү, том шүдтэй, дух нь томорсон, урт гартай байв. Эдгээр төрлийн гэмт хэрэгтнүүд нийт гэмт хэргийн гуравны нэг орчим хувийг эзэлж байжээ[115].

Иймд гэмт хэрэг үйлдэж болзошгүй, хорих ял шийтгэгдсэн, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн зэрэг судалгаанд дээр дурдсан онцлог содон шинж тэмдэг, хувийн зан төрх байдал зэргийг судалж обьектын судалгаанд тусгах онол, практикийн ач холбогдолтой байна. Үүнийг хорих ял эдлээд суллагдсан хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн тоо үзүүлэлтээр тайлбарлаж болох юм.

1860 онд Лувены шоронгийн дарга Стивенс Швейцарь хоригдлуудын бие махбодын хэсгийг хэмжиж, үр дүнг бүртгэлийн картан дээр бичиж эхлэв. Стефенсийн үйл ажиллагааг түүний гадаад үзэмжээс хамааран хүний гэмт хэргийн бүртгэл эхэлсэн гэж үзэж болно. Гэсэн хэдий ч Парисын цагдаагийн албан тушаалтан Альфонс Бертиллон үүнийг антропометрийн таних нэрээр боловсруулсан бөгөөд ийм бүртгэлд суурилсан шинжлэх ухааны аргыг Францад бодитоор хэрэгжүүлжээ. Бертлон энэ системд орж, антропологийн судалгааны арга зүйг антропологичдоос суралцсан байжээ.

Энэ тогтолцооны үндэс суурь нь Бельгийн эрдэмтэн Адольф Куетлет хүний биеийн хэмжээ өөрчлөгдөх нь тодорхой хууль тогтоомжийн дагуу явагддаг, хүн бүрийн хувьд биеийн хэсгүүдийн хэмжээсийг тус тусад нь хийх санаа сэджээ.
Ингээд хоригдлуудыг бүртгэхдээ Бериллон хэмжилтийн аргыг баяжжуулж зогсож буй өндөр, сунгасан гарны урт, суух өндөр, толгойны урт, өргөн, баруун чихний урт, өргөн, зүүн хөлний урт, дунд хурууны урт, зүүн гарын хурууны урт, зүүн гарын гарын урт, нүдний цахилдагийн өнгийг мөн тэмдэглэсэн бөгөөд үүнийг тодорхойлох тусгай хүснэгтийг боловсруулсан бөгөөд энэ өнгийг долоон бүлэгт хуваж бүртгэдэг байжээ.

Парист 1882 онд Альфонс Бертиллоны санал болгосон эрүүгийн бүртгэлийн системийг туршлагаас үндэслэн 1888 онд Францын Засгийн газар баталж, зөвшөөрсөн бөгөөд энэ үеэс эхлэн гэмт хэрэгтнүүдийг бүртгэх үндсэн систем болжээ. Үүний дараа ОХУ-ын нэрт судлаач В.И.Лебедев “Гэмт хэргийг илрүүлэх урлаг” гарын авлагадаа Бериллоны системийн дагуу тусгай тэмдгийг судлах дараах журмыг зааж өгсөн байдаг: 1-зүүн гар, 2-баруун гар, 3-нүүр ба хүзүү, 4-цээж, 5-ар тал, 6-хөл[116] гэсэн дараалал тогтоожээ.

Үүний зэрэгцээ В.И.Лебедев өөрийн судалгааны ажлаараа тухайн этгээдийн гарын хурууны үений үрэвсэл байгаа эсэх, гарын хуруу, гарын алганы гадна болон дотор талд онцлог содон шинж тэмдэг, шарх сорви байгаа эсэх гэх мэт өвчин эмгэг, хөхөрсөн, тайруулсан зэрэг төрөлхийн болон үүссэн бусад шинж чанаруудыг тусгасан байна.

ОХУ-д антропометрийг анх 1890 онд Санкт-Петербург хотод нэвтрүүлсний дараа нэмж 12 антропометрийн товчоог нээв. Антропометрийн систем нь хүнийг бүртгэх, танихад чухал амжилт байв. Гэсэн хэдий ч нэг хүнийг дахин хэмжихдээ хэмжилт хийж байсан хүний олж авсан мэдлэг чадвараас шалгаалж үр дүн өөр өөр

[114] https://en.wikisource.org/wiki/1911_Encyclop%C3%A6dia_Britannica/Monboddo,_James_Burnett,_Lord
[115] Lombroso, C. (1876). L'uomo delinquent [Criminal man]. Milan, Italy: Hoepli
[116] См.: Лебедев В. И. Искусство раскрытия преступлений. СПб., 1912. С. 29.

байсныг урьдчилан мэдэж, нэг хүний давтан хэмжилт хийх хүснэгтийг боловсруулсан хэрэглэсэн үр үртэй байв.[117]

Түүнчлэн, бүртгэлийн мэдээллийг зөв уншихын тулд ижил агуулгатай ижил нэр томъёог ашигласан. Альфонс Бериллилоны хэлснээр тайлбарын дараалал нь дараах байдалтай байв. Үүнд:

- Дух, хамар, баруун чих, уруул, ам, эрүү, хөмсөг, зовхи, нүдний шил, нүдний залгуур, дотогшоо, үрчлээ, нүүрний нүүрний нүүрний дүүрэн байдал, зууван.
- Нүүрний элемент бүрийг харьцангуй хэмжээ, төрөл, өнгөөр нь тэмдэглэх нь зүйтэй. Тэдгээрийн гадаад төрх шинж чанаруудыг хэдий чинээ сайн тодорхойлж чадах тусам хөрөг зураг нь амаар гарч ирэв.

Гэсэн хэдий ч амаар тайлбарлах аргачлал нь тодорхой, бодлоготой байсан ч нэлээд төвөгтэй болж хувирсан. Зөвхөн хамгийн чадварлаг ажилчид л энэ техникийг бүрэн эзэмшиж, хайлтын ажилд амжилттай хэрэгжүүлж байжээ.

Швейцарын Лозаннагийн их сургуулийн профессор Рудольф Арчибалд Рейс Алфонс Бериллилоны аргаар хүнийг таних, үүний тулд нүүрний хэсгүүдийн зургийг түүний бие даасан элементийн схем зургаар хавсаргасан байв. Рейсийн үзэж буйгаар эдгээр зурагнууд нь уншигчдын анхаарлыг тухайн хүний нүүрний онцлог шинж чанарт анхаарлаа хандуулж, түүнийг санахад нь туслах ёстой. Рейс мөн гадаад төрх тэмдгийг тодорхойлох тусгай дижитал кодыг боловсруулсан бөгөөд үүний тусламжтайгаар гэмт хэрэгтнүүдийн дүр төрхтэй холбоотой мэдээллийг телеграфаар дамжуулах боломжтой болгожээ.

Герман Улсад 1925 онд Берлиний эрэн сурвалжлах хэлтсийн дарга Ханс Шнайкертын хүний онцлог содон шинж тэмдгүүдийн тухай сургааль ном хэвлэгджээ. Энэ бүтээлд хүний гадаад төрхийн анатомийн болон функциональ шинж тэмдгүүдийг биеийн байдал, дохио зангаа, харц, нүүрний хувирал, хөдөлгөөн, хувцаслалт зэргийг нэмж тодорхойлж гэмт хэрэгтнүүдийн дүр төрх, сураггүй алга болсон болон хэн болох нь тогтоогдоогүй цогцосыг тогтоох таних зэрэгт үр дүнтэй ашиглаж байсан нь цагдаагийн үйл ажиллагаанд ахиц гарч байжээ.[118]

ОХУ-ын судлаач Н.В.Терзиев 1950 онд шүүх эрх зүйн сурах бичигт криминалистикийн шинжилгээ хийхэд ажиглагдах ёстой үндсэн дүрмийг тусгасан. Тэрээр тэдгээрийг 1951 онд хэвлүүлсэн “Криминалистикийн тухай” бүтээлд тайлбарласан. Мөн 1956 онд “Гадаад дүр төрхөөр нь хүний бие махбодиор танин мэдэхүй” хэмээх бүтээлдээ нарийвчлан судалж тусган хэвлүүлжээ.

ОХУ-ын нэрт эрдэмтэн А.А Гусев 1960 онд “Гадаад төрхөөрөө таних байдлыг тогтоох зорилгоор шүүх эмнэлгийн үзлэгийг зохион байгуулах аргачлал” бүтээл нь цагдаагийн үйл ажиллагаанд ялангуяа гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

Энэхүү сургалтын арга зүйн гарын авлагад тодорхой үзлэг шалгалтын үндсэн дээр зургаас гаднах шинж тэмдгийг судлах үндсэн аргуудын тодорхойлолтыг өгч, зурагнаас гаднах шинж тэмдгүүдэд дүн шинжилгээ хийх зөвлөмжийг гаргаж, шинж тэмдэг, шаардлагын найдвартай байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

ОХУ-ын эрдэмтэн А.Ю.Пересункин 1960 онд гэмт этгээдүүдийн гадаад шинж тэмдгийг судалж гадаад төрх байдлын шинж тэмдгүүдийн тогтолцоог танилцуулсан бөгөөд үүндээ анатомийн, үйл хөдлөлийн, дагалдах шинж тэмдэгүүдийг тусгаж өнөөг хүртэл хөгжиж иржээ.[119]

АНУ-ын криминологич Готтфредсон, Хирчи нар гэмт хэрэгтнүүдийн талаарх судалгаануудаас олж мэдсэн зүйл дээр үндэслэн онол боловсруулахыг зорьжээ.

---

[117] https://studref.com/323712/pravo/gabitoskopiya_kriminalisticheskoe_uchenie_vneshnem_oblike_cheloveka

[118] См.: Криминалистика. Техника и тактика расследования преступлений. М., 1938. Ч. 1. Разд. 1.

[119] См.: Пересункин А. Ю. Установление личности по признакам внешности (словесный портрет). М., 1960; П

Тэдний судалгаагаар гэмт хэрэгтнүүд өөрийгөө хянах чадвар багатай болохыг мэдэж гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, хүйс, үндэс угсаа, гэмт хэргийн төрлөөр нь эрүүгийн үйлдэл, зан үйлийг тайлбарлажээ.

Өөрийгөө хянах чадварыг өөрсдийгөө ямар нөхцөл байдалд байгаагаас үл хамааран хүмүүс гэмт зан үйлдлээс зайлсхийх хандлага гэж тодорхойлсон.

Мөн өөрийгөө хянах чадвар багатай хүмүүсийг зан байдал, хандлагыг нарийвчлан судалж тогтоосон байна. Тухайлбал, тэд тэсвэр хатуужил султай, хувиа хичээж хайхрамжгүй ханддаг, гэр бүл, нөхөрлөл, мэргэжлийн хувьд хэвийн байдагч ерөнхийдөө тогтворгүй хандлага илэрдэг, бухимдалд хамгийн бага тэвчих чадвартай, зөрчилдөөнд амаар бус бие махбодын хувьд хариу үйлдэл үзүүлэх хандлагатай, эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн чадвар эзэмших, үнэлэх чадвар бага байдаг гэжээ.[120]

Эдгээр шинж чанаруудаас шалтгаалан өөрийгөө хянах чадвар багатай хүмүүс зөвхөн гэмт хэрэгт холбогдоод зогсохгүй тамхи татах, мансууруулах бодис хэрэглэх, хууль бус бэлгийн харьцаанд орох зэрэг эрсдэлтэй байдаг нь судалгаагаар нотлогджээ.[121]

Иймд гэмт хэрэг үйлдэж болзошгүй, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн, өөрийгөө хянах чадвар султай сэтгэцийн өвчтэй зэрэг хүмүүсийн зан байдлыг судалж обьектын судалгаандаа тусгах нь зүйтэй.

Шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийг бүхий л салбарт нэвтрүүлж, XX зууны сүүлийн арван жилд гадаад дүр төрхийг тодорхойлох, судлах ажилд компьютер ашиглах боломжийн талаар судалгаа хийж эхэлсэн бөгөөд өдгөө XXI зуунд хиймэл оюун ухаан ашиглаж төрөл бүрийн программ хангамж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын обьектын судалгаанд баримтлах онол, үзэл баримтлалыг эрдэмтэн, судлаачид цогц байдлаар судлаагүй, иймд обьектын судалгаанд баримтлах онол, үзэл баримтлалыг тодорхойлох, хөгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагын обьектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох гэмт хэрэг үйлдэгчдийн судалгаа, архаг архичдын судалгаа, гэмт хэрэгт холбогдогчийн судалгаа, эрэн сурвалжлагдаж буй этгээдүүдийн судалгаа, түгшүүр төрүүлэгчдийн зэрэг судалгаанд дээр дурдсан криминалистикийн дүр төрх судлалын ухааныг өргөнөөр ашиглаж үйл ажиллагаандаа хэвшүүлэн, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглаж болох юм.

Нөгөө талаар обьектын судалгаанд авагдсан этгээдийн гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн дүр төрхийг судалж тогтоох нь тухайн этгээдийн болон түүний гэр бүлд байгаа хүмүүсийг гэмт хэрэгт өртөж хохирох, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагын тоо бүртгэл хийх, хөгжүүлэх, өргөтгөх, гүнзгийрүүлэх, сайжруулах, боловсронгуй болгох үйл явц нь судалгааны обьектыг танин мэдэх үйл явцын дараа явагддаг процесс гэж үзэж болохоор байна.

Санал

- Цагдаагийн байгууллагын тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагааг хөгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа хийж, үр дүнг практикт нэвтрүүлэх;
- Судлагдаж буй этгээдийн талаар өргөн мэдээлэл агуулсан, тухайн этгээдийн дүр төрхийг тусгасан субьектын судалгаа хийх загвар боловсруулж ашиглах;

[120] Gottfredson, MR, & Hirschi T. (1990). A general theory of crime. Stanford, CA: Stanford University Press.

[121] Perrone, D., Sullivan, C., Pratt, TC, & Margaryan, S. (2004). Parental efficacy, self-control, and delinquent behavior: A test of a general theory of crime on a nationally-representative sample.

- Криминалистикийн тоо бүртгэл, хүний дүр төрх судлалын ухааныг ашиглан цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлыг хөгжүүлэх, шинэчлэл хийх зэрэг болно.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Б.Зоригтбаатар
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга. Зам тээврийн гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, обьектив шалтгаан, нөхцөл, субьектив хүчин зүйлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга замын талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Зам тээврийн осол, гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдал, автотээврийн хэрэгсэл, жолооч, зорчигч.

Удиртгал

Зам, тээврийн ослын шалтгаан, нөхцөлийг жолоочийн, явган зорчигчийн буруутай үйлдэл, замын нөхцөл, техникийн гэмтлийн улмаас гарсан осол хэмээн бүлэглэн үзэж болно. Эдгээрээс замын нөхцөл буюу авто зам, түүний төлөвлөлт, ашиглалт, арчлалтаас үүдэн гарсан нь нийт осол, хэргийн дотор дөнгөж 0.1 хувийг эзэлж байна. Гэтэл авто замын сүлжээ өндөр хөгжсөн ОХУ, Их Британи, Франц, Герман зэрэг улсад замын нөхцлөөс шалтгаалан гарч буй осол нийт ослын 24-30 хувийг эзэлдэг байна.[122]

Манай улсын авто замд халтиргаа, гулгаа, эвдрэл гэмтэл, стандартад нийцсэн гэрэлтүүлэг, тэмдэг, тэмдэглэл, аюулгүйн зурвасгүй, зорчих хэсгийн өргөн хангалтгүй зэрэг замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлээс шалтгаалсан зам, тээврийн осол, хэрэг цөөнгүй бүртгэгдэж байгаа хэдий ч замын нөхцөл байдлаас шалтгаалан үйлдэгдсэн нь албан ёсоор тогтоож, бүртгэж чадахгүй байна.

Дэлхийн хэмжээнд нэг жилд гарч байгаа авто ослын 20 орчим хувь нь замын эвдрэлээс, 49.6 хувь нь нойтон болон халтиргаатай замаас үүдэлтэй гэж үзсэн байдаг. Манайд зам, тээврийн осол, зөрчил, гэмт хэргийн статистик үзүүлэлтэд замын нөхцөл байдлаас шалтгаалсан ослын хүчин зүйлд техникийн гэмтэл, зорчих хэсгийн гэрэлтүүлэг, зам орчны нөхцөл байдлыг авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагын буруутай үйлдлийг тогтоодоггүй.

Зам, тээврийн ослын улмаас бусдад учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн болон хариуцлага тооцсон бүртгэл байхгүй, замын нөхцлөөс шалтгаалсан зам, тээврийн осол, хэрэг харьцангуй бага бүртгэгдсэн хэвээр байна. Замын нөхцлөөс шалтгаалан бүртгэгдсэн зам, тээврийн осол, хэрэг улсын хэмжээнд сүүлийн 6 жилийн хугацаанд гарсан нийт ослын 0.1-0.3 хувийг эзэлж байна.[123] Иймээс зам тээврийн осол, гэмт хэрэгт нөлөөлж буй шалтгаан, нөхцлийг арилгахад эрх зүйн орчин, практик байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ур чадварт анхаарах асуудлууд, бусад улсын туршлагын талаар судлах шаардлагатай байна.

Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ойлголт

Замын хөдөлгөөн гэдэгт нийтийн хэрэгцээний зам дээр явганаар болон тээврийн хэрэгслээр хүн, ачаа шилжих үйл ажиллагааг ойлгоно.[124]

Хөдөлгөөн гэж аливаа биетийн шилжилт гэж ойлгодог боловч замын хөдөлгөөн нь дээрх тодорхойлолтын дагуу нийгмийн харилцаан дахь автозамын хөдөлгөөнтэй холбогдох зохицуулалтын хүрээгээр хязгаарлагдаж буй тодорхой

---

[122] http://unuudur.mn/%D0%BC. Хандалт 2021.09.24.

[123] М.Гантулга. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа, шийдвэрлэлт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар зөвлөмж. УБ. 2019 он., 16 дахь тал.

[124] Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2015 он. №28

дүрэм, журмаар зохицуулагддаг жолооч, явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчийн хөдөлгөөнийг хэлнэ.[125]

Зам тээврийн ослын гэмт хэрэг гэдэгт Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд заасан Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмээр тогтоосон хэм хэмжээг гэм буруутайгаар зөрчсөн үйлдлийг хамааруулна.

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын журам, хүний амьд явах эрх, эрүүл мэндийн халдашгүй байдал, бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн холимог хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм.[126]

Монгол Улсын түүхийн хуудсыг сөхөж үзвэл, зам тээврийн осол, гэмт хэрэг нь тухайн үед замын хөдөлгөөнд оролцож байгаа, тээврийн хэрэгсэл болон хүн амын нягтралаас хамаарч байгаа нь харагдаж байна.

Монгол оронд эрдэм шинжилгээний томилолтоор 1919-1920 онд ажилласан Оросын худалдааны төлөөлөгч И.М.Майскийн бичсэнээр Монгол Улсад автомашин бий болохоос өмнө буюу 19 дүгээр зууны сүүлчээр нийслэл хот Өргөөгийн гудамжинд хүндээр бие засаж байсан Монгол эмэгтэйг Оросын консулын сүйх тэргийн жолооч дайрсан нь хамгийн анхны зам тээврийн осол болж тэмдэглэгдэн[127] үлдсэн байна.

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилдаг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь дэлхий нийтийн өмнө шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болсонтой холбоотойгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны 10 жил болгож, дэлхий нийтэд тунхагласан байдаг.

Гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн онолын үүднээс авч үзвэл, гэмт хэрэгтэй тэмцэх тухай ойлголт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх гэсэн харилцан шүтэлцээтэй үйл ажиллагааны цогц юм. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүргийн салшгүй нэг хэсэг гэж ойлгож болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн гэж[128] хуульчилсан.

Хоёр.Зам тээврийн ослын гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Төр засгаас дэд бүтэц, зам харилцааг сайжруулах, зам засварлах, шинээр барих, авто замын хөдөлгөөнийг телекамерын хяналтад авах зэрэг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байгаа боловч зам тээврийн осол, гэмт хэрэг нь:

-Жолоочийн буруутай үйлдлээс,

-Явган зорчигчийн буруутай үйлдлээс,

-Замын нөхцөлөөс,

---

[125] Ч.Жаргалсайхан. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн үүсэл, хөгжил. УБ., 2000. 25 дахь тал

[126] С.Гантулга. Б.Энхболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/.УБ хот. 2018. 515 дахь тал

[127] А.Энхболд. Замын хөдөлгөөний аюулгүй байдал. УБ., 2007. 13 дахь тал

[128] Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2019. №42

-Техникийн гэмтлээс шалтгаалан гарсаар байна.

Улсын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн шалтгааныг харуулбал,

Улсын хэмжээнд 77444 зам тээврийн ослын шинжтэй дуудлага ирсэнээс 1276 хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 25302 зам тээврийн осол, 561 хүн амь насаа алдсан байна.[129] Үүний шалтгааныг авч үзвэл:

Үүнээс үзвэл зам тээврийн ослын шалтгааны 97.9 хувийг жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж байгаа бол 2.1 хувийг явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан байна.

[129] https://transportation.police.gov.mn/a/4218 хандалт 2021.09.24

Жолоочийн буруугаас гарч байгаа зам тээврийн ослыг жолоочийн хөдөлгөөнд оролцох соёл, хууль дүрмийн мэдлэг сайнгүй, Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлдэггүй, биелүүлэхийг хүсдэггүй, өөрөөр хэлбэл, хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүрэг, хариуцлагыг ухамсарлаж биелүүлэх явдал хангалтгүй, тээврийн хэрэгслийн жолоодох ур чадвар муу байгаатай холбон үзэж болно. Жолоочийн буруугаас гарч байгаа зам тээврийн ослын дийлэнх нь соргуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос, хажуу хоорондын зай тохируулаагүйгээс, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөнөөс, аюул тохиолдох үед тээврийн хэрэгслээ зогсоох арга хэмжээ аваагүйгээс, хурд хэтрүүлсэнээс, эгнээ байр буруу эзэлснээс шалтгаалан гарч байна.

Зам, тээврийн осол, гэмт хэргийн улмаас нас барсан тохиолдол орон нутгийн замд 78 хувь гарч байгаа нь энд тавих хяналтыг сайжруулах, харин Улаанбаатар хотод зам, тээврийн ослоор нас барсан иргэдийн дийлэнх хувийг явган зорчигч эзэлж байгаад анхаарч холбогдох арга хэмжээ авах шаардлагатайг харууллаа. Түүнчлэн, зам, тээврийн осолд жолоочийн буруутай үйлдэл 98 хувь байгаа тул жолооч бэлтгэх, мэргэшүүлэх, сургуулийн наснаас дадал зуршил бий болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх цаг болсон юм.[130]

Замын хөдөлгөөнд оролцож буй явган зорчигчид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль, дүрмийг биелүүлэх нь зөвхөн жолоочид л хамаатай мэтээр ойлгож байгаагаас зам тээврийн осолд өртөх явдал их байна. Сүүлийн 3 жилийн

[130] http://mminfo.mn/news/view/17722. Хандалт 2021.09.24

байдлаар зам тээврийн осол, гэмт хэргийн 6.5 хувь нь явган зорчигчийн буруугаас үйлдэлтэй байна. Тухайлбал, гарц, гарамгүй газраар зам хөндлөн гарах, гэрлэн дохио зөрчих, тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх, зогсож буй тээврийн хэрэгслийн урдуур нь тойрох, замын зорчих хэсэг болон хашлагыг дагаж явах, архидан согтуурч замын зорчих хэсэг дээр хэвтэх, унтах зэргээс автомашинд дайрагдаж, шүргүүлэх тохиолдол их байна.

Замын нөхцөл ба техникийн гэмтлийн улмаас гарсан зам тээврийн осол, хэргийн хувьд замын гадаргуу, үзэгдэх орчин, гэрэлтүүлэг чимэглэл тааруу, замын тэмдэг, тэмдэглэл, ойлгомжгүй байснаас болох, тээврийн хэрэгсэлд үүссэнээс хэрэг, осол үйлдэгдэхийг ойлгоно. Энэ нь техникийн бүрэн бүтэн, аюулгүй, найдвартай байдал, түүний тоноглол хамгаалалт, үйлдвэрийн баталгаа, стандарттай холбоотой.

Монгол Улсад бүртгэлтэй автомашины жолооны хүрд 404803 буюу 49.7 хувь нь зүүн талдаа, 410206 буюу 49.7 хувь нь баруун талдаа байрлалтай байна. Нийслэлд жолооны хүрд буруу буюу баруун талдаа байрлалтай 255756 автомашин хөдөлгөөнд оролцож байгаа нь нийслэлд бүртгэлтэй автомашины 55.7 хувийг эзэлж байна.[131]

Жолооны хүрдны байрлалаас хамаарсан гэрлийн тусгал нь зам, тээврийн ослын үзүүлэлтэд нөлөөлдөг болохыг 2020 онд хийсэн судалгаагаараа мэргэжилтнүүд тогтоосон байдаг. Уг судалгаагаар гэрлийн тусгалын хэмжээ, далайц зам, тээврийн осолд шууд нөлөөтэй болохыг харуулж, жолооны хүрдний байрлал буюу түүнтэй тохируулан хийсэн гэрлийн тусгалын инженерийн шийдэл гэж үзсэн.

Европын зарим оронд буруу тусгалтай тээврийн хэрэгсэл улсын хилээр гарах үед гэрлийн шилний урд хэсэгт наалт нааж сөрөг хөдөлгөөнд яваа тээврийн хэрэгслийн жолоочийн нүдийг гялбуулахгүй байх арга хэмжээ авдаг юм билээ. Мөн их гэрлийн тусах өнцгийг нь зөв талдаа илүү байхаар гэрлийн суурийг өөрчилж, тааруулдаг байна. Энэ нь жолоочийн нүдэнд очих гэрлийн хүчийг бууруулах, зорчих хэсгийн баруун захыг гэрэлтүүлэх боловч төгс шийдэл биш юм байна. Бурууталдаа хүрдтэй тээврийн хэрэгслүүдийн ойрын гэрлийн тусгал нь өөдөөс яваа жолоочийн нүдийг гялбуулахдаа холын гэрлийнхтэй ойролцоо байдаг.[132]

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор “Буруу талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хүрдний байрлалыг солих, гэрлийн тусгалыг өөрчлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих замаар буруу талдаа жолооны хүрдтэй автомашины тоог цөөрүүлнэ”[133] хэмээн стратеги, төлөвлөгөө баталсан ч өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтад сөргөөр нөлөөлж буй нь судалгааны явцад тогтоогдсон гэж үзэж болох юм.

Зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг ойлгоно. [3]

Замын хөдөлгөөн шуурхай байх үндсэн нөхцлийг нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөх шаардлагатай.

Замын эвдрэл гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан, нөхцөлүүдийн нэг болдог байна. Сүүлийн жилүүдэд нийслэл хотод баригдаж байгаа барилгууд зогсоолгүй төлөвлөгдөж тээврийн хэрэгсэл зогсох, зам талбай нь хүрэлцээгүй байгаагаас хөдөлгөөнд зориулсан зорчих хэсэг дээр тээврийн хэрэгсэл байрлаж байгаа нь осол, хэрэг үйлдэгдэх бас нэг шалтгаан нөхцөл болдог.

---

[131] https://transportation.police.gov.mn/a/4218.хандалт.2021.09.24

[132] Н.Алтанхуяг. Б.Бүрэнзэвсэг. Автотээврийн үндэсний төвийн техникийн хяналтын судалгаа. УБ. 2019. 13 дахь тал

[133] Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол

Дүгнэлт

Тээврийн цагдаагийн алба нь дунд болон урт хугацааны стратеги төлөвлөлтийг хийж боловсон хүчний нөөцийг төлөвлөх шаардлагатай байна.

Алба хаагчдын ажлын байрны тогтвортой байдлыг хангах, албан тушаал дэвшүүлэх шалгуурыг тодорхой болгох, алба хаагчид албандаа итгэх итгэл нэмэгдэнэ.

Хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, осол, гэмт хэрэг үйлдэгдсэн байдалд дүн шинжилгээ хийж, зам тээврийн осол, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг бодитой тогтоон зөв оновчтой сонгож зохион байгуулах шаардлагатай байна.

Жолооч бэлтгэх сургууль, дамжааны сургалтын чанарыг дээшлүүлэх, түүнд тавих хяналтыг үр дүнтэй болгох замаар жолоочийн үүрэг, хариуцлага, ур чадвар, хөдөлгөөнд оролцох соёлыг дээшлүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хор уршиг, хохирлын бодитоор үнэлэх, мөн замын нөлөөллөөс шалтгаалсан хүчин зүйлийг бүрэн тогтоож чадахгүй байна.

Санал

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг санхүүжүүлэх. Тухайлбал, жолооч бэлтгэх сургалтын төвийг байгуулах, шинээр бэлтгэгдэн гарч байгаа алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зэрэг ажилд зарцуулах.

Хот төлөвлөлтөд зам, замын байгууламжийг хамтад нь төлөвлөх, зам шинээр барих, арчлах, сэргээн засварлахад аюулгүй стандартыг чанд мөрдөх, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх. Замын нөхцөлөөс гарсан зам тээврийн осолд замын байгууламж хариуцсан албад, албан тушаалтанд акт тавигддаггүй, жолооч, явган зорчигчдын буруугаас зам тээврийн осол гарсан гэж акт тавигдаж байна. Иймд замын байгууламж, зам хариуцдаг байгууллагад хариуцлага ноогдуулж байх.

Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр бүртгэгдсэн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн бичлэг, гэрэл зургийг үндэслэн зөрчил гаргагчид зөрчлийн шийтгэл оногдуулж эхэлсэн бөгөөд цаашид гудамж замын хөдөлгөөний хяналт зохицуулалтад техникжүүлэлт, камержуулалт, автомашинжуулалт, компьютержуулалтыг цогцоор нэвтрүүлэх.

Орон нутгийн босоо, хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замын дагуу 150 километр тутамд хяналтын постыг байгуулах. Пост байгуулах, техник хэрэгслээр хангаж үйл ажиллагааг хэвийн явуулахыг орон нутгийн Засаг дарга нарт чиглэл өгч, хэрэгжүүлэх.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор “Буруу талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хүрдний байрлалыг солих, гэрлийн тусгалыг өөрчлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих замаар буруу талдаа жолооны хүрдтэй автомашины тоог цөөрүүлнэ” хэмээн батлсан стратеги, төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх, үр дүнд хүрэх.

Гэмт хэргийг индекс болон индекс бус гэмт хэрэг гэж 2 ангилан бүртгэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, төсвөө тодорхойлох.

ДХИС-ийн Цагдаагийн сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, алба хаагчдыг үе шаттайгаар давтан мэргэшүүлэх сургалтад хамруулах-зэрэг болно.

Ном зүй

Нэг.Хууль тогтоомж

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. УБ. 2015
- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол
- Авто тээврийн газрын Зам тээврийн хяналт, бүртгэлийн газраас гаргасан үзүүлэлт

- Н.Алтанхуяг. Б.Бүрэнзэвсэг. Автотээврийн үндэсний төвийн техникийн хяналтын судалгаа. УБ. 2019

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага

- С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 2018
- М.Гантулга. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа, шийдвэрлэлт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар зөвлөмж. УБ. 2019

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛИЙН ШИНЭЧЛЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Т.Сосорбарам
Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга

Товч агуулга. Төрийн албан тушаалын оновчтой ангилал, зэрэглэлийн тогтолцоо нь мерит зарчмын хэрэгжилтийг үр дүнтэй байлгах хэрэгсэл бөгөөд төрийн албан тушаалын ангиллыг оновчлох, шинэчлэн боловсруулах нь аливаа улс орны хувьд засгийн газраа шинэчлэх, төрийн албаны бүтцээ оновчлох ингэснээр төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар, ажлын гүйцэтгэл сайжрах, сэтгэлгээ хандлагын өөрчлөлт шинэчлэл хийгдэх үндэс болдог. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага албан тушаалын зөв, системтэй ангилал, зэрэглэлтэй байх нь төрийн албан дахь хүний нөөцийн удирдлагад чухал ач холбогдолтой хэмээн үзэж дэлхийн улс орны судлаачид энэ чиглэлд анхаарал хандуулан судалсаар ирсэн байна.

Энэ талаар доктор, профессор Б.Чимид өөрийн бүтээлдээ “төрийн албан тушаалыг зөв ангилах нь төрийн байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаалын цалин хөлс, шагнал, урамшуулал, хүний нөөцийн төлөвлөлт, албан хаагчийг шилжүүлэх болон сэлгэн ажиллуулах зэрэг төрийн албаны харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах, уялдуулах, хөдөлмөрийн харилцааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах албан хаагчдын харилцан ажиллагааг нарийн тодорхой тогтоох зэрэг практик зорилтыг шийдвэрлэхэд тусалдаг” хэмээн цохон тэмдэглэжээ.[134]

Үүнийг эш болгон төрийн албан хаагчийн болон албан тушаалын ангилал, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэлт, өөрчлөлтийг функциональ болон органик түвшинд харьцуулан судалж, өнөөгийн ангилал, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалт нь оновчтой бус байгаагаас практикт тулгамдаж буй зарим асуудлыг хөндөн гаргах зорилгоор энэхүү өгүүллийг толилуулж байна.

Түлхүүр үг. Төрийн албаны мерит зарчим, тэгш байдал, төрийн албан тушаал, төрийн албан хаагч, албан тушаалын ангилал, албан тушаалын зэрэглэл.

Нэг.Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоож ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл

1.1.Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийн өөрчлөлт, шинэчлэлт

Социалист системийн үед төрийн албан тушаалыг биш төрийн албан хаагчийг ангилж ирсэн бөгөөд *төрийн албан хаагчдыг эрх хэмжээгээр нь* 1)албан тушаалтан[135]; 2)техникийн гүйцэтгэх ажилтан[136]; 3)засаг захиргааны төлөөлөгч[137] гэж

---

[134] Б.Чимид, БНМАУ-ын захиргааны эрх зүй, УБ.,1973, 253 дахь тал

[135] “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад захирамжлах-зохион байгуулах буюу захиргаа, аж ахуйн албан үүргийг байнга буюу түр, эсхүл дээр дурдсан үүргийг мэргэжлийн буюу тусгайлан олгосон эрх хэмжээний дагуу гүйцэтгэж байгаа хүмүүс болон засгийн төлөөлөгчийн албан тушаалтан” БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 135 дугаар зүйл.

[136] Төрийн байгууллагын аппаратын дотоод үйл ажиллагаанд багтсан материал-техникийн чанартай үүрэг биелүүлдэг албан хаагчийг техникийн гүйцэтгэх ажилтан гэнэ. Техникийн гүйцэтгэх ажилтанд даргын нарийн бичгийн дарга, бичиг хэргийн эрхлэгч, бичээч, түргэн бичигч, шифрлэгч, олшруулагч (ротаторчин) архивч, тоо бүртгэгч, мөнгөний нярав, мөнгө хураагч, эдгээртэй адилсах үүрэг биелүүлдэг бусад албан хаагч хамаарна.

[137] Төрийн албан хаагчдын өөр ангилалтад багтах албан тушаалтны зарим хэсгийг (давхардуулан) багтаасан ойлголт болоход оршино. Өргөн хүрээгээр авч үзвэл, албан тушаалын хувьд харьяалан

гурван хэсэгт, *албан тушаалтныг* а)удирдах албан тушаалтан[138]: б)гүйцэтгэх албан тушаалтан[139] гэж хоёр хэсэгт, *техникийн гүйцэтгэх ажилтныг үйл ажиллагааных нь чиглэлээр нь* а)бүртгэл хяналтын; б)бичиг хэргийн; в)аж ахуй үйлчилгээний гэж; *ажиллаж байгаа байгууллагын салбараар нь* 1)төрийн эрх барих болон захиргааны байгууллагын, 2)шүүхийн байгууллагын; 3)прокурорын байгууллагын; 4)ардын хянан шалгах байгууллагын албан хаагч гэж ангилж ирсэн байна.[140]

Улмаар "Төрийн захиргааны байгууллагын боловсон хүчний ажлын зохион байгуулалтын тухай" Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газрын 1991 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 293 дугаар тогтоолоор анх төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг хуульчлан тогтоосон байна. Тус тогтоол нь төрийн захиргааны байгууллагын албан хаагчдыг:

- Улс төрийн зүтгэлтэн;
- Төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан;
- Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх албан тушаалтан;
- Төрийн захиргааны байгууллагын техникийн гүйцэтгэх ажилтан,
- Ажилчид гэж ангилан удирдлагын түвшингээр нь дээд, дунд, доод гэж зэрэглэл тогтоосон байна.

Монгол Улс 1994 онд анхны Төрийн албаны тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу төрийн албан тушаалыг: шинэчлэл,

1/улс төрийн албан тушаал;

2/захиргааны албан тушаал;

3/тусгай албан тушаал;

4/үйлчилгээний албан тушаал гэж ангилах болсон байна.

Үүний дагуу тус хуулийн 7 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт болон 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэл"-ийг тогтоож, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталжээ.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу тус тогтоолоор төрийн захиргааны албан тушаалыг:

1/тэргүүн түшмэл;

2/эрхэлсэн түшмэл;

захирагдахгүй байгууллага, ажилтан иргэдэд буюу "гурав дахь этгээдэд төрийн нэрийн өмнөөс заавал биелүүлэх шаардлага тавих бүрэн эрх бүхий хүмүүсийг засгийн төлөөлөгч гэнэ. Үүнд, бүх шатны АДХ-ын депутат, шүүгч, прокурор, бусад зарим төрлийн ажилтан хамаарагдана.

[138] төрийн дээд албан тушаалтнуудаас гадна яамны сайд, улсын хороо, тусгай газар, орон нутгийн АДХ -ын гүйцэтгэх захиргааны дарга, тэдгээрийн орлогч, газар, хэлтэс, товчоо тасаг, секторын дарга, үйлдвэр, албан дарга, эрхлэгч зэрэг төрийн байгууллага, түүний бүтцийн бие даасан нэгжийг удирдаж байгаа хүмүүс хамаарна. Тэдгээрийн эрх хэмжээ гүйцэтгэх албан тушаалтныхаас өргөн байдаг. Эрх зүйн акт гаргах, хүмүүсийг ажилд авах, өөрчлөх, халах, шагнаж урамшуулах, ажилтнуудын ажил үүргийн хуваарь тогтоох, мөнгөн хөрөнгө зарцуулах, эрх зүйн болон бусад албан бичиг баримтыг гарын үсэг зурж батлах зэрэг эрх эдэлдэг нь удирдах албан тушаалтны үйл ажиллагааны хууль зүйн гол шинж мөн. Түүнчлэн тэдгээр нь харьяа үйлдвэр, албан газрын ажилтныг захирч үйл ажиллагаанд нь шууд оролцож, захирамжилсан заалт өгөх, захирах захирагдах журмаар хариуцлага хүлээлгэх зэрэг бүрэн эрхтэй.

The Union shall also have exclusive competence for the conclusion of an international agreement when its conclusion is provided for in a legislative act of the Union or is necessary to enable the Union to exercise its internal competence, or in so far as its conclusion may affect common rules or alter their scope.[149]

In especially, the European Union treaties are binding agreements between Union member countries. They set out Union objectives, rules for institutions, how decisions are made, and the relationship between the Union and its member countries. Every action taken by the Union is founded on treaties.

According to the list of the Council of Europa's are 225 treaties[150] such as are treaty on the Union, the treaty on the Functioning of the Union, a treaty establishing the Atomic energy community, charter of Fundamental Rights of the Union treaties is currently in force.[151]

"The EU treaty system is embedded in general international law in that secondary norms of international law, for example, rules of interpretation in the law of treaties or the rules of responsibility of states or international organizations, remain applicable where no special rules have been adopted. Traditionally, international obligations of the EU have also arisen from functional succession into the member states' obligations." (Katja, Z. 2016. *The Relationship between EU law and International Law*)

The European Union is a party to innumerable treaties in its areas of competence including mixed agreements where it has shared competence and is thus both norm generator and norm recipient at the international level. In this case, additional obligations arise because of the specific relationship of the Union and its member states regarding member states' international obligations into which the Union may functionally succeed.

The present process is likely to focus on the implementation of Union legislation rather than another international law. This process is progressing rapidly in the field of private international law. e.g.

"EU Directives in the field of private law were of a so-called 'minimum harmonization' standard. This meant that the directive prescribed a basic level of protection, especially for consumers, which had to be met by each national legal system. For that reason, the European Union is seeking concurrently with the International institute for the Unification of private law negotiation some measure of further harmonization amongst its member

[149] Treaty of the Functioning of the European Union. art.3. (2016)
[150] "See details", Council of Europe portal. https://www.coe.int/en/web/conventions/full-list
[151] Treaties Currently in Force, https://eur-lex.europa.eu/collection/eu-law/treaties/treaties-force.html

states." (Hal, B. 2009. *Private International Law.* The International Lawyer. vol. 43. pp.749, 750)

Autonomy of the EU legal order

Montesquieu concluded that the best form of government was one in which the legislative, executive and judicial powers[152] were separate and kept each other in check to prevent any branch from becoming too powerful. Autonomy means not only being legally different from others but also that the mechanisms for creating and enforcing laws are independent and respectful.

While writing this essay, I have seen the specifics of the autonomy of the EU legal order including unified treaties and independence of the judiciary. Currently, the EU has all forms of autonomy, including parliament, the judiciary, and the executive.

The following scholars have expressed a view of the legal independence of the European Union.

"The community of law constructed by the European Court of Justice together with the national courts of the European member states. Beyond the European Union, both national and international courts are attracting increased attention in terms of their actual or potential relationship with one another, either as partners in enforcing international rules or as participants in a larger dynamic process of socialization in the service of compliance." (Mary, S., Andrew, T., & Stepan, W. 1998. *International law and International Relations Theory.* The American Journal of International Law. vol. 92. p.370.391)

"The supremacy of Community law[153] over, and the direct effect of Community law within, the member states' legal orders are now well-established. They are accepted by both the constitutional and the international law accounts of the system and confirmed by and large in practice. It was the unique legal features of its rules, and their normative implications for the member states that became the foundations of the autonomy of the Community, and later the Union, legal system." (Weiler, J., Ulrich, H. 1996. *The Autonomy of the Community Legal Order-through the Looking Glass.* Harvard International Law Journal. vol.37. p.413)

The autonomy of the European Union legal order appears in different contexts the internal and the external referring to control of influence on the European Union emanating either from the member states or the international legal community. It has identified three interconnected concepts of autonomy: normative autonomy, jurisdictional autonomy, and institutional autonomy.

Normative autonomy claims independence towards national law and international law; jurisdictional autonomy exclusive jurisdiction of the Court over the final interpretation of European Union law; and institutional autonomy respect for the allocation of competence between the European Union and its member states. (Xavier, G., Marja, Ö. 2021. *The Web of Autonomy of the EU Legal Order*: Achmea)

Autonomy is used as shorthand for what it is meant to safeguard in relation to the member states: 'the specific characteristics of the Union and Union law'. Such special characteristics would be a synonym for what is traditionally called a 'new legal order of international law' or simply 'new legal order.'

This refers to an internal dimension in relation to the member states, characterized by direct effect and supremacy of European Union law in the legal order of the member states, individual rights, and supranational law-making grounded on a division of competencies between the EU and the member states. Autonomy is also referred to as a principle to protecting the Court of Justice European Union's jurisdiction in relation to other international tribunals. (Katja, Z. 2017. Autonomy: *EU Law, Human Rights and International Law.* University of Leicester. pp.35.39)

---

[152] "See details", https://www.britannica.com/topic/separation-of-powers, Antonio, S. 2017. A History of Law in Europe. Cambridge University Press. p.407

[153] The law of the European Union. It consists of the treaties establishing the EU, Community legislation, and decisions of the European Court of Justice. "See details", Oxford Dictionary of Law (2001). p.95

Besides, EU law also has supremacy over conflicting domestic laws. This can be concluded as the legal nature of the EU law. Treaties and the legal orders adopted by the Union should be model or standard in the legislation of the member states. Also, the EU's judiciary is governing the implementation of a unified legal policy in its member states.

Scholars are examining the relationships between the European Court of Justice and national courts in various European Union member states, analyzing the ways in which those relationships have been critical to the construction of the EU legal system. For example:

"EU law has a 'direct effect' in national jurisdictions." (Geoffrey, G. 1995. *The Politics of Legal Integration in the European Union, International Organization.* vol.49. p.171)

Much Union law is inherently responsive to differences in the member states' legal and administrative systems. (Stine, A. 2012. The Enforcement of EU law: *The Role of the European Commission.* p.36)

General principles of law, derived from the constitutional traditions common to the member states, have served in the case-law of the court as a means of filling gaps and as interpretation aids.[154] EU law affects almost every aspect of national law, thus also some very sensitive areas.[155]

Recently new cases related to this issue have emerged. For example, in a decision that sent shockwaves through Europe, Poland's constitutional court in October 2021 ruled the country's laws had supremacy over those of the European Union. The long-awaited ruling says some parts of EU treaties and court rulings go against Poland's highest law.

In connection with the dispute Polish Prime Minister has accused the EU of blackmail in a heated debate with the European Commission chief over the rule of law. The case, brought by the Polish prime minister, was the first time that an EU member state's leader had questioned EU treaties in a national constitutional court.[156]

After that, the European Commission will not hesitate to make use of its powers under the Treaties to safeguard the uniform application and integrity of Union law," the EU commission statement said. Also, the European Court of Justice ruling obliged the government to ditch the new regulations and observe the independence of justice.[157]

According to the EU legal order, The European Court of Justice has multiple power of interpreting[158] and enforcing laws, annulling legal acts, ensuring the takes action, and sanctioning institutions. Court of Justice deals with requests for preliminary rulings from national courts, certain actions for annulment, and appeals.

General Court rules on actions for annulment brought by individuals, companies, and, in some cases, European Union governments. In practice, this means that this court deals mainly with competition law, state aid, trade, agriculture, trademarks.

The principle of autonomy of EU law is the outcome of judicial creation. There is no reference to it in primary law. Instead, the principle emerged in the early constitutional case-law of the Court of Justice which stressed the fundamentally distinct character of the then-new legal order.

In particular, the concept of the autonomy of the EU legal order has been employed by the court since the 1970s, culminating in post-Lisbon Treaty landmark rulings such as Opinion 1/09, Opinion 2/13, Achmea, and Opinion 1/17. The cases have had tremendous repercussions on the discussion and understanding of the concept of autonomy in the EU

---

[154] Jьrgen, S. (2004) *Enlargement, the European Constitution, and Administrative law.* The International and Comparative Law Quarterly. vol.53

[155] Frischhut, M. (2018) *The Ethical Spirit of EU Law.* p.45

[156] "See details", https://www.bbc.com/news/world-europe "Polish PM accuses the EU of blackmail as row over rule of law escalates"

[157] "See also", https://www.euronews.com/2021/10/08/polexit-will-poland-s-nuclear-strike-on-eu-s-legal-order-lead-to-the-country-quitting-the-

[158] Autonomy concerns the authority to determine the validity and interpretation of EU law as a self-contained and self-referential legal system distinguishable and independent from national and international law. "See details", Christina, E. (2020) The autonomy of EU Legal Order

legal order. (Xavier, G., Marja, Ö. 2021. *The Web of Autonomy of the EU Legal Order*: Achmea)

In Case C-284/16 Achmea[159], the court was asked for the first time directly to rule on the compatibility of intra-EU a Bilateral investment treaty with EU law. These are investment treaties between the member states which were concluded prior to the accession of one of the contracting parties to the EU.

> The case arose from a reference from the Bundesgerichtschof before which an annulment action had been brought against the final award by an arbitral tribunal constituted under the bit between the Netherlands and Czechoslovakia. This case was not about a substantive incompatibility between the intra-EU Bilateral investment treaty in question and European Union law. In fact, no such argument was put forward.
>
> This case raised, instead, a broader constitutional question: does the investor-state dispute settlement mechanism provided for in the agreement and pursuant to which the arbitral tribunal rendered its award violate three of the main tenets of European Union law, namely the principle of non-discrimination, the preliminary reference procedure and the exclusive jurisdiction of the Court of Justice?
>
> In its judgment, the court held that the arbitration procedure laid down in the intra-European Union bilateral investment treaty was contrary both to the preliminary reference procedure and the exclusive jurisdiction of the Court of Justice.
>
> The judgment may appear to suggest that every time an EU law issue pertains to a dispute before an international tribunal, the autonomy of the European Union legal order would be at stake and the Court's exclusive jurisdiction should be triggered.
>
> "The Court also recalled that 'the autonomy of European Union law with respect both to the law of the member states and to international law is justified by the essential characteristics of the EU and its law, relating in particular to the constitutional structure of the European Union and the very nature of that law'." Moreover, the court noted, they were to take for those purposes any appropriate measure to ensure fulfillment of the obligations arising out of the European Union treaties or the acts of the institutions of the European Union." (Panos, K. 2019. *The Autonomy of EU Law and International Investment Arbitration*. Nordic Journal of International Law. pp.50.51)

In order to ascertain whether the investor-state dispute settlement mechanism in the intra-EU bilateral investment treaty ensures consistency with EU law, the question the Court addresses is whether an EU law issue related to the dispute might be brought before an arbitral tribunal. As such, it enables the court to construe the reach of the EU legal order and, more to the point, the scope of its own jurisdiction in similarly broad terms.

According to the court, the specific characteristics and the autonomy of the EU legal order were to be preserved by the judicial system of the European Union, intended to ensure consistency and uniformity in the interpretation of European Union law.[160]

"In other words, by protecting the EU legal order against international rules that threatened the Union's system of human rights protection, the court also protected the EU legal order against recalcitrant domestic courts which might take it upon themselves to protect domestic human rights systems and, therefore, challenge the supremacy of European Union law. Also, International investment law provides both a suitable and topical framework within which to examine the principle of autonomy of the European Union legal order." (Panos, K. 2019. *The Autonomy of EU Law and International Investment Arbitration*. Nordic Journal of International Law. pp.43.48)

---

[159] The Achmea case essentially concerned a preliminary reference by the German Federal Court of Justice over whether EU law precluded the application of an arbitration clause in International investment agreements between EU member states. The investment tribunal considered this a breach of the bilateral investment treaty and awarded Achmea damages of EUR 22.1 million.

[160] "See also", Christina, E. (2020) The autonomy of EU Legal Order

As a result of the Achmea case, in 2020, a total of 23 member states signed a termination agreement of intra-European Union BITs[161]. From this case, it can be seen the affiliation of the court and the protection of the unified principles of the EU legal system. In particular, national courts and tribunals, and the Court, were tasked with ensuring the full application of EU law in all Member States and the judicial protection of the rights of individuals under that law.[162]

"When a legal concept or rule proves to be common to all the member states, the community courts may, without risking opposition in the national legal orders, promote it to a concept or rule of the Community legal order." (Koen, L. 2003. *Interlocking Legal Orders in the European Union and Comparative Law.* The International and Comparative Law Quarterly. vol.57. p.884)

Conclusion

Throughout the historical age, International customary and treaty law has been the key to peacekeeping in the world, ensuring human rights, strengthening the rule of law, and developing humanitarian and economic cooperation. Therefore, any country has always pursued a policy of respecting international law and bringing it into line with domestic law.

Treaties ratified by the European Union have become a platform of international law not only within the member states but also among other partner countries. This is because the EU legal order is having itself the main source of international law.

The European Union's orders in line with common international law manifest the relationship between EU law and International law. On the other hand, the EU is taking steps to ensure the autonomy of its legal order through its own rules and Court of Justice system. This process will determine not only the relationship between EU law and international law but also the future direction of the EU's legal autonomy.

REFERENCES

András, J., Dimitry, K. (2017) *Enforcement of EU law and Values*

Anthea, A., Paul, S. (2018) *Comparative International law*

Athea, R. (2011) *The Role of National Courts in Creating and Enforcing International law.* The International and Comparative Law Quarterly. vol.60

Carrie, A. (2010) *Bilateral Investment Treaties and the EU Legal Order: Implications of the Lisbon Treaty,* Brooklyn Journal of International law. vol.35

Christian, F. (2009) *Key Features of European Union Private Law.* The University of Warwick

Christina, E. (2020) The autonomy of EU Legal Order

Covindaraj, C. (2018) *Private International Law*

Dictionary of law. (2003) Oxford University Press

Elizabeth, R. (2001) *Traditional and Modern Approaches to Customary International Law*. The American Journal of International Law. vol.95

Eva, K. (2017) *The General Court, Völkerrechtsfreundlichkeit and the External Aspect of European Integration*

Frischhut, M. (2018) *The Ethical Spirit of EU Law*

Geoffrey, G. (1995) *The Politics of Legal Integration in the European Union.* International Organization. vol.49

Hal, B. (2009) *Private International Law.* The International Lawyer. vol. 43

Henry, C. (1968) *Blacks' Law dictionary*

James, S. (2017) The legal Nature of International Law, The American Journal of International Law. 1907. vol.1

Jan, K., Anne, P., & Geir, U. (2009) *Constitutionalization of International law*

[161] An agreement between two countries regarding promotion and protection of investments made by investors from respective countries in each other's territory

[162] "See details", Xavier, G., Marja, Ц. (2021) *The Web of Autonomy of the EU Legal Order*: Achmea

Jürgen, S. (2004) *Enlargement, the European Constitution, and Administrative law.* The International and Comparative Law Quarterly. vol.53
Katja, Z. (2016) *The Relationship between EU law and International Law*
Katja, Z. (2017) Autonomy: *EU Law, Human Rights and International Law.* University of Leicester
Koen, L. (2003) *Interlocking Legal Orders in the European Union and Comparative Law.* The International and Comparative Law Quarterly. vol.57
Mary, S., Andrew, T., & Stepan, W. (1998) *International law and International Relations Theory.* The American Journal of International Law. vol. 92
Nicholas, L. (1980) *Recent Trends of International Law.* International Law Studies. vol.61
Oana, H. (2005) Between Power and Principle: *An Integrated Theory of International Law*, The University of Chicago Law Review. vol.72
Panos, K. (2019) *The Autonomy of EU Law and International Investment Arbitration*. Nordic Journal of International Law
Richard, S. (2006) *Power and International Law,* The American Journal of International Law. vol.100
Stine, A. (2012) The Enforcement of EU law: *The Role of the European Commission*
Terence, H., Pavel, O. (2006) Globalization of Law. Annual Review of Sociology. vol.32
Treaty of the Functioning of the European Union. art.3. (2016)
Violeta, L. (2019) Autonomy: *International law and the EU legal order*
Weiler, J., Ulrich, H. (1996) *The Autonomy of the Community Legal Order-through the Looking Glass.* Harvard International Law Journal. vol.37
William, M. (2017) *Treaties Conventions, International Acts, Protocols and Agreements*
Xavier, G., Marja, Ö. (2021) *The Web of Autonomy of the EU Legal Order*: Achmea

СУДЛААЧИЙН БАЙР СУУРЬ

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ СУДАЛГАА

А.Мөнхцэцэг Магистр
Ц.Түвшинбаяр Магистрант

Товч агуулга. Монгол Улсын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулийн эрх зүйн зохицуулалтыг гадаадын зарим орны эрх зүй дэх онцлогтой харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсэн.

Түлхүүр үг. Нутгийн удирдлага, сонгууль, сонгуулийн тогтолцоо, эрх зүй.

Удиртгал

Нутгийн өөрөө удирдах ёс нь өөрийн хариуцлага, өөрийн эрх мэдэл бүхий нутаг дэвсгэрийн бие даасан байдлыг хангаж, тухайн харьяаллын нутаг дэвсгэрт орон нутгийн иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн хуулийн асуудлыг шийдвэрлэх, нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх, бүрэн эрх, чадвар мөн гэж тодорхойлжээ.

Өөрөө удирдах ёсны байгуллагын сонгуулийн тогтолцооны харьцангуй бие даасан байдлыг тогтоон хангах замаар Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг тодорхой цаг хугацаанд батлан гаргаж хэрэгжүүлснээр, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нам төрөөс хэт хамааралтай захирагдмал байдал, түүний хязгаарлагдмал орчин нөхцөл багасч нутгийн эрх барих удирдах, гүйцэтгэх эрх мэдлийн зааг ялгаа тодорч эрх зүйн зарцуулалтын шинэ институт бүрэлдэж эхэлсэн.

Сонгууль нь нэг талаасаа төрийн тэргүүн, парламент, орно нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хуульд заасан журмаар байгуулах ардчилсан арга хэрэгсэл, нөгөө талаас иргэд төрийн удирдах хэрэгт шууд оролцож байгаа ардчиллын нэг хэлбэр болдог.

Баримт 1.

2008 оны сонгуулийн үр дүнд аймгийн ИТХ-ын нийт төлөөлөгчийн 59.8 хувь нь МАН, 39.4 хувь нь АН, 0.8 хувь нь бие даан нэр дэвшигч, нийслэлийн ИТХ-ын 80 хувь нь МАН, 20 хувь нь АН байсан. 2012 оны сонгуулийн үр дүнд аймгийн ИТХ-ын 44.8 хувь нь АН, 50.9 хувь нь МАН, 2.7 хувь нь Шударга ёс эвсэл, 0.7 хувь нь бие даан нэр дэвшигч, нийслэлийн ИТХ-ын 45 суудлын 26-г АН, 14-г МАН, 4-г нь МАХН, 1-г нь ИЗНН авсан. 2016 оны сонгуулийн үр дүнд аймаг, нийслэлийн ИТХ-ын 29,1 хувь нь АН, 64.6 хувь нь МАН, 2.6 хувь нь МАХН авсан тоон үзүүлэлтэй байна.

Үүнээс үзэхэд, Монгол Улс орон нутгийн хурлын сонгуулийг 1992 оноос хойш нийт 8 удаа явуулж, 1992 онд шууд бусаар, бусад онд шууд, 1996, 2012 онд сунгуулийг мажоритар, пропорциональ тогтолцоог хослуулж, бусад оны сонгуулийг мажоритар тогтолцоогоор явуулснаараа онцлогтой юм. Манай улсад нийт 35 нам, эвсэл Улсын дээд шүүхэд бүртгэгдсэн. Үүнээс Монгол ардын нам, Ардчилсан намууд төрийн эрх барьж барьж байсан.

Үндсэн хэсэг

Иргэншиж тогтсон нийгэмд нутгийн өөрөө удирдах ёс нь ардчиллын үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хангаж буй хэмжүүр, эрх зүйт төрийн нэг чухал шинж юм[163]. Олон улсын баримт бичгүүдэд Өөрөө удирдах ёсны талаар тодорхойлохдоо "*Тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид ардчилсан, тэгш, шууд*

[163] Эрдэнэцогт. А"Нутгийн өөрөө удирдах ёсны Олон Улсын хөгжлийн чиг хандлага", "Эрх зүй" сэтгүүл УБ., 2003. № 10-11, х.71 дэх тал

сонгуулийн үндсэн дээр өөрсдийн төлөөлилийн байгууллага бүрдүүлнэ” гэсэн агуулгыг тусгасан.[164]

Баримт 2

Торонто хотноо 1993 онд Хуралдсан нутаг дэвсгэрийн нэгжийн Олон Улсын холбооны 31-р хурлаас “Нутгийн өөрөө удирдах ёсны Олон улсын тунхаг” бичиг болон Нутгийн удирдлагын тухай 1985 оны Европын Хартид ардчилсан улсууд нийтээр хүлээн зөвшөөрсөн нутгийн өөрөө удирдах ёсны талаар нийтлэг байдлаар тодорхойлсон.

Өөрөөр хэлбэл, тухайн нутгийн иргэд, эсвэл тэднээс ардчилсан, чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлэх ба үйл ажиллагаандаа ардчиллын үнэт зүйлсийг мөрдлөг болгоно.

Өөрөө удирдах ёс нь нутаг дэвсгэрийн нэгжийн хүн ам, суурин газрын оршин суугчдын ба олон нийтийн байгууллагын гишүүд гэх мэтчлэн хүмүүсийн нэгдлийн дотоод зохион байгуулалт бөгөөд үндсэн утга учир нь иргэд хамтарч ерөнхий хэрэг явдлаа удирдан хөтлөх, амин чухал асуудлаа шийдвэрлэхэд оршино.[165]

Харин ***нутгийн өөрөө удирдах ёсны*** гол хууль зүйн онцлог бол тухайн нэгжийн амьдралын үндсэн асуудлыг тэр нэгжийн иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлаж шийдвэрлэгдэг явдал мөн.[166]

1985 оны 10 дугаар сарын 15-нд баталсан Европын Улсуудын нутгийн удирдлагын тухай Хартийн 3 дугаар зүйлд “Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагаас өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийн тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлага хэрэгжүүлэх эрх бодит чадвар” гэж тодорхойлсон.[167]

Баримт 3

“Бие даасан хандлага” гэж Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрийн нийт иргэн буюу нутаг дэвсгэрийн хамт олныг хэлнэ. “Ашиг сонирхол” гэж ерөөс алив хүн, хамтлагийн бие даан орших, өөрийгөө хамгаалах, эсэргүүцэх зэрэгээр хариу үйлдэл ухамсарласан мэдрэмж бөгөө Нутгийн хамтлаг бие даан хөгжих хууль ёсны эрхээ хамгаалах, түүнийг нь зөрчвөл эсэргүүцэн няцаахад тэр ашиг сонирхол нь илэрнэ.

Өөрөөр хэлбэл, “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага” гэдэг нь нутаг дэвсгэрийн нэгжийн хүн амын өөрсдийнх нь буюу нутаг дэвсгэрийн хамтлаг, *түүний үйл ажиллагааг удирдлага* сонгуульт байгууллагын нийгэм, эдийг засаг, төрийн байгууллагуудын тодорхой салбаруудын үйл ажиллагааны цогцолбор гэж үзэж болно.[168]

Торонто хотноо 1993 онд Хуралдсан нутаг дэвсгэрийн нэгжийн Олон Улсын холбооны 31 дүгээр бага хурлаас “Нутгийн өөрөө удирдах ёсны Олон улсын тунхаг” бичиг болон Нутгийн удирдлагын тухай Европын Хартид ардчилсан улсууд нийтээр хүлээн зөвшөөрсөн нутгийн өөрөө удирдах ёсны талаар нийтлэг байдлаар тодорхойлсон. Тус баримт бичгүүдэд Өөрөө удирдах ёсны талаар тодорхойлохдоо “Тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид ардчилсан, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр өөрсдийн төлөөллийн байгууллагаа бүрдүүлнэ” гэсэн агуулгыг тусгасан.[169]

---

[164] Дондог.Д, Тунгалаг.О “Нутгийн удирдлага- Эрх зүйн шинэчлэл” УБ., 2007, 3 дахь тал
[165] Солонго.Д “Төрийн эрх зүйн тайлбар толь” УБ., 2003., 76 дахь тал
[166] Удирдлагын академи “Сумын судалгаа:онол арга зүйн асуудал” УБ., 2004, 46 дахь тал
[167] Чимид.Б ”Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008, 366-367 дахь тал
[168] Дондог.Д, Тунгалаг.О “Нутгийн удирдлага-Эрх зүйн шинэчлэл” УБ., 2007, 4 дахь тал
[169] Мөн тэнд, 3 дахь тал

Иймээс тухайн нутаг дэвсгэрт харьяалагдах Монгол улсын иргэн бүр Аймаг, нийслэл, сум, дүүрэгтээ хэнийг сонгох, хэнийг эс сонгох, хэнээр засаг захиргаагаа удирдуулах наад захын эрхээр хангагдах ёстой.[170] Энэ нь дээр дурдсан эрхийг хангаж байхаар оновчтой, нэг ёсондоо нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчдийн сонгох сонгууль үнэн зөв томъёологдсон байх ёстой бөгөөд тэгш эрхийн үндсэн дээр явагдах ёстойг харуулсан.

Өөрөөр хэлбэл, тухайн нутгийн иргэд, эсвэл тэднээс ардчилсан, чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлэх ба үйл ажиллагаандаа ардчиллын үнэт зүйлсийг мөрдлөг болгохыг тунхагласан.[171]

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулийн тогтолцоо:

Монгол Улсын Үндсэн хуулиар манай улсын иргэдийн сонгох, сонгогдох эрх, түүний баталгааг заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9-д "Монгол Улсын иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдсон насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзах хуулиар тогтооно" гэжээ.[172]

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага /Иргэдийн төлөөлөлгчдийн хурал/ нь сонгуульт байгууллага юм. Түүнийг тухайн нэгжийн сонгуулийн эрх бүхий иргэд нийт, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно.[173]

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр хурлынхаа харьяа нутаг дэвсгэрт байнга оршин суудаг (хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийг байнга оршин суугаа), сонгох, сонгогдох эрх бүхий Монгол Улсын иргэнийг сонгож болно. Энэ ерөнхий шаардлагаас гадна ялгүй (ял шийтгэгдсэнд тооцохгүй), "зээлийн өргүй" байх зэрэг тусгай шаардлага бий.[174]

Нутгийн өөрөө удирдах ёсны байгуулагын сонгуулийг мажоритор, пропорциональ тогтолцооны аль нэгээр эсвэл холимог гэсэн тогтолцоогоор явуулдаг. Сонгуулийн холимог тогтолцоо гэдэг нь **мажоритар буюу олонхи дийлэнхи, пропорциональ буюу хувь тэнцүүлэн сонгох тогтолцоог хослуулсан аргыг хэлдэг.**

Ардчилсан тогтолцооны үед Орон нутгийн сонгуулийг 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016 онд явуулжээ. 1992 онд шууд бусаар сонгууль явуулсан. 1996, 2012 онд сонгуулийг мажоритор, пропорциональ тогтолцоог хослуулж, бусад оны сонгуулийг мажоритар тогтолцоогоор явуулсан.

Гадаадын зарим улсын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулийн онцлог:

Манай улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, парламентын засаглалтай улс. Иймээс төрийн байгууламжийн хэлбэрийн хувьд нэгдмэл, мөн эрх зүйн тогтолцооны хувьд Эх газрын эрх зүйн тогтолцоотой улстай нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн тогтолцоог харьцуулан авч судлах нь чухал юм. Орон нутгийн сонгуульд дэвшүүлэх ажиллагааг Япон, Унгар, Бангладеш, Польш, Болгар, Чех, БНСУ зэрэг улсуудад бие даан нэр дэвшүүлэх, улс төрийн намуудаас нэр дэвшүүлэх болон тодорхой тооны сонгогчдоос нэр дэвшүүлэх зарчмаар явуулж байна. Япон улс тухайн улс төрийн намд нэр дэвшүүлэх хүний тоон хязгаарыг тогтоож өгдөг бол Унгар улсад тухайн орон нутагт байгын оршин суугчийн нэрийг дэвшүүлэх түүнчлэн ТББ нэр дэвшүүлэх эрхтэй байдаг нь заавал намаас нэр дэвших явдлыг хязгаарлаж байгаа хэлбэр юм.

---

[170] Цогтоо.Ш "Засаг захиргаа-онол арга зүйн асуудал" УБ., 2007,192 дахь тал
[171] "Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр" сэдэвт бага хурлын баримт материалын эмхтгэл, УБ., 2004, 192 дахь тал
[172] Лүндээжанцан.Д, Энхбаатар.Ч "Монгол Улсын үндсэн хуулийн эрх зүй" УБ., 200. 229 дэх тал
[173] Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг УБ., 2008. 369 дэх тал
[174] Мөн тэнд. 370 дахь тал

Зарим нэг улсын онцлог зохицуулалтыг дурдвал:

- Япон улсад тухайн улс төрийн намд нэр дэвшүүлэх хүний тоон хязгаарыг тогтоож өгдөг.
- Унгар улсад тухайн орон нутагт байнгын оршин суугчийн нэрийг дэвшүүлэх түүнчлэн ТББ нэр дэвшүүлэх эрхтэй.
- БНСУ-д бие даан нэр дэвшигч нь хичнээн хүний гарын үсэг авах болон мөнгөний барьцааг хуульд тодорхой заасан байдаг.
- Казакстан улсад тухайн тойргийн сонгуульд өргөдөл гаргаж нэр дэвших, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах зэрэг асуудлыг Орон нутгийн сонгуулийн тухай хуулинд зааж өгчээ.

Австри, Австрали, АНУ, БНСУ, Дани, Ирланд, Испани, Их Британи, Казакстан, Канад, Мексик, Молдов, Нидерланд, ОХУ, Польш, Словен-ХБНГУ, Унгар, Франц, Чили, Швед, Швейцар, Эстони, Япон зэрэг улсуудын орон нутгийн сонгуулийн тогтолцоонд улс төрийн намууд хэрхэн оролцох оролцоо, орон нутгийн хурлын үйл ажиллагаанд нэр дэвших эрх, улс төрийн намаас нэр дэвшүүлэх эрх зэрэг асуудлыг харьцуулан үзүүлэв[175]



Тухайлбал, **Канад** улсад нэр дэвшүүлэх баримт бичигт зөвхөн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй хоёр сонгогчийн гарын үсэг байхад хангалттай байдаг бол, **Австрали** улсад нэр дэвшүүлэх өргөдөлд сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй арван сонгогч гарын үсэг зурсан байх хэрэгтэй бөгөөд эдгээрийн нэг нь нэр дэвшүүлэгч, нэг нь нэр дэвшүүлэгчийн саналыг дэмжигч, үлдсэн найм нь нэр дэвшигчийг дэмжихийг зөвшөөрсөн мөн жагсаалтад бүртгэлтэй сонгогч байна. **АНУ-д** улс төрийн намууд нэр дэвшүүлэхийн тулд тодорхой тооноос доошгүй бүртгэгдсэн сонгогчдын гарын үсэг зурж цуглуулсан байх хэрэгтэй (Иллинойст – 25 мянга, Нью-Йоркт – 20 мянга, Охайо, Алабамад – 5 мянга г.м.). Гэхдээ АНУ-д ихэнх орон нутгийн сонгууль улс төрийн намуудын оролцоогүй явагддаг. **ХБНГУ-д** Бундестагт суудалгүй боловч аль нэг муж улсын Ландтагт сүүлийн сонгуулиар таваас доошгүй суудал авсан улс төрийн нам сонгуулийн компанид оролцох хүсэлтээ сонгуулийн зохион байгуулагчид мэдэгдэж, үүнийг нь үндэслэн Холбооны сонгуулийн хороо уг байгууллагыг улс төрийн намын шинжтэй гэж үзсэн тохиолдолд тус нам сонгуульд нэр дэвшүүлдэг. Үүнээс гадна парламентад суудалгүй нам өөрийн нэр дэвшигчээ нэр дэвшүүлж буй тойрог бүрт 200-аас доошгүй, нэр дэвшигчдийн жагсаалтаа дэвшүүлж буй муж улс бүрт 1000-аас доошгүй сонгогчдын гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг. **БНПУ**-д хуучин социалист орнуудын хүрээнд хэт

[175] "Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намын оролцоо, үүрэг, нөлөө, гишүүдийн орон-нутгийн хуралд нэр дэвших эрх (СТ-12/202, харьцуулсан судалгаа).

төвлөрлөөс ангид орон нутгийн бие даасан хараат бус байх зарчмыг шинэ Польшийн 1997 оны Үндсэн хуулийн VII хэсэгт зохицуулсан байна.[176] Польш улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Бүгд найрамдах Польш улс бол нэгдмэл улс мөн" гэж заажээ. Польш Улсын Үндсэн хуулийн[177] 169 дүгээр зүйлийн 169.1 дэх хэсэгт "Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгжүүд өөрийн зорилтыг шийдвэр гаргагч, гүйцэтгэгч байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлнэ". Үүнээс 169.2 дэх хэсэгт "Шийдвэр гаргагч байгууллагын сонгуулийг нийтээрээ, шууд, тэгш эрхтэй нууцаар санал хурааж явуулна. Нэр дэвшигчид нэрээ дэвшүүлэх, сонгууль явуулах зарчим, журам болон сонгууль хүчинтэй байх нөхцлийг хуулиар тодорхойлсон. БНПУ-ын Сонгуулийн тухай[178] төрөлжсөн хуулийн (2011 он) 7 дугаар бүлэгт Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн эрх зүйн харилцааг зохицуулсан.[179] Тухайн хуулийн 6.2-т *Орон нутгийн өөрөө удирдах байгууллага гэдэг"* нь Өөрөө удирдах зөвлөл (засаг захиргааны анхан шатны нэгж), Орон нутгийн зөвлөл, Бүсийн зөвлөл зэргээс бүрдэнэ. Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн нутаг дэвсгэрийн харьяалалтай байна. Тухайн хуулийн 489.2-т "Хотын захирагч болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгохдоо хуулийн дагуу дийлэнхи олонхиор /мажоритор/ нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно. "Польш улсад нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчдийг сонгохдоо сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэглэдэг.

Словени Улсын нутгийн удирдлагын эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хууль, Орон нутгийн сонгуулийн тухай хууль зэрэг холбогдох бусад хууль тогтоомжоор (*Сонгуулийн хууль болон Улс төрийн намын тухай хууль гэх мэт 10 орчим*) зохицуулагддаг байна.

Орон нутгийн сонгуулийг Орон нутгийн сонгуулийн тухай хууль болон Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулиар зохицуулна. Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар " Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал" , засаг дарга , бүсийн зөвлөл болон хотын зөвлөлүүд , тосгон болон дүүргийн коммуныг сонгох харилцааг зохицуулна. Орон нутгийн зөвлөлийн сонгууль нь 4 жил тутамд явагдах ба шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө зарлан явуулж болно. Орон нутгийн сонгуулийг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч , харин хуулийн хугацаанаас өмнө явуулах дахин болон нөхөн сонгуулийг хотын захирагч зарлана.

Тухайн орон нутагт оршин суугч Словени Улсын насанд хүрсэн бүх иргэн сонгуульд саналаа өгөх эрхтэй. Орон нутгийн сонгуулийн хуулийн дагуу 12-с доош гишүүн бүхий "аймаг , нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал" –ыг Төлөөлөгчдийн хурал гэх мажоритар системээр , харин 12-с дээш гишүүн бүхий Төлөөлөгчдийн хуралд пропорциональ системээр сонгууль явагдана. Түүнчлэн иргэд нь бие даан нэр дэвшигчдийг жагсаалтаас сонгох тохиолдолд пропроциональ системээр сонгуулийг явуулдаг.

---

[176] "Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр" сэдэвт бага баримт материалын эмхэтгэл, УБ, 2004, 167 дахь тал

[177] Бүгд найрамдах Польш Улсын Үндсэн хууль., Польш хэлнээс орчуулсан: Б.Лхагважав, Ж.Алтангэрэл

[178] http://www.legislationline.org, Election Code Of Poland, орчуулав.

[179] 7-р бүлэг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль. 369-3469-р зүйлүүдэд дараах харилцаануудыг зохицуулсан байна. Сонгуулийн Ерөнхий зарчмууд, Ошин байгаа газрын шилжих хөдөлгөөний асуудал, Сонгуулийн дүнг зарлах тухай, Нэр дэвшигчдэд мандат олгох, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлттэй холбоотой асуудлууд, Сонгууль хүчин төгөлдөр болох тухай, Нэр дэвшигчдийг зарлах зэрэг асуудлуудыг зохицуулсан байна.

Хүснэгт. Доорх улс орнуудын орон нутгийн сонгуулийн онцлогийг хүснэгтээр авч үзэхэд:

Улс	Сонгуулийн эрх зүйн үндэс	Сонгуулийн тогтолцоо	Нэр дэвшүүлэлт	Онцлог зохицуулалт
Бүгд найрамдах польш	Үндсэн хууль болон сонгуулийн төрөлжсөн хууль	мажоритар	Нам , бие дааж	НӨЕБ нь Өөрөө удирдах зөвлөл, Орон нутгийн зөвлөл, Бүсийн зөвлөлөөс бүрдэнэ.
Словени	Үндсэн хууль, орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хууль , Орон нутгийн сонгуулийн тухай хууль	12-оос доош гишүүн бүхий Төлөөлөгчдийн хурал-ыг мажоритар системээр, 12-оос дээш бол Пропроционал системээр	Аймаг , нийслэлд улс төрийн нам , сонгуулийн нэгжид сонгогчид	Сонсогчид нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж болно. Нэг сонгогчийн групп нь зөвхөн нэг жагсаалт гаргах эрхтэй.
БНСУ	Нутгийн өөрөө удирдлагын эрх зүйн акт	Холимог 90%-ийн мажоритар 10%-ийг хувь тэнцүүлсэн зарчмаар	Нам эвслээс , бие дааж	Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэхдээ 2-50 сая воны барьцааны мөнгийг авдаг.

Дүгнэлт

Манай улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж, шинэ Үндсэн хууль батлагдсанаар нутгийн удирдлагын тогтолцоог өөрчлөн байгуулах эрх зүйн орчин бүрдсэн юм. Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал нь манай улсын төвлөрсөн удирдлагаас ангижрах гол нөхцөлийг бүрдүүлж өгснөөр орон нутгийн удирдлагын тогтолцоо шинэчлэгдэж ардчилсан нийгэмд иргэн бүр өөрийн амьдарч буй орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэхэд шууд оролцох, мөн төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийн эрх барих, шийдвэр гаргах түвшинд шударга, эрх тэгш чөлөөтэй оролцох эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн.

Монгол Улсын Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулийн тогтолцоо, гадаадын зарим орны Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулийн тогтолцоог судалж, цаашид орон нутгийн сонгуульд улс төрийн нам оролцдог нөлөөллийг багасгаж, иргэдийн төлөөллийн байгууллага гэдэг утгаараа иргэн, хүсвэл иргэд улс төрийн намгүйгээр эвлэлдэн нэгдэж жагсаалт бүрдүүлэн оролцдог тогтолцоог бий болгох нь ач холбогдолтой юм.

Манай улсын хувьд орон нутгийн сонгуульд зөвхөн нам зонхилох үүрэгтэй оролцдог байдлыг багасгах, иргэд болон ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх шаардалагатай гэж үзэж байна.

Санал

1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулийн тогтолцоо, журамд иргэд, олон нийт улс төрийн намын харъяалалгүйгээр нэр дэвших боломжийг нэмэгдүүлэх замаар улс төрийн намуудын орон нутгийн сонгуульд оролцох оролцоог багасгаж, нутгийн өөрийн удирдах ёсны байгууллага дахь намын төлөөллийг бууруулах. Тухайлбал, бие даан нэр дэвшигч УИХ-ын гишүүнд нэр дэвшигчтэй адил тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг цуглуулдгийг цөөрүүлэх. Мөн нэр дэвших нас 25-аас дээш буюу УИХ-д нэр дэвшигчтэй адил байгааг хөдөөд орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан насны хязгаарыг багасгах;
2. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуульд иргэд, сонгогчид, ТББ-ууд улс төрийн намын харьяалалгүйгээр жагсаалт үүсгэн нэр дэвшдэг холимог тогтолцоог аль болох хэрэглэх, ингэхдээ параллель хувилбарыг сонгох, босгыг 5%-иар тогтоох;
3. Сонгуулийн мажоритар тогтолцоо нь сонгох сонгогдох эрхэд харьцангуй сөрөг нөлөөлөл бий болгон Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад иргэдийг төлөөлөх, сонгогчдын саналын тусгал байх зарчмыг алдагдуулаг тул тус тогтолцоог дангаар хэрэглэхээс татгалзах;
4. Орон нутгийн сонгуулийн тухай хуульд байнга өөрчлөлт орж сонгуулийн тогтолцоо, журам 4 жил болоод солигддог практикийг халж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгууль тойрсон асуудлыг нэг мөр маргаангүй болгох-зэрэг болно.

ГЭР БҮЛИЙН НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙ ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ: ОНОЛ, ПРАКТИК

Д.Батчимэг
ДХИС-ийн магистрант, “Токмастер” ХХК-ны захирал

Товч агуулга. Энэхүү өгүүлэл нь гэр бүлийн насанд хүрээгүй хүний эд хөрөнгийн эрх, тэдэнтэй холбоотой эрх зүйн тогтолцоо ард иргэдийн дунд дутмаг байгаатай холбоотойгоор дэлгэрүүлэн мэдлэг олгохыг хичээлээ.Тэдгээрийн дундаас хүүхдийн эрх тэр тусмаа насанд хүрээгүй хүний эд хөрөнгийн эрх, дундын өмчийн харилцаанд хүүхдийн өмчийг хэрхэн хамгаалах, хүүхдэд зориулан гаргасан хуулиар олгогдсон зарим нэг эрхийг мэдэхгүй байгаа нь судалгаа хийх гол шалтгаан боллоо. Энэ нь гэр бүлийн насанд хүрээгүй хүн буюу хүүхдэд ч бас гэр бүлийн хөрөнгөнөөс өөрийн гэсэн тодорхой хувийн өмчлөх эрх байдаг ч гэр бүл салалт болох хүртэл энэ эрх огтхон ч дурддаггүйд эмзэглэн судалгаагаа энэ эрхэд чиглүүлэн нийгэмд далайцтайгаар хүргэхийг зорьж байна.

Түлхүүр үг. Гэрлэлт, гэр бүл, насанд хүрээгүй хүн, дундын өмч.

Өнөөгийн нийгэмд хүүхдийн эрх ихээр зөрчигдөж хүүхэд хамгааллын системийн гажуудал үүссэнээс Монгол Улс хүүхдэд ээлгүй орчныг бүрдүүлж хүүхдийн эрх зөрчигддөг хатуу нийгэм цогцлоогоод байна. Бид хүүхдийн эрхийн талаар маш олон чиглэлээр мэддэг боловч эцэг эхчүүдийн түгээмэл мэддэггүй, зайлшгүй мэддэг байх нэгэн эрхийг хөндөх юм. Энэ нь гэр бүлийн насанд хүрээгүй хүний эд хөрөнгийн эрх буюу өмчлөх эрхийн мөн чанар нь хүүхдийн өмчлөх эрхийг хянан шийдвэрлэх, шүүн таслах ажиллагааны явцад нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийн бат бэх байдлыг хангах, хүүхдийн эрх, гэрлэгчдийн бодит болон бодит бус хөрөнгө, хувь хүний эрх чөлөөг хамгаалах гэх мэт үндсэн зорилго агуулсан байдаг.

Нэг.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмчийн харилцаанд насанд хүрээгүй хүний өмчлөх эрхийн үндэс

1.1.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмчийн харилцаанд насанд хүрээгүй хүний өмчлөх эрхийн ойлголт мөн чанар

Иргэний хуулийн 126 дугаар зүйлд заасан хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөд хамаарна. Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж захиран зарцуулна. Гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн гишүүдийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна. Хуульд өөрөөр заагаагүй бол уг зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна. Гэрлэснээс хойш гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгөө дур мэдэн бусдад шилжүүлсэн, олсон ашиг, орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй. Гэрлэгчид эд хөрөнгийн харилцааг гэрээгээр зохицуулах: Энэ нь гэр бүлийн хөрөнгө болон тэжээн тэтгэх харилцааны зохицуулалтад нэгэн адил хамаарна.

Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.2[180]-т гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчид хамаарах хөрөнгийг заасан. Эдгээрт:

- Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн болон тэдгээрийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон болон бусад орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө;
- Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө;

[180] ГТХАН, ХЗҮТөв (Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар) ерөнхий анги 439 дэх тал

- Ногдол хувь, үнэт цаас;
- Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө;
- Гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал тус тус хамаардаг.

Иргэний хуулийн 126.3-т зааснаар гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгийг гэр бүлийн бусад гишүүд их засвар хийсэн, шинэчилсэн, өөрчлөн тоноглосны улмаас үнэ нь үлэмж нэмэгдсэн, эсхүл анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашаа, байшин зэрэг/ бол хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болгон тогтоож болдог байна. Мөн зүйлийн 126.4.-т зааснаар гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ. Гэрлэгчид нь дээрх зохицуулалтын дагуу хөрөнгийг дундын өмчлөлийнх мөн болохыг тогтоолгохоор бие биендээ шаардлага гаргах эрхтэйгээс гадна энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1[181]-д заасан 4 үндэслэлээр гэр бүлийн дундын өмчлөлийн эд хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хэсгийг тогтооход гэр бүлийн нийт гишүүдэд адил тэнцүү хуваж тооцох шаардлагатай бол Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3-т заасан үндэслэлээр буюу гэрлэлт цуцлах үед гэрлэгчдэд ногдох хэсгийг тэдгээрийн хооронд адил тэнцүү хуваж тооцох бөгөөд харин хэн алины эрүүл мэндийн болон хүүхэд хэнтэй нь амьдрах байдлыг шүүх харгалзан үзэж, аль нэг талд илүү хэмжээгээр ногдох хувийг тогтоож болох байна.

Харин гэрлэлтээ цуцлуулж буй гэрлэгчдийн хүүхэд эцэг, эхийнхээ хөрөнгөөс тэдгээрийн адил тэнцүү хуваж авах эрхгүй бөгөөд шүүх тухайн маргааныг хянан шийдвэрлэхэд хүүхдийн эрх ашгийг харгалзан үзэх л үүрэгтэй болохоос бус гэрлэгчдийн эд хөрөнгийг хүүхдүүдэд нь тэнцүү хуваадаг нь эрх зүйн хувьд алдаатай болно.

Хүүхэд тодорхой эд хөрөнгийн хамтран өмчлөгч мөн тохиолдолд гэрлэгчдэд ногдох хувийг тогтооход тооцоо өөрөөр хийгдэх боломжтой боловч шүүх тухайн эд хөрөнгийг бүхэлд нь хамтран өмчлөх хүүхдийн эрхийг эцэг, эхийнх нь гэрлэлтийг цуцалснаар үгүйсгэж болохгүй юм. Эцэг, эхийн гэрлэлтийг цуцлах үед шүүх хүүхдэд ногдох хэсгийг түүнтэй цаашид амьдрах талд гаргуулснаар хүүхдийн эрхийг хамгаалж, харгалзан үзэж байгаа гэж харагдах боловч хүүхдийн эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдаж буй эсэхийг анхаарах учиртай.

Харин хүүхдийн эзэмшил, ашиглалтад тухайлан олгогдсон эд хөрөнгө \хувийн хэрэглээний зүйл, тавилга, утас, компьютер зэрэг\ эд хөрөнгийг гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хуваах, энэ хөрөнгөөс өөрт ногдох хэсгийг гаргуулах үндэслэлгүй болно. Энэ эд хөрөнгө хүүхдийн ханаа амьдрахаас шалтгаалан гэрлэгчдийн аль нэгний эзэмшилд очих боловч уг эд хөрөнгө гэрлэгчдийн бусад эд хөрөнгийг хуваах тооцоонд орохгүй юм.

1.2.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмчийн харилцаанд насанд хүрээгүй хүний өмчлөх эрхийг хамгаалж байсан хууль цаазын уламжлал

1926 оны Монгол Улсын Иргэний хуульд “эр эм хоёр аливаа хогшлын тухай завсар дор хууль ёсны гэрээ хэлэлцээр байгуулж болмой” гэсэн заалт байх бөгөөд амьдралд тэр бүр байгуулагдаж байсан эсэх нь эргэлзээтэй юм. Энэхүү заалтыг “дээрх зүйлүүд ёсоор байгуулсан гэрээ хэлэлцээний дотор хоёр этгээдийн хэн нь ч атугай хөрөнгө хогшлыг эзэрхэн эдлэх тухай эрхийг үндсээр нь хасагдуулан муудуулах зэрэг зүйл байх ахул түүнийг байгуулсан эр эм хоёр бус бусад этгээдээс тэдгээрийн ашиг тусыг хамгаалахын тулд уг байгуулсан гэрээг устгуулахыг хүсэж зохих шүүх таслах газраа мэдүүлж болмой” хэмээн тайлбарласан байна. Үүнээс

[181] Монгол Улсын Иргэний хууль УБ. 2002 он

үзэхэд гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдон үүсэх харилцаагаа гэрээний үндсэн дээр харилцан тохиролцон шийдвэрлэх боломжийг 1926 оны Иргэний хуулиар олгосон байжээ.

БНМАУ-ын 1973 оны Гэр бүлийн хууль нь социалист нийгмийн тогтолцооны үед хэрэгжиж байсан нийгэм-журмын үзэл баримтлал бүхий хууль хэдий ч уг хуулийн 16 дугаар зүйлд "тус бүрийн хуваарьт эд хөрөнгөө бүхэлд нь эсхүл хэсгийг хамтран өмчлөх дундын өмчид нийлүүлэхээр гэрлэгсэд харин тохиролцох эрхтэй" хэмээн хуульчилж өгсөн байна. Уг хуулийн заалтыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар Х.Дамдин нарын эрдэмтэд БНМАУ-ын гэр бүлийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар хэмээх бүтээлдээ "гэрлэгсэд тус бүрийнхээ хуваарьт өмчийг өөрсдийн сайн дураараа хамтран өмчлөх дундын өмчид нийлүүлэхээр харилцан тохирвол тэр нь дундын өмч болж хувирна. Гэрлэгсдийн өмчийн нэг хэлбэрээс нөгөөд шилжин шинэ эрх үүрэг, үр дагавар бий болгож байгаагаас үндэслэж маргаан шийдэж байгаа шүүх хурал дээр биечлэн хэлэлцэж тохиролцсоноос бусад тохиолдолд ийм хэлбэрийг бичгээр үйлдэж нотариатын баталгаатай байхыг шаардах үндэстэй юм" хэмээн тайлбарлан бичжээ.

Дээрхэд үндэслэн 1973 оны Гэр бүлийн хуулийн зохицуулалт нь гэрлэгчдэд хөрөнгийн эрхтэй холбоотой харилцаагаа гэрээ байгуулах замаар харилцан тохиролцох боломжийг олгосон байх ба уг тохиролцоо нь гагцхүү хуваарьт эд хөрөнгийг хамтран өмчлөх дундын өмчид нийлүүлэх тохиолдолд байгуулагдахаар хуульчилж өгсөн нь гэрлэгчдийн хөрөнгийн эрхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа мэт боловч тухайн үеийн нийгмийн тогтолцооны онцлогийг илэрхийлсэн хэлбэр төдий байсан.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд "Гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байх, гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ" гэж зааснаар нэг талаас иргэний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах үндэс суурь тавигдсан төдийгүй нөгөө талаас гэр бүлийн харилцааны зохицуулалтад төрөөс оролцох оролцоог аль болох багасгах, гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулах хэм хэмжээг улам боловсронгуй болгох үүднээс 1973 оны Гэр бүлийн хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай болсон байна.[182]

Академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ "Монгол Улс социалист нийгмийн тогтолцооноос ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр гэр бүлийн эрх зүй дэх гэрлэлтийн институтэд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт гарсан юм. Социалист тогтолцооны үед гэр бүлийн эрх зүйг түгээмэл эрх зүйд хамааруулж, гэрлэлт, гэр бүлийн дотоод хэрэгт төрийн хөндлөнгийн оролцооны нөлөөлөл хүчтэй байсан бол одоо энэ эрх зүйг хувийн эрх зүйд хамааруулах болов"[183] хэмээн онцгойлон тэмдэглэжээ.

Хоёр.Гэр бүлийн насанд хүрээгүй хүний эд хөрөнгийн эрхийг хамгаалж буй өнөөгийн практик, тулгамдаж буй асуудал

<u>2.1.Гэр бүлийн насанд хүрээгүй гишүүний өмчлөх эрхийг хамгаалж буй шүүхийн практик</u>

Үндсэндээ гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэр бүлийн гишүүд хамтран эзэмшинэ. Хамтран өмчлөгч нь дундын өмчийг хуваагаагүй тохиолдолд бусдын эрхийг хязгаарлан, бие даасан хэсгийг эзэмших боломжгүй. Иймээс гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөнд гэр бүлийн гишүүнд ногдох хэсгийг дараах тохиолдолд тодорхойлно.

Үүнд: 1.Гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарахад ногдох хэсгийн талаар маргавал 2. гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хуваарьт эд хөрөнгө хүрэлцэхгүй бол 3. гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулбал 4. гэр бүлийн гишүүн нас барснаар өв нээгдсэн бол Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн

[182] А.Дугармаа., "Гэр бүлийн эрх зүй" УБ. 2016 он 32 дахь тал
[183] С.Нарангэрэл "Монгол Улсын эрх зүйн тогтолцооны удиртгал" УБ. 2003 он 116 дахь тал

хэмжээ нь насанд хүрээгүй хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна. Гэрлэлт цуцалсан буюу гэрлэлтийг хүчингүйд тооцсоноос гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг харгалзан шүүх өөрөөр тогтоож болох ч дээрхээс бусад гэр бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болгоход тусалсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно. Харин гэр бүлийн гишүүн цэргийн жинхэнэ алба хаах, сургуульд суралцах удаан хугацаагаар өвчлөх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бүрэлдэхэд хөдөлмөрөөрөө буюу хөрөнгөөрөө оролцож чадаагүй тохиолдолд дээрх хэсэгт хамаарахгүй юм.

Гэр бүлийн гишүүдийн хамтран олсон, эсхүл гэр бүлийн гишүүний хэн нэгний хүлээх үүргийн дагуу олсон ашиг орлогыг гэр бүлийн хэрэгцээнд ашигласан нь нотлогдсон бол гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болох бөгөөд уг эд хөрөнгө хүрэлцэхгүй бол гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгөөс гаргуулна. Харин бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс, олсон ашиг орлогоо гэр бүлийн бусад гишүүдийн хуваарьт эд хөрөнгөнд, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгөнд шилжүүлсэн нь нотлогдсон бол тэр хэмжээгээр уг эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно. Гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгөтэй холбоотой маргааныг шүүх шийдвэрлэнэ.

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэрлэгчдийн хэн нэгний буюу гэр бүлийн насанд хүрсэн бусад гишүүний шаардлагаар гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэлт цуцалсны дараа, эсхүл гэр бүлийн гишүүн хэн нэгний нь хуваарьт эд хөрөнгө төлбөр гаргуулахад хүрэлцэхгүй бол нэхэмжлэгчийн шаардлагаар мөн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө харилцан тохиролцох журмаар хуваах болно. Маргаан гарсан тохиолдолд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хэсгийг шүүх тогтоох бөгөөд энэ нөхцөлд гэр бүлийн гишүүний хэнд нь ямар хөрөнгө шилжихийг тодорхойлж аль нэг гишүүнд шилжүүлсэн хөрөнгийн үнэ нь түүнд ногдох хэсгээс давсан бол үнийн зөрүүг бусдад нь олгож болно. Гэр бүлийн нэг буюу хэд хэдэн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарвал хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгээ авах боловч гэр бүлийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах хөрөнгийг авах эрхгүй. Ногдох хэсгийг эд хөрөнгөөр өгөх боломжгүй бол үнийг нь төлнө. Жишээ нь: А нь өөрийн гэр бүлийн хамт Булган аймагт мал аж ахуй эрхэлдэг. А-ийн эцэг, эх Дарханд амьдардаг. Тэд охин А-даа хувцасны шинэ шүүгээ бэлэглэжээ. Хуучин шүүгээ нь эвдэрсэн аж. 15 Энд хэдийгээр А-д бэлэглэсэн ч шүүгээ нь гэр бүлийн нийтийн хэрэгцээнд зориулагдсан болохоор дундын өмчид хамаарагдана.

2.2. Гэр бүлийн насанд хүрээгүй гишүүний хамтран өмчлөх дундын өмчөөс ногдох хэсэг тодорхойлоход тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам

Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах гол бичиг баримт нь Монгол улсын Үндсэн Хуулийн 5 дугаар зүйлд[184] “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” Уг заалтаас улбаалан Иргэний хуулийн 99 дүгээр зүйлд Монгол улсад нийтийн болон хувийн өмч байна. Мөн хуулийн 99.3 дугаар зүйлд хувийн өмч нь иргэний болон дундын хэлбэртэй байхаар заасан бөгөөд мөн хуулийн 125 дугаар зүйлд гэр бүлийн хөрөнгийн эрх түүний зохицуулалтыг тусгаж өгсөн. Гэр бүлийн хөрөнгийн харилцааг шууд утгаараа 1-рт гэрлэгчид гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөтэй холбоотой харилцаа 2-рт гэр бүлийн гишүүдийн хоорондох тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаа гэж үзэж болохоор бөгөөд эхний ангиллыг дотор нь: 1-т гэр бүлийн

[184] Дундын өмчлөлийн эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа УБ. 2016 он

гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө; 2-т гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө гэж хуваан үзэж болох юм.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийг гэр бүлийн гишүүн бүр захиран зарцуулах адил тэгш эрхтэй байх ба гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгөө дур мэдэн бусдад шилжүүлсэн, олсон ашиг орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан зэрэг үр дагаврыг гаргахгүй байх ёстой. Хэрэв дээрх үйл ажиллагаа нь тогтоогдсон тохиолдолд эрх нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй. Гэр бүлийн гишүүний өмчөө захиран зарцуулах эрх нь түүний хувийн эрх бөгөөд гэр бүлийн дундын өмчтэй холбоотой гэрээ хэлцэл нь энэхүү хувийн эрхээ өөрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа явдал юм. Энэхүү гэрээ хэлцэл нь гэр бүлийн дундын эд хөрөнгийг хөндөх ч гэр бүлийн гишүүдэд шууд нөлөө үзүүлэхгүй. Гэр бүлийн эд хөрөнгийг захиран зарцуулж байгаа гэр бүлийн гишүүн нь өөрийн нэрийн өмнөөс хийсэн гэрээ, хэлцэлтэй холбоотой үүсэх маргааныг гуравдагч этгээдтэй хэлэлцэнэ. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна. Ийнхүү зөвшөөрөл авч байгаа нь гэр бүлийн амьжиргааны баталгаа болох үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалах, алдагдахаас сэргийлэхэд чиглэгдэж байна. Хэрвээ зөвшөөрлийг аваагүй худалдсан бол тухайн гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус болно.

Иргэний хуулийн 129.2 дэх хэсэгт[185] зааснаар Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна гэж заасны дагуу тэд эд хөрөнгөөс адил хэмжээгээр шаардах эрхтэй байна. Мөн Иргэний хуулийн 129.2 дэхь хэсэгт заасны дагуу тэд эд хөрөнгөөс адил хэмжээний ногдох хэсгийг шаардах эрхтэй боловч мөн хуулийн 129.4 дэхь хэсэгт зааснаар хөдөлмөрийн оролцоог харгалзан гэр бүлийн гишүүдэд хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгийг багасгах эсвэл олгохгүй байж болно. Гэрлэгсэд хөдөлмөр эрхэлж байсан тул дээрх зохицуулалт тэдэнд хамаарахгүй мөн хөдөлмөрийн чадваргүй аав болон бага насны хүүхдэд үйлчлэхгүй бөгөөд Иргэний хуулийн 129.2 дэх хэсэгт зааснаар “Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна гэж заасан тул хамтран өмчлөх дундын хөрөнгөөс шаардах эрхтэй байна харин ах нь хөдөлмөрийн чадвартай боловч гэр бүлийн орлогыг бүрдүүлэхэд ямар нэгэн байдлаар оролцоогүй тул түүнд ногдох хэсгийг олгохгүй. Иймд гэр бүлийн 4 гишүүн адил хэмжээний ногдох хэсгийг олж авах эрхтэй байна. Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.4 дэх хэсэгт ”Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгийг гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө гэнэ” гэсэн заалт нь зөвхөн гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийг зохицуулж байгаа юм. Мэдээж гэрлэгчид, гэр бүлийн гишүүний аль нэг нь тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхтэй гэж үзэж байгаа бол өмчлөгчөөр бүртгүүлэхийг шүүхээс шаардах нь ойлгомжтой юм.

Дүгнэлт

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө гэж хуульд заасны дагуу гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгийг хэлнэ. Гэр бүлийн хөрөнгө нь гэр бүлийн зорилго, гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн нэгдмэл хэрэгцээ ашиг сонирхолд тулгуурлан, түүнийг хангах зорилготой.

Гэр бүлийн амьжиргааг баталгаажуулах үүднээс гэр бүлийн хамтран өмчлөх дундаа хөрөнгийг бүрдүүлнэ. Гэр бүлийн нэг гишүүний эрх бусад хамтран өмчлөгч гишүүдийн эрхээр хязгаарлагдах юм. Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын

[185] Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль УБ. 1999 он

эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна. Гэрлэлт цуцалсан буюу гэрлэлтийг хүчингүйд тооцсоноос гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг харгалзан шүүх өөрөөр тогтоож болох ч дээрхээс бусад гэр бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болгоход тусалсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно.

Гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмчийн харилцаанд насанд хүрээгүй хүн гэр бүлийн бусад гишүүдийн адил эрх эдэлнэ.

Ном зүй

Нэг.Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Иргэний хууль УБ. 2002
- Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль УБ. 1999

Хоёр.Ном сурах бичиг, гарын авлага

- А.Дугармаа. “Гэр бүлийн эрх зүй”. УБ., 2016
- С.Нарангэрэл. “Монгол Улсын эрх зүйн тогтолцооны удиртгал”. УБ., 2003
- ГТХАН, Хууль зүйн үндэсний төв. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. ерөнхий анги. УБ., 2002
- Дундын өмчлөлийн эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа УБ. 2016

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Б.Алтанцэцэг
ДХИС-ийн магистрант

Товч агуулга. Сүүлийн 5 жилд Монгол Улсын иргэдийн фэйсбүүк хэрэглээ эрс нэмэгдэж, Фэйсбүүк компаниас гаргасан "Хамрагдах интернетийн индекс-2018" судалгааны хэрэглээ гэсэн үзүүлэлтээр Монгол Улс Ази тивд нэгдүгээрт, дэлхийд 10 дугаарт бичигдэж байна.[186] Энэхүү өгүүлэлд фэйсбүүк ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалган шийдвэрлэхэд тулгамдаж байгаа асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулсан.

Түлхүүр үг. Залилах гэмт хэрэг, фэйсбүүк, цахим орчин, хэрэглэгч, цахим гэмт хэрэг, конвенц.

Удиртгал

Монгол Улсын иргэд Трояны довтолгоо, salami халдлага, и-мэйлийн бөмбөгдөлт, цахим залилан, DOS халдлага, мэдээллийн хулгай, системийг эвдлэх, хакердах зэрэг цахим гэмт хэргийн хохирогч болох нь нэмэгдсээр байна. Иргэдийн хамгийн хэрэглэж байгаа сошиал медиа бол фэйсбүүк юм.

Монгол Улсад фэйсбүүк цахим хэрэглээ нэмэгдсэнээр цахим гэмт хэргийн төрлөөс фэйсбүүк хэрэглэгчдийн хаяг руу төрөл бүрийн пишинг сайт илгээж мэдээлэл хулгайлах, эсхүл боломжит хувилбаруудаар нэвтрэх оролдлого хийх /dictionary attack/, нэвтрэлт амжилттай болсон тохиолдолд бүртгэлтэй найз нөхдөөс нь мөнгө зээлэх, эсхүл интернет банкны эрхээ түр хэрэглүүлээч, барьцаагүй хөрөнгөгүй зээл, хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлнэ зэргээр залилж мөнгө авдаг гэмт хэрэг нь сүүлийн үед хамгийн түгээмэл үйлдэгдэж байгаа, хохирлын хувьд харьцангуй өндөрт тооцогдож байна. Энэхүү илтгэлээрээ Монгол Улс дахь фэйсбүүк ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн нөхцөл байдал, мөрдөн шалгахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг судлахад оршино.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан...” үйлдлийг залилах гэмт хэрэгт тооцдог. Залилах гэмт хэрэг гэдэг нь иргэдийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхэд халдсан, нийгэмд аюултай, Эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдлийн цогц гэж ойлгож болно. Залилах гэмт хэрэг нь хамгийн түгээмэл үйлдэгддэг өмчийн эсрэг гэмт үйлдлийн төрөлд хамаардаг. Иргэдийн цахим хэрэглээ үүсэж, хөгжихөөс өмнө баримт бичиг хуурамчаар үйлдэх, гэрээгээр халхавчлан залилах, итгэл эвдэх гэх зэрэг уламжлалт үйлдлийн аргаар залилах гэмт хэргийг гэмт этгээдүүд үйлддэг байсан бол сүүлийн жилүүдэд цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргийн төрөл бүрийн үйлдлийн аргаар иргэдийг залилж байна. Үүний дотор хамгийн түгээмэл дэлгэрч байгаа арга бол иргэдийг фэйсбүүк цахим хэрэгслээр залилж байна.

Монгол Улсаас сошиалд идэвхтэй хэрэглэгчид 2.200.000 хүрээд байна. Хэрэглэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр фэйсбүүкийг ашиглан үйлдэгдэх гэмт хэрэг нэмэгдэж, цахим орчинд залилах гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалган шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

---

[186] “Хамрагдах интернетийн индекс-2018" судалгаа

Манай улсад 2017-2021 оны 09 сарын байдлаар бүртгэгдсэн нийт залилах гэмт хэргийг цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн залилах гэмт хэрэгтэй харьцуулан авч үзье:[187]



Монгол улсад фэйсбүүк ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн судалгааг сүүлийн 4 жилээр авч үзье:



Улсын хэмжээнд фэйсбүүк цахим хэрэгсэл ашиглан 2017 онд 106 , 2018 онд 245, 2019 онд 575, 2020 онд 671[188] залилах гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2019 оноос эхлэн фэйсбүүк цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэрэг эрс нэмэгдэж байгааг харуулж байна.

Нийслэл хотод фэйсбүүк цахим хэрэгсэл ашиглан 2017 онд 85 , 2018 онд 207, 2019 онд 432, 2020 онд 464[189] залилах гэмт хэрэг бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн фэйсбүүк цахим хэрэгсэл ашиглан залилсан хэргийн 74.3 хувийг эзэлж байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд фэйсбүүк цахим хэрэгслээр залилуулсан үйлдлийн аргыг цахим хэрэгсэл ашиглаж болон бусад гэсэн төрлийг бүртгэлд оруулан бүртгэсэн байна. Хамгийн ихээр үйлдэгдэж байгаа фэйсбүүк цахим хэрэгслээр залилуулсан гэмт хэргийн албан ёсны статистик мэдээ гардаггүй байна.

[187] Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн сан.
[188] Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн сан.
[189] Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн сан.

Цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэрэг ихэвчлэн фэйсбүүк, мэйл хаягаар нэвтэрч хүний нэр барин мөнгө залилсан үйлдлүүд байна. Цахим залилангийн үйлдэл нь хэлбэрийн хувьд цахим шуудангийн луйвар, романс луйвар, зээл олгох, банкны залилан, үнэгүй бараа өгөх, мөнгө гуйх зэргээр үйлдэгджээ. Тодруулбал:

Цахим шуудангийн луйвар: - Манай улсын гадаад худалдаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд харилцагч талаас ирсэн цахим шууданд төлбөрийн данс солигдсон, өөрчлөгдсөн үндэслэлээр өөр дансанд төлбөрийг шилжүүлэхийг хүссэн цахим шуудан хүлээж авдаг ба тус шилжүүлгийг хийснээр цахим шуудангийн луйврын хохирогчид болдог.

Романс луйвар. Интернет орчинд харилцаа тогтоон хүний итгэлийг олж аван улмаар үүнийгээ ашиглан залилангийн гэмт хэрэг үйлдэхийг романс луйвар гэж ойлгож болно.

Зээл олгох. Цахим шуудан болон олон нийтийн сүлжээ сайтуудаар маш бага хүүтэй барьцаагүй, баталгаатай зээл гэх утгатай захидал болон нийтлэлүүд нийтлэгддэг. Үүний дагуу хэн нэгэн холбогдоход гэмт этгээд та эхлээд авах гэж байгаа зээлийнхээ тодорхой хувийг шимтгэлд төлөх ёстой, дараа нь та татвараа төлөх ёстой гэх нэрийдлээр луйврын гэмт хэргийг үйлддэг байна.

Банкны залилан. Таны имэйл хаягт банкны албан ёсны мэт хуурамч имэйл хаяг ирэх ба танаас банкны мэдээлэл асууж, баталгаажуулахыг шаарддаг. Банк хэзээ ч таны хувийн мэдээллийг асууж имэйл явуулдаггүй. Харин гэмт этгээд таны хувийн мэдээллийг өөрийн болгосноор дурын гэмт хэргээ үйлдэх нөхцөл боломж нь бүрдсэн байдаг.

Үнэгүй бараа. Гэмт этгээдүүд онлайнаар олон улсад нэр хүндтэй хүмүүс болон байгууллагын нэрийг барьж та азтан боллоо, та үнэгүй авах боломжтой гэх утга бүхий имэйлийг таны имэйл рүү явуулна. Улмаар та хожсон эсвэл үнэгүй авах боломжтой бараагаа авахын тулд таны кредит карт, гэрийн хаяг болон бусад мэдээллийг асуух болно. Хэрэв та өөрийн мэдээллээ өгсөн тохиолдолд дансан дахь мөнгөө алдах эрсдэлтэй.

Мөнгө гуйх. Онлайнаар таны танилын хаягаас эсвэл таны танилын хаягтай төсөөтэй хуурамч хаягаас танруу яаралтай мөнгө зээлээч, өнөөдөр орой эсвэл маргааш өглөө өгнө, хүүтэй нь хамт өгнө гэж урьдчилан бэлтгэсэн дансанд хохирогчоос мөнгийг нь залилж авдаг байна. Дээрх гэмт хэргүүдээс иргэдийн фэйсбүүк хаягийн нэвтрэх нэр, нууц үгийг авах, таах зэргээр хууль бусаар нэвтэрч ойр дотны хүн, найз нөхөд рүү нь эзэмшигчийн өмнөөс чат бичиж мөнгө залилаж байгаа хэрэг ихэвчлэн үйлдэгдсээр байна.[190]

Монгол Улсад бүртгэгдсэн залилах хэргүүдээс жишээ авч үзвэл:

Жишээ-1: Монгол Улсын иргэн С-тай 2019 оны 01 сард фэйсбүүк цахим хэрэгслээр АНУ-д амьдардаг иргэн өөрийгөө армид удирдах албан тушаалтан хийдэг хэмээн танилцуулж удаан хугацааны турш онлайнаар харилцаж Монгол Улсад очиж хамт амьдарна хэмээн итгүүлдэг. Гэмт этгээд аль нэг гадаад улсын дансанд гацсан их хэмжээний мөнгөө Монгол Улс руу гуйвуулахад гарах зардал, шимтгэл гэх нэрийдлээр гадаад данс руу 8,000-9,000 ам.доллар шилжүүлэн авч залилсан.

Жишээ-2: Монгол Улсын иргэн Э.О нь 2019 оны 08 сарын 25-ны өдрөөс эхлэн өөрийн фэйсбүүк цахим хэрэгслээр “F” гэх хэрэглэгчтэй харилцаж тухайн хэрэглэгчээс “*Олон улсын хүүгүй зээл олгодог байгууллага”* зээл авах хүсэлт, нөхцөлийг санал болгож, та зээл авахад урьдчилгаа 500 ам.долларыг манай байгууллага руу шилжүүлснээр зээлийн 10.000 ам.долларыг таны данс руу шилжүүлэх болно гэх нөхцөлийг тавьсаар хохирогчоос 8 удаагын үйлдлээр нийт 9978 ам.доллар буюу 22.601.400 төгрөгийг Франц улсын Парис хот, Бенин улсууд руу мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ашиглан шилжүүлэн авсан.

---

[190] ЦЕГ-ын МДДШУА, “Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа”, УБ., 2020 он.

Жишээ-3: БНСУ-д оршин суух Монгол Улсын иргэн Д нь 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр 8.000.000 вонийг төгрөг болгон Монгол Улсруу шилжүүлэхээр фэйсбүүк цахим хаягаар зарын дагуу “Z K” гэх хэрэглэгчтэй харилцан тохиролцож мөнгөө шилжүүлэн авч чадалгүй залилуулсан.

Дээрх хэргүүдийг үйлдсэн фэйсбүүк хэрэглэгчийг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлэх техникийн боломж, фэйсбүүк компанитай хамтын ажиллагаа манай улсад дутмаг байгаа тул энэ төрлийн хэрэг илрүүлэх шийдвэрлэх боломжгүй нөхцөлд байна. Учир нь Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2018 онд АНУ-ын Фэйсбүүк компаний төлөөлөгч нартай цахим хурал зохион байгуулж хурлын үр дүнд “Фэйсбүүк компаниас хамтын ажиллагааны хүрээнд “терроризм”, “хүний амь нас хохирох нөхцөл байдал бий болсон”, “хүүхдийн садар самуун”, “секс сүрдүүлэг” гэсэн 4 төрлийн хэрэг дээр мэдээллийг хойшлуулшгүйгээр прокурорын зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл гаргуулан авах”[191] хамтын ажиллагааг хэлэлцэн тохиролцсон байна.

Олон улсад цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн хэрхэн хуульчилсан байдлыг авч үзвэл:

Европын зөвлөлийн сайд нарын хорооны 109 дүгээр чуулганаас 2001 оны 11 дүгээр сарын 23-нд Будапешт хотноо баталсан, 2004 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон *“Кибер гэмт хэргийн тухай”* конвенцийн хоёр дугаар бүлэгт Үндэсний хэмжээнд авах арга хэмжээг тусгасан байдаг. Тус бүлгийн нэгдүгээр хэсэгт Эрүүгийн нэгдмэл хуулийн тухай хуульчилсан байна. Үүнийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгтэй харьцуулан авч үзье.

Д/д	Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 2 дугаар бүлэг, 1 дэх хэсгийн 8 дугаар зүйл. **Компьютер ашиглан залилан үйлдэх:** [192]	Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйл. Залилах:[193]
1	Энэхүү конвенцийн оролцогч талууд хууль батлах, шаардлагатай бусад арга хэмжээ авах замаар эрхгүйгээр, санаатайгаар бусдын эд хөрөнгөд хохирол учруулах зорилготой дор дурдсан үйлдэлд дотоодын хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ: а.компьютерийн өгөгдлийг шинээр нэмэх, засах, устгах, нуух; б.**өөрийн буюу бусдад эдийн засгийн ашиг, давуу тал бий болгох, залилан хийх** эсвэл **залилан мэхлэх зорилгоор компьютерийн сүлжээний үйл ажиллагаанд саад хийх.**	1.Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, **цахим хэрэгсэл ашиглаж**, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол. дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Судалгаанаас үзэхэд, олон улсад **өөрийн буюу бусдад эдийн засгийн ашиг, давуу тал бий болгох, залилан хийх эсвэл залилан мэхлэх зорилгоор компьютерийн сүлжээний үйл ажиллагаанд саад хийх** үйлдлийг цахим гэмт хэргийн төрөлд оруулдаг байна. Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт Кибер гэмт хэргийн

[191] Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс Фэйсбүүк компанитай зохион байгуулсан хурлаас гарсан шийдвэр.
[192] https://www.coe.int/ /Budapest Convention on Cybercrime in Mongolian language/
[193] Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он.

тухай конвенцийн 8 дугаар зүйлд заасан Компьютер ашиглан залилан үйлдэх үйлдлийг хуульчлаагүй байна. Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг "Залилах" гэмт хэргийн үйлдлийн аргад **"цахим хэрэгсэл ашиглаж"** гэж тусгасан нь дутагдалтай байна**.** Иймд цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргийг Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хуульчлан оруулж тусгай алба буюу Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст харьяалуулан мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Дүгнэлт

Мэдээллийн технологи хөгжихийн зэрэгцээ кибер гэмт хэрэг даган өсөж, илүү нарийн төвөгтэй, шинэ төрлүүдтэй хувирч байна. 2002 оны 09 сараас дэлхийн нийтээр хэрэглэх болсон фэйсбүүк цахим хуудас хэрэгчдийн тоо Монгол улсад сүүлийн 5 жилд эрс нэмэгдэж хэрэглээгээрээ Ази тивд нэгт бичигдэж байна. Аливаа зүйлийн хэрэглээ нэмэгдэхийн хирээр сөрөг зүйл гарч ирдэг тул фэйсбүүк хэрэглээ нэмэгдэхийн хирээр хэрэглэгчдийн аюулгүй байдал халдах, хууль бус халдлага нэмэгдэж байна.

Манай улсад бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын арга, гэрээ, хэлцлээр халхавчлан залилах гэмт хэрэг түгээмэл үйлдэгдэж байсан бол 2019 оноос цахим хэрэгслээр залилуулах иргэдийн тоо эрс нэмэгдэж байна. Цахим залилан дундаа фэйсбүүк цахим хэрэгсэл ашиглаж "зээл, хөрөнгө оруулалт санал болгох, хэрэглэгчийн хаягийг судлан ганц бие эмэгтэйчүүдийг онцлон харилцаа тогтоох, хуурамч хаяг үүсгэн валютын арилжаа, үнэгүй бараа илгээх, мөнгө гуйх" гэх мэт үйлдлийн аргаар иргэдийг залилах гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байгаа нь анхаарах асуудал болж байна. Дээрх хуурамч Фэйсбүүк хаяг нээн иргэдийг залилсан хэрэгт фэйсбүүк хэрэглэгчийг илрүүлж чадахгүйгээс энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа удааширч, зогсонг байдалд байна. Учир нь манай улс Фэйсбүүк компаниас 4 төрлийн хэрэг дээр хойшлуулашгүй ажиллагаагаар мэдээлэл гаргуулан авч хамтран ажиллаж байгаа нь дутагдалтай.

Олон улсад компьютерийн өгөгдлийг шинээр нэмэх, засах, устгах, нуух компьютерийн сүлжээний үйл ажиллагаанд саад хийсэн үйлдлийг кибер буюу цахим гэмт хэргийн төрөлд оруулдаг байна. Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг "Залилах" гэмт хэргийн үйлдлийн аргад **"цахим хэрэгсэл ашиглаж"** гэж хуульчилсан нь дутагдалтай байна.

Санал

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэг 26.4 дүгээр зүйлд "Цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн залилах гэмт хэрэг" гэх зүйл заалтыг нэмэлтээр оруулах.
- Прокурорын байгууллагаас цахим орчинд залилуулсан хэргийн мөрдөн шалгах харьяаллыг Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс тогтоох
- Цагдаагийн байгууллагаас Фэйсбүүк компинад албан ёсны хүсэлт илгээж мэдээлэл авах хамтын ажиллагааны хүрээг нэмэгдүүлэх.
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн санд бүртгэгдсэн фэйсбүүк ашиглан залилах гэмт хэргийг ангилан бүртгэлд оруулах. Ингэснээр бусад төрлийн залилах хэргийн тоо мэдээнээс ялгагдан урьдчилан сэргийлэх ажил оновчтой хэрэгжинэ

Ном зүй

- Кибер гэмт хэргийн тухай. 2001 оны Будапештын конвенци
- Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он.

- Фэйсбүүк компаниас гаргасан “Хамрагдах интернетийн индекс-2018" судалгаа
- ЦЕГ-ын МДДШУА “Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа”, УБ., 2020 он.
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн сан.
- Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс Фэйсбүүк компанитай зохион байгуулсан хурлаас гарсан шийдвэр
- https://www.coe.int/ /Budapest Convention on Cybercrime in Mongolian language/

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАД НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Наранхүү
ЦЕГ-ын Интерполын үндэсний төв товчооны
ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Техник, технологийн хөгжил нь хүн амын бүтэц, хэрэглэгчийн зан үйлд нөлөөлж байгаа байдалд дүн шинжилгээ хийж, гэмт явдлын чиг хандлагыг тодорхойлж, санал боловсруулсан.

Түлхүүр үг. Хиймэл оюун ухаан, мэдээллийн аюулгүй байдал, дижитал шилжилт.

Шинэ мянганыхан буюу "Z" үеийнхэн одоогийн байдлаар дэлхийн хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа бол манай улсын хүн амын бүтцэд 46 хувь нь энэ үеийнхэн байна. Уг "Z" үеийнхэн амьдралаас яг юу хүсдэг өмнөх үеийнхнээсээ юугаараа ялгаатай болохыг одооноос эргэцүүлж эхлэх хэрэгтэй. Учир нь тэр эрх чөлөөг эрхэмлэгч, уйдамтгай хэв шинжийн хүн байх тул ажлаа ойрхон солих, мөн аливаад тайлбар тавьж, өөрийн итгэл үнэмшлээр хандах тул ойлголцол чухал болно. Өөрөөр хэлбэл, орчин үеийн удирдлагын менежментэд гарцаагүй авч үзэх, хэрхэн зохицон оршихын шинжлэх ухааны тайлбар хийгээд практик шатанд дүн шинжилгээ хийх замаар бодлогоо тодорхойлох шаардлагатай. Нэгэнт нөхцөл байдлын оршихуйн төлөв хамтын зарчимд үндэслэх учраас бидний тогтсон хандлагад реформист залуу үеийн үзүүлэх нөлөө ч их байх нь тодорхой гэж үзэж байна.

Хиймэл оюун ухаанд тулгуурласан цахим хувьсгал, цахим шилжилттэй холбоотойгоор уламжлалт үйлдвэрлэл, үйлчилгээ, хүний амьдралын хэв шинж бүхэлдээ хурдацтай өөрчлөгдөж байгаа үед эдгээр залуус өсөн дэвжиж хэрэглээ нь хүртэл ухаалаг болох нь ч гарцаагүй. Онолын хувьд дэвшигдэж байгаа дурдан буй нөхцөл байдлуудын харилцан хамаарал нь олон талт харилцаа гэдгийг бид анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, тэрхүү харилцаа нь зөвхөн захирах, захирагдах агуулгаас гадна, хүний суурь хэрэгцээний онолын бүхий л давхаргуудад хамаарна. Тэр дундаа эдийн засаг, эрх зүй, улс төр, этик, боловсрол, цахим орчин, оршин тогтнохуйн үзэл санаа, аюулгүй байдлын хийгээд сэтгэл ханамж, сэтгэц зан үйлийн өвөрмөц байдлыг тогтолцооных нь хүрээнд системтэй авч үзэхгүй бол аливаа нэг элементийг орхигдуулах нь явцдаа хүндрэл үүсгэж болох юм.

Үүнээс бидний анхаарал хандуулах нэг чиглэл нь зогсолтгүй өсөн нэмэгдэж буй үүрэн болон цахим орчны хэт өсөлт юм. Хүнийг нийгмийн амьтан мөн гэсэн нь түүний оршин тогтнохын оюун санааны хийгээд бие бялдарын хувьд хэн нэгнээс хамааралгүй байх боломжгүйг илтгэдэг. Үүнийг дараах байдлаар тайлбарлая. Үүнд:

- Хүний хэрэгцээний үе шатлалын онол нь өөрт буй дутуугаа нөхөх, эзэмших, өмчлөхийн байнгын ашиг сонирхлыг дагуулдаг. Энэ нь сэтгэл зүйн болон биологи, бие бялдрын хүсэл эрмэлзлээс хамаардаг. Тийм учраас бид ердийн харилцааны болон бусад харилцааны хэрэгслээр уг хүсэл эрмэлзэлээ хангадаг.
- Хүний хэрэгцээ хангагдахад дараагийн хэрэгцээнүүд үүснэ. Энэ нь илүү нарийн бүтэцтэй, төвөгтэй байдлыг дагуулна. Өөрөөр хэлбэл, өмч эзэмших, нэр алдарт дурлах, эрх мэдэлд тэмүүлэх, бэлгийн гаж болон бусад зан үйлд татагдах зэргээр хүн зөвхөн нийгмийн харилцааны явцад хангахаар байгааг анхаарах хэрэгтэй.
- Хүний хүсэл, ялангуяа шунал бүхий л зовлонгийн шалтгаан болно. Гэвч тэрхүү шуналаас тусдаа хүний оюун санаа орших нөхцөлгүйг хүн төрөлхтөний түүхийн олон мянган жилийн түүх гэрчилнэ.

Хэрэгцээнд үндэслэсэн интернэт болон үүрэн холбооны хэрэглэгчийн өсөлтийн мэдээллийг үзүүлбэл,

Эх сурвалж: Статистикийн нэгдсэн мэдээллийн сан /www.1212.mn/

Эндээс үзэхэд, интернет болон үүрэн холбооны хэрэглэгчийн тоо 2016-2019 онд тогтмол өссөн, 2020 онд тогтворжсон байна. Гэтэл 3 сая гаруйхан хүн амтай улсад маань жилдээ 2 сая гаруй ухаалаг гар утас борлуулагддаг, 2020 оны эцсийн байдлаар 3.4 сая ухаалаг утас, 2.3 сая 4G, 3.2 сая 3G хэрэглэгч, нийт 262.102 ТВ[194] дата хэрэглэж, ачаалал 80 хувь нэмэгдсэн. Энэ бол зөвхөн гар утас бөгөөд цаана нь ухаалаг зурагт, цахим тооцоолуур, бусад хэрэглээ бий. Энэ хэрэглээ, үйлчилгээ чухам нийгмийн аль хэсэгт хүрч, биднийг юу хүлээж байна вэ?

Энэ бол хэрэглээ болон хүн амын бүтцийн талаас нь харуулсан үзүүлэлт.

Улсын хэмжээний гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнээс үзэхэд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг” 3 төрлийн гэмт хэргийн гаралт өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал,

Статистикийн нэгдсэн мэдээллийн сан /www.1212.mn/

Энэ төрлийн гэмт хэрэг нь нийт бүртгэгдсэн хэрэгт 0.006 хувийг эзэлж, сүүлийн 5 жилийн хугацаанд 14.6 дахин өсчээ. Харин бусад тодорхой төрлийн гэмт хэргийг цахим үйлдлийн аргаар үйлдсэн байдлыг авч үзэхэд:

Д/д	Төрөл	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт
1	Залилах	17	69	136	590	641	1281	2734
2	Цахим мэдээлэлд хууль бусаар халдах			39	43	53	145	280
3	Гүтгэх	16	5	11				32
4	Доромжлох	7	12	4				23
5	Хувь хүний нууцад халдах				14	7	8	29

[194] https://dashboard.cita.gov.mn/

6	Компьютерийн мэдээллийг хууль бусаар олж авах	9	5	3				17
7	Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах				5	7	4	16
8	Компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх	4	3	2				9
9	Заналхийлэх					7	18	25
10	Хувь хүний нууцыг задруулах				5	1	2	8
11	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших					4	17	21
12	Нянтай программ зохион бүтээх, ашиглах, тараах	2	1					3
13	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих				2	1	1	4
14	Мөнгө угаах					3	1	4
15	Садар самууныг сурталчлах	2						2
16	Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах	2						2
17	Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах					2	3	5
18	Хүчиндэх					2	6	8
19	Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох					2	5	7
20	Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх					2	5	7
21	Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих		1					1
22	Компьютерийн мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, борлуулах		1				2	3
23	Биеэ үнэлэхэд бусдыг татан оролуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах	1						1
24	Хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших	1						1
25	Бэлгийн мөлжлөг					1		1

26	Хүн худалдаалах					1		1
27	Ялгаварлан гадуурхах					1		1
28	Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах					1		1
29	Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах					1		1
30	Худал мэдээлэл тараах						173	173
31	Хулгайлах						67	67
32	Мөрийтэй тоглоом зохион байгуулах						18	18
33	Хөрөнгө завших						13	13
34	Бусад						26	26
	Нийт	**61**	**97**	**195**	**659**	**737**	**1795**	**3544**

Цахим үйлдлийн аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2015 оноос хойш 29.4 дахин өссөн нь Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан 3 зүйл гэмт хэргээр цахим гэмт хэргийг төсөөлөх нь өрөөсгөл бөгөөд бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлийг цахим хэрэгслийг ашиглан үйлдэх боломж байгааг илтгэж байна.

Дэлхийн бодлогод нөлөө бүхий улс орнууд энэхүү үйл явдлыг хэрхэн авч үзэж, түүнтэй тэмцэх бодлого боловсруулж буй нь манай улсын хувьд эерэг, сөргөөр хэрхэн нөлөөлж болохыг судалж, дижитал шилжилтэд хууль сахиулах байгууллага бэлэн байх ёстой.

Энэ шилжилт хүн амын насны бүтцээс шалтгаалан огцом хийгдэхийг үгүйсгэхгүй тул бид маш хурдан бэлтгэлээ хангах нь зүйтэй. Түүнчлэн, мэдээллийн аюулгүй байдал нь бидний дижитал шилжилтийн үйл явцыг эрсдэлгүй гүйцэтгэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүйг тодорхойлох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн загварт суурилж өөрийн улсын хэв шинжид тохируулсан загварыг бий болгох нь тулгамдаж буй асуудал юм.

Дүгнэлт

Гэмт явдал нь шинжлэх ухаан, техник, технологийн дэвшил, түүнд суурилсан нийгмийн хөгжил, хүн амын бүтэцтэй холбоотойгоор богино хугацаанд хувьсан өөрчлөгдөх чиг хандлагатай байна.

Ном зүй

Нэг. Хууль, тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
- Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Харилцаа холбооны тухай // Төрийн мэдээлэл. УБ., 2001. №43
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай //Төрийн мэдээлэл. УБ., 2011. №26

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

- С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургааль/. УБ., 2009
- Б.Хишигтогтох, Л.Цогтбаяр, Д.Сумъяацэрэн. “Цахим мэдээллийн орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс”. сурах бичиг. УБ., 2015

Гурав.Цахим эх сурвалж

- http://www.isd.gov.mn/

- https://ncsc.gov.mn/
- https://www.1212.mn//
- https://dashboard.cita.gov.mn/
- https://www.marshallcenter.org